

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ



# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот  
2024 он

ННА 66  
ДАА 320  
Г 94

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Эмхэтгэсэн: Хүний эрхийн Үндэсний Комисс  
Хэвлэлийн эхийг: А.Дүүрэнжаргал  
Хавтасны дизайнер: Ш.Гантуул  
Цаасны хэмжээ: 70x100/16  
Хэвлэлийн хуудас: 14.6 х.х  
Хэвлэсэн он: 2024 он  
Хэвлэлийн "Соёмбо Принтинг" ХХК-д хэвлэв.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

Тайлангийн агуулга, арга зүй, зөвлөмж нь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон холбогдох байгууллагуудыг төлөөлж эсвэл тэдгээрийн үзэл санааг илэрхийлээгүй болно.

**ISBN 978-9919-9007-6-2**

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

## АГУУЛГЫН ТОВЬЁГ

<b>Өмнөх үг.....</b>	<b>4</b>
<b>1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн 7 дугаар бүлэг</b>	
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шийдэл .....</b>	<b>5</b>
Танилцуулга .....	7
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн оролцоо.....	10
Эрх зүй, институтийн хүчин зүйлс .....	13
Эдийн засгийн хүчин зүйлс .....	20
Нийгэм, соёлын хүчин зүйлс.....	22
Хувь хүний хүчин зүйлс.....	25
Дүгнэлт.....	32
САНАЛ .....	34
<b>2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг үнэлэх судалгааны тайлан.....</b>	<b>35</b>
Танилцуулга .....	36
Бүлэг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн талаарх онолын суурь үзэл баримтлал судлагдсан байдлын судалгаа .....	40
Бүлэг 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн судалгаа .....	56
Бүлэг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийн талаарх олон нийтийн хандлагын талаарх судалгаа .....	128
Бүлэг 4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийн талаарх хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн зохицуулалт.....	135
Судалгаа, дүн шинжилгээний нэгдсэн дүгнэлт.....	153
Санал, зөвлөмж.....	161
Товчилсон үгийн жагсаалт.....	163
Ашигласан материал.....	164
Хүснэгтийн жагсаалт .....	171
Зургийн жагсаалт.....	172

## ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх судалгааг эрхэм танд толилуулж байна. Уг судалгааг КОЙКА олон улсын байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр, ХЭҮК-оос удирдаж, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, судлаач Г.Туяагэрэл, “Тэгш нийгэм холбоо” ТББ-ын тэргүүн Л.Энхбуянт, “Түгээмэл хөгжил” бие даан амьдрах төвийн гадаад харилцааны ажилтан, судлаач Н.Тамирхүү нар гүйцэтгэн явууллаа. Судалгааны гол үр дүнд тулгуурлан, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шийдэл” бүлгийг боловсруулан тусгаж, холбогдох саналыг УИХ-д хүргүүлсэн болно. Илтгэлийн бүлгийг энэхүү товхимолд мөн эмхэтгэн орууллаа.

Судалгааны урьдчилсан үр дүнг ХЭҮК-оос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулсан “Хүний эрхийн Үндэсний форум-2023”-д танилцуулсан. ХЭҮК-ын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцгээ, Судалгаа дүн шинжилгээ хариуцсан референт Н.Золжаргал, Италийн АИФО төрийн бус байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Д.Тулгамаа нар судалгааны тайланг сайжруулахад зөвлөж, энэхүү эмхэтгэлийг эрхлэн хэвлүүллээ. Судалгааны ажилд оролцсон, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн байгууллага, судлаачид, хүмүүст талархал илэрхийлье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэм, улс төрийн үйл хэрэгт идэвхтэй оролцох нь тэдний эрх, эрх чөлөө “цаасан дээрх уриа тунхаг” төдий нөхцөл байдлыг гэтлэх бодитой арга зам юм. Идэвхтэй оролцоог дэмжих оновчтой бодлогыг тодорхойлох үндэс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн идэвхгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг танин мэдэж, бодлогын дарааллыг тогтоох билээ. Энэхүү судалгаа ямар нэг онцгой нөхцөл байдлыг илрүүлж, түүнийг шийдэх шидэт арга замыг санал болгоогүй боловч яагаад төрийн бодлого бодит байдалд нийцэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах бодлого, эрх зүй, эдийн засгийн арга хэмжээ үр өгөөж муутай байгааг олж харахад, өөрөөр хэлбэл, бодлогын харааг хурцлахад хувь нэмэр оруулна гэж итгэж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн,  
хууль зүйн ухааны доктор  
Г.Нарантуяа

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ  
ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 23 ДАХЬ  
ИЛТГЭЛИЙН ДОЛДУГААР БҮЛЭГ**

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН  
УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД  
НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС, ШИЙДЭЛ**

*“Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”*

**(Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалт)**

*“...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”*

**(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт)**

*“...Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах үүрэг хүлээнэ:*

☞ ① *Бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох...”*

**(Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 29 дүгээр зүйлээс)**

*“Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.”*

*“Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.”*

**(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлээс)**

## 7.1 ТАНИЛЦУУЛГА

НҮБ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц батлахтай холбоотой 2000-аад оны дунд үеэс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаа олон улсын хэмжээнд идэвхэжсэн нь Монгол Улсад ч үлэмж нөлөө үзүүлсэн юм.<sup>1</sup>

ХЭҮК-оос хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрийн бодлого эрүүл мэнд, нийгмийн хамгааллын явцуу хүрээнд биш, хүн бүрийн ижил үнэ цэнийг хүндэтгэн зөвшөөрч, нийгмийн амьдрал, үйл хэрэгт тэгш дүүрэн оролцуулах өргөн хүрээнд боловсруулах нь зохистой болохыг сануулж, холбогдох хууль тогтоомж, бодлого, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлснээ 2007 онд УИХ-д илтгэж байсан.<sup>2</sup> Өнгөрсөн хугацаанд Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн шинэтгэл явуулж, асуудал эрхэлсэн бүтэц, байгууллагыг үүсгэж, зохих үр дүнд хүрчээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгайлан зохицуулсан үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг гурван удаа батлан хэрэгжүүлж,<sup>3</sup> 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан.<sup>4</sup> Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд 2012 онд асуудал эрхэлсэн хэлтэс бий болж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус үндэсний, дэд, салбар зөвлөлүүдийг 2016 оноос ажиллуулж, 2018 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ)-ыг байгуулжээ.<sup>5</sup> Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн болон эрүүл мэндийн сэргээн засах тусламж үйлчилгээг орон нутагтаа авах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдийг Дархан-Уул, Дундговь, Дорнод, Ховд, Хөвсгөл аймгуудад байгуулж, 2023 оноос үйл ажиллагааг эхлүүлжээ.

Макро төвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд эерэг өөрчлөлт гарсан байна. 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогоор манай

<sup>1</sup> Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг 2008 онд соёрхон баталсан. Энэ үеэс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн нийгмийн бодлого эрүүл мэнд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, боловсролын гэх мэт салбарын явцуу хүрээнд биш, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцуулах өргөн хүрээтэй болж, үйл ажиллагаа эрчимжсэн.

<sup>2</sup> ХЭҮК, "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл", 2007 он, 20-58 дахь тал.

<sup>3</sup> 2006 онд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих үндэсний хөтөлбөр"; "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр" (2006-2012); 2013 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"; 2017 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр" (2018-2022)-ийг тус тус батлан хэрэгжүүлжээ.

<sup>4</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/11711>

<sup>5</sup> ХБХХЕГ нь бүтэц зохион байгуулалтын хувьд Тамгын газар, Бодлогын хэрэгжилтийн газар, Хөгжил нийгмийн оролцооны газар, Хяналт шинжилгээ-үнэлгээний газар гэсэн дөрвөн газартай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн гурван харьяа төвтэй. Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвд Протез, ортопедын үйлдвэр, Сэргээн засах төв эмнэлэг болон Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль багтдаг. <http://www.gadpwd.gov.mn/index.php/page/639>



улсад 10 болон түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 78.0 хувь нь ямар нэг төвшний боловсрол эзэмшсэн байсан бол 2020 оны тооллогын дүнгээр 86.1 болж, 8.1 хувиар өсжээ.<sup>6</sup> 2010 онд улсын хэмжээнд хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 18.2 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан бол 2020 онд 29.2 хувь болсон байна.<sup>7</sup> Хүн амыг орон сууцаар хангах хөтөлбөр,<sup>8</sup> цахим технологийн хөгжил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч эерэг нөлөөлжээ.<sup>9</sup> Гэвч сүүлийн арван жилийн хугацаанд гарсан эдгээр өөрчлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний зэрэгтэй амьдрах, эрх, эрх чөлөөгөө бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх Монгол Улсын олон улсын гэрээний амлалт, хууль тогтоомжийн зарчим, бодлогын зорилго, зорилтууд, байгуулсан бүтэц, зарцуулсан төсөвтэй харьцуулахад чамлалттай юм.

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, нийгмийн хөгжлийн энэхүү зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг санал болгоно. Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу УИХ-ын гишүүдийн тоо 126 болж, 78 гишүүн иргэдийг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн сонгох холимог тогтолцоог хуульчилсан нь хууль тогтоох байгууллагын нийгмийг төлөөлөх чадавх, ардчилсан шинжийг нэмэгдүүлэхэд түлхэц болох боломжтой. Эмэгтэйчүүд, ахмадууд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үүднээс 2023 онд шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуульд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэр дэвшүүлсэн улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалт оржээ.<sup>10</sup> Гэвч Монгол Улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол нийгмээс хамгийн их тусгаарлагдсан бүлэг бөгөөд энэ байдал олон хүчин зүйлээс улбаатай.

Илтгэлийн энэ бүлэг хоёр үндсэн зорилготой. Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгамдсан

<sup>6</sup> ҮСХ, "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого – Хөгжлийн бэрхшээл", 2021 он, 43 дахь тал

<sup>7</sup> "2010 онд хөгжлийн бэрхшээлтэй цалин хөлстэй ажиллагч хөдөлмөр эрхэлдэг хүн амын 35.7 хувийг эзэлж байсан бол 2020 онд 43.7 хувь болж 8.0 нэгж хувиар өсжээ. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эзлэх хувь 46.7 болж 5.0 нэгж хувиар өссөн байна." ҮСХ, "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого – Хөгжлийн бэрхшээл", 2021 он, 49, 50 дахь тал.

<sup>8</sup> "2020 оны Хүн ам, орон сууцны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй 94.0 мянган өрхийн 44.0 хувь нь гэрт, 54.9 хувь нь байшинд амьдардаг бол 1.1 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад гэрт амьдардаг өрх 6.8 нэгж хувиар, бусад сууцанд амьдардаг өрх 0.2 нэгж хувиар доогуур, байшинд амьдардаг өрхийн хувь 7.0 нэгж хувиар өндөр байна. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 19.2 хувийг эзэлж байгаа нь 2010 оноос 5.3 нэгж хувиар нэмэгдсэн байна. Сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин өмнөх тооллогын дүнгээс 2.4 нэгж хувиар, бие даасан тохилог сууцных 0.2 нэгж хувиар тус тус өссөн байна." ҮСХ, "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого – Хөгжлийн бэрхшээл", 2021 он, 68 дахь тал.

<sup>9</sup> Энэ бүлгийн 7.6.4 дэх хэсгийг үзнэ үү.

<sup>10</sup> Улс төрийн намын тухай хууль, 27 дугаар зүйлийн 27.7 дахь заалт.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>

асуудал, авах арга хэмжээг санал болгоно. Хоёрдугаарт, олон талт хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн эрх зүй, институтийн арга хэмжээ хангалтгүй, харин тухайн асуудалд нөлөөлж буй хүчин зүйлсийг цогцоор тодорхойлж, бодлогын эрэмбийг тогтоох нь үр дүнтэй болохыг хууль тогтоогч, бодлого боловсруулагчдад сануулахыг зорилоо. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх асуудлаар дамжуулан хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл, донтолт, амиа хорлолт зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсэж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогыг хуулийн хэрэгжилт, төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн үүднээс биш, тухайн асуудалд нөлөөлөх хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглүүлж байж, бодитой, далайцтай эерэг өөрчлөлт гарах юм.

ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 8.0 хувь нь сонгох, сонгогдох эрхээ хангалттай, 33.5 хувь нь дунд төвшинд эдэлж байна гэж, харин 58.5 хувь нь эдэлж чадахгүй байгаа гэж үнэлжээ.<sup>11</sup> Сонгуульд санал өгөх, улс төрийн байр сууриа илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг улс төрийн биет оролцооны хувьд судалгаанд оролцогчдын 12.0 хувь нь маш идэвхтэй, 40.5 хувь нь дундаж байхад 17.6 хувь нь огт идэвхгүй, 15.0 орчим хувь нь сул идэвхтэй байна.<sup>12</sup> Нийгмийн харилцаанд бие даан оролцох хүсэл, улс төрийн эрхээ хэрэгжүүлэхэд 18-35 насны оролцогчид бусад насны бүлгүүдтэй харьцуулахад илүү идэвхтэй, 56-аас дээш насны оролцогчид идэвх муутай байв. Судалгааны бүх асуулгын хүрээнд хүйсийн ялгаатай байдал огт ажиглагдаагүй нь онцлог байлаа.<sup>13</sup>

Энэ бүлгийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Шийдвэр гаргах төвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн дэмжлэгээр ХЭҮК-оос удирдаж явуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгаанд үндэслэн,<sup>14</sup> бусад байгууллагуудаас 2020-2023 онд явуулсан тус бүлгийн асуудалд холбогдох судалгааны үр дүнг харьцуулан дүгнэж, Комиссоос 2023 онд хийсэн хяналт шалгалтын үр дүнд цугларсан мэдээллээр баяжуулж, боловсрууллаа.

<sup>11</sup> ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 126 дахь тал (Тайлбар: Тус судалгааны тайлан нь хэвлэгдээгүй бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар эцсийн хувилбараас нь эшлэсэн болно. Судалгааны тайлан хэвлэгдэхэд эшлэсэн хуудасны дугаар өөрчлөгдөх боломжтой.)

<sup>12</sup> Мөн тэнд, 100 дахь тал.

<sup>13</sup> Мөн тэнд, 67, 71, 75, 80, 85, 111, 116, 132 дахь тал.

<sup>14</sup> Монгол Улсын нутаг дэвсгэрийг үндсэн 5 кластерт хувааж, кластер тус бүрээс 1-2 аймгийг сонгож, санамсаргүй түүврийн аргаар судалгааг хийсэн. Судалгаанд нийт 698 хөгжлийн бэрхшээлтэй хүн, олон нийтийн хандлагын судалгаанд нийт 1291 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцжээ. Тоон болон чанарын судалгааны аргаар мэдээллийг цуглуулсан.

## 7.2 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СОНГУУЛИЙН ОРОЛЦОО

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд санал өгсөн байдал харьцангуй өндөр байна. Тухайлбал, ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85.7 хувь нь 2020 оны УИХ-ын, 84.1 хувь нь 2020 оны орон нутгийн сонгуульд, 84.7 хувь нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгсөн гэжээ.<sup>15</sup> Судалгаанд оролцогчдын 14-16 хувь нь аль ч сонгуульд санал өгөөгүй бөгөөд сонгуулийн байранд ганцаараа очих боломжгүй, хэн нэгний тусламж дэмжлэгийг авах шаардлагатай болдог, санал авах байр хол, хүртээмжгүй, улс төрийн сонгуулийн талаар ойлголт муу, мэдээлэл хязгаарлагдмал, нийгмийн оролцооны идэвх сул байдгаас сонгуульд оролцоогүй болохоо илэрхийлжээ.<sup>16</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуульд харьцангуй өндөр оролцоотой санал өгч байгаа ч саналаа чөлөөтэй, нууцаар гаргаж байгаа эсэх нь анхаарах удаах асуудал юм. Асран хамгаалагч, гэр бүлийн гишүүд зэрэг хэн нэгний нөлөөллөөс ангид өөрийн хүсэл зориг, шийдвэрээр саналаа өгч байж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрх жинхэнэ утгаараа хангагдана. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд санал өгсөн 59 хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс тусалж буй этгээдийн нөлөөгүйгээр саналаа бие даан гаргасан эсэхийг тандахад 90 хувь нь чөлөөтэй гаргаагүй гэжээ.<sup>17</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуульд нэрээ дэвшүүлэх, сонгогдох байдал маш бага байна. УИХ болон орон нутгийн долоон удаагийн сонгуульд нийт найман хөгжлийн бэрхшээлтэй хүн нэр дэвшиж, өрсөлджээ. Тэдгээр хүмүүсийн долоо нь хөдөлгөөний бэрхшээлтэй, нэг нь сонсголын бэрхшээлтэй бөгөөд хүйсийн хувьд долоон эрэгтэй, нэг эмэгтэй нэр дэвшигч байна. УИХ-ын гишүүнээр хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгогдож байгаагүй бөгөөд харин Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэг хүн Төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

<sup>15</sup> ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 110 дахь тал.

<sup>16</sup> Мөн тэнд, 110 дахь тал.

<sup>17</sup> СЕХ-нд хөндлөнгийн ажиглагчаар ажиллахаар албан ёсоор бүртгүүлж, бэлтгэгдсэн ажиглагчдаас 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үеийн ажиглагчаар ажиллуулж, мөн 59 хөгжлийн бэрхшээлтэй сонгогчоос саналаа хэрхэн өгсөн тухай асуумж авчээ. Монголын багш, эцэг эхийн холбоо ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийн хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн ажиглалтын тайлан”, 2021 он, 23 дахь тал.

**Хүснэгт 7.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд нэр дэвшсэн байдал**

Д/д	Төрөл	Он	Тойрог	Нам, эвсэл, бие даасан байдал
1	Улсын Их Хурал	2004	63 дугаар тойрог	Ардчилсан нам
			Баянгол дүүрэг	Иргэний зориг ногоон нам
		2008	Сонгинохайрхан дүүрэг	Бие даагч
		2012	Баянзүрх дүүрэг	Бие даагч
		2016	Сэлэнгэ аймаг	Тусгаар тогтнол эв нэгдлийн нам
		2020	Хэнтий аймаг	Шинэ нам
		2020	Баянзүрх дүүрэг	Ардчилсан нам
2	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2016, 2020	Чингэлтэй дүүрэг, 16 дугаар тойрог	Ардчилсан нам

Сонгуульд нэрээ дэвшүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогдох эрхээ эдлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (ХБХЭК)-ыг бодитоор хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, баталгаажуулахад санал бодлоо хэлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, нийгмийн уламжлалт хандлагыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулах зорилгоор сонгуульд өрсөлдөх шийдвэр гаргасан байна.<sup>18</sup> Тэдний хувьд хандив цуглуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон биечлэн сурталчилгаа хийх, материал хэвлүүлэх тараах, сонгуулийн штабын байрны болон ухуулагчдын зардлаа төлөх зэрэг санхүүгийн асуудал хамгийн хүнд, дохионы хэлмэрчгүй ажилласан, уулзалтын байрны хүртээмжгүй байдал, сонгогчдод өөрийгөө таниулахад бэрхшээл учирсан гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн оролцоог нийгмийн бүлгийн ерөнхий хэв шинжтэй уялдуулан ойлговол зохино. Шинжлэх Ухааны Академи (ШУА)-ийн Философийн хүрээлэнгээс явуулсан судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс хамгийн тусгаарлагдсан бүлэг гэж дүгнэжээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн тусгаарлагдмал байдал 42.9 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд хөгжлийн бэрхшээл, хүнд өвчтэй өрхийн гишүүнтэй бүлгээс 23.3 пунктээр, бусад бүлгээс 28.1 пунктээр илүү байна гэжээ.<sup>19</sup> Мөн өрхөд хүнд өвчтэй, асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүн байх нь тухайн өрхийн, гэр бүлийн бусад гишүүдийн нийгмээс тусгаарлагдах эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг уг судалгаа илтгэжээ.

<sup>18</sup> Энэ үзүүлэлт нь улс төрийн намууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйл ажиллагаандаа идэвхтэй оролцуулахыг дэмжих бодлого байхгүйг илтгэж байна. Энэ талаарх дэлгэрэнгүй дүгнэлтийг судалгааны 153-154 дэх хэсгээс үзнэ үү. ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 149 дэх тал.

<sup>19</sup> Ж.Батжаргал, О.Баасантогтох, Д.Номун-Эрдэнэ, "Нийгмээс тусгаарлагдах эрсдэлт зарим бүлгүүд: шалтгаан, асуудал бэрхшээл", ШУА-ийн Философийн хүрээлэн, "Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар", 2023 он, 275-277 дахь тал

## Тохиолдол 7.1

... Хомсдмол байдлын шинжээр нь авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй бүлэг эдийн засаг, нийгмийн оролцоогоор гачигдмал, нийгмийн үйлчилгээ хомсдолтой байна. Тодруулбал, тэд бусад хүмүүсээс эдийн засгийн нөөцөөр 2 дахин их хомсдож, 3 дахин илүү гачигдаж байгаа бол нийгмийн оролцооны хувьд 3 дахин илүү гачигдмал байна. Түүнчлэн нийгмийн үйлчилгээгээр хомсдох нь бусад хүмүүсээс 20 пунктээр илүү байв.

(Судалгааны тайлангаас)<sup>20</sup>

2023 оны 08 дугаар сарын 17, 18-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн НҮБ-ын хороо ХБХЭК-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын хоёр болон гуравдугаар тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргасан.<sup>21</sup> Тус Хорооноос Монгол Улсын Засгийн газарт агуулгын хувьд давхардсан байдлаар 35 арга хэмжээ авахыг зөвлөсний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх талаар дараах асуудлыг зөвлөжээ.

ХБХЭХ-ноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмж (CRPD/C/MNG/CO/2-3)

58.(а) Конвенцод нийцүүлэн Иргэний хууль, сонгуулийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, сонсголын бэрхшээлтэй, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй, хараа-сонсголгүй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд зэрэг төлөөлөл багатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх тусгай арга хэмжээ авах, хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг, ялангуяа жижиг намаас нэр дэвшиж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих;

(б) Сонгуулийн болон санал өгөх журам, цахим болон хэвлэмэл материалыг энгийн илэрхийлэл, хялбар уншигдах хэлбэрээр боловсруулж, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн ашиглах боломжийг бүрдүүлэх;

Монгол Улсын иргэдийн сонгуулийн оролцоо сүүлийн жилүүдэд буурч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн идэвхэд мөн нөлөөлөх макро чиг хандлага юм. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц эхэн үедээ харьцангуй өндөр байсан бол УИХ-ын 2020 оны сонгуулиар ирц 73.6 хувь болж анхны УИХ-ын сонгуулийн ирцээс 22 хувиар, Ерөнхийлөгчийн 2021 сонгуулийн ирц 59.3 хувь болж анхны Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцээс 33.4 хувиар буурчээ.<sup>22</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг эрх зүй ба институтийн, эдийн засгийн, нийгэм соёлын, хувь хүний гэсэн дөрвөн хүрээнд ангилж, удаах хэсгүүдэд танилцууллаа.

<sup>20</sup> Мөн тэнд, 276 дахь тал

<sup>21</sup> ХБХЭХ-оос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмж, (2023 оны 10 дугаар сарын 05) [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CRPD%2FC%2FMNG%2FCO%2F2-3&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CRPD%2FC%2FMNG%2FCO%2F2-3&Lang=en) цахим хуудсанд 2024 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар хандсан.

<sup>22</sup> . О.Баасантогтох "Нийгмийн институтчилал ба тусгаарлагдмал байдал", ШУА-ийн Философийн хүрээлэн, "Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар", 2023 он, 214 дэх тал

## 7.3 ЭРХ ЗҮЙ, ИНСТИТУТИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

### 7.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог дэмжих эрх зүйн зохицуулалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг Монгол Улс харьцангуй боломжийн төвшинд хуульчлан баталгаажуулжээ. Монгол Улс 2009 онд нэгдэн орсон ХБХЭК-ын үзэл санаа, ялангуяа улс төрийн оролцооны талаарх Конвенцын 29 дүгээр зүйлд нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6-д “Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байхыг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.” гээд 30 дугаар зүйлийн “Улс төрийн үйл ажиллагаанд оролцох” хэсгийн 30.1-д “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.”, 30.2-т “Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.”, 30.3-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.” 30.4-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн,<sup>23</sup> УИХ-ын,<sup>24</sup> Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал (АНСДИТХ)-ын сонгуулийн<sup>25</sup> тухай хуулиудад эрх зүйн бүрэн чадамжтай хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд, ялгаварлалгүйгээр сонгох эрхийн үндсэн дээр нууцаар, хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, сонгуульд санал өгөх боломжоор хангагдах, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар, эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч зөөврийн хайрцгаар сонгуульд саналаа өгөх эрхийг хангахаар заажээ. ХБХЭК-ын 29 дүгээр зүйлийн 29(а)(iii) хэсэгт шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй сонгогч санал өгөхдөө туслалцаа авах хүнийг өөрөө сонгох боломж бүрдүүлэхээр заасан нь Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн агуулгаар тусгагдаагүй байна.

<sup>23</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 5 дугаар зүйлийн 5.7, 58 дугаар зүйлийн 58.1.1, 62 дугаар зүйлийн 62.9.

<sup>24</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4, 63 дугаар зүйлийн 63.1.1, 66 дугаар зүйлийн 66.9.

<sup>25</sup> АНСДИТХ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, дугаар зүйлийн 5.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.5.9.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн,<sup>26</sup> УИХ-ын,<sup>27</sup> АНСДИТХ-ын<sup>28</sup> сонгуулийн тухай хуулиудын санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэх, тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байхаар заасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.27, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.27-д “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна.” гэж заасан. Харин АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуульд мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэхийг үүрэгжүүлсэн зохицуулалт байхгүй байна.

Сонгуулийн байгууламж, үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх талаарх хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс Сонгуулийн Ерөнхий Хороо холбогдох журмуудыг батлан гаргажээ.<sup>29</sup>

Монгол Улсын хууль тогтоох байгууллагын нийгмийг төлөөлөх байдлыг дээшлүүлэх, зарим бүлгийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгогдох эрхийг хангах зохицуулалт 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намын тухай хуульд тусгагдсан нь бодитой алхам болжээ.<sup>30</sup> Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх тухай тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана.” гэж заагаад 26 дугаар зүйлийн 26.3.1-т намд жил бүр төрөөс олгож буй төсвийн 20-иос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх үүргийг хуульчилжээ. Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д “Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг

<sup>26</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.4, 56.5.

<sup>27</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3, 62.4, 62.5.

<sup>28</sup> АНСДИТХ-ын 61 дүгээр зүйлийн 61.3, 61.4, 61.5.

<sup>29</sup> Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 23 дугаар тогтоолоор “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага”, “Санал авах байр бэлтгэх заавар”-ыг тус тус шинэчлэн баталж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага, MNS 6055:2009” стандарт, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, MNS 6056:2009” стандартыг тус тус мөрдлөг болгохыг журамд тусгажээ.

<sup>30</sup> Улс төрийн намын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>

тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.” гэж заасан нь намууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс нэр дэвшүүлэхийг дэмжихэд чиглэсэн тодорхой хэмжээний санхүүгийн хөшүүрэг болжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу УИХ-ын сонгуулийн холимог тогтолцоог хуульчилсан нь нийгмийн бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц болох юм. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүн төрийн захиргааны байгууллагад ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн захиргааны албан хаагчид тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хоёр дахин бууруулсан зохицуулалтыг 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Төрийн албаны тухай хуульд нэмэлтээр тусгасан байна.<sup>31</sup> Үүний хамт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болно.”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар энэ хуулийн 40.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилсон бол байгууллага дэд даргатай байна. Энэ тохиолдолд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг хамаарахгүй.” гэсэн зохицуулалтыг тус тус тусгаж, баталсан байна.<sup>32</sup>

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хуульчлан баталгаажуулсан боловч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бий болгосон байгууллага, албан тушаалтан, бусад этгээдэд хүлээлгэх хариуцлага, хариуцлага тооцох механизмыг тодорхой хуульчилж чадаагүй нь эрх зүйн зохицуулалтын гол хийдэл болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчихөд хариуцлага тооцох нэг заалт Зөрчлийн тухай хуульд бий бөгөөд энэ зөрчилд оногдуулах торгуулийн дээд хэмжээг хүнийг нэг мянган нэгж, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тогтоосон нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй зохицуулалт болж чадахгүй байна. УИХ-д өргөн барьсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчилд хариуцлага тооцох заалт тусгагдаагүй. Харин Эрүүгийн хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүнд шууд хамаарах 7 заалт тусжээ.

<sup>31</sup> Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.

<sup>32</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5, 40.6.



ХБХЭК-ын 33 дугаар зүйлийн дагуу Монгол Улс уг конвенцын хэрэгжилтэд хяналт тавих механизмыг тогтоож албажуулах үүрэг хүлээсэн боловч өнөөг хүртэл энэ механизмыг бий болгоогүй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц  
33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих ажиллагаа

2. Оролцогч улсууд нь өөрсдийн эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмыг оролцуулан энэхүү конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах, томилох, бэхжүүлэх, тогтвортойгоор ажиллуулна. Ийм механизмыг байгуулахдаа оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авна.

3. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд ийнхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхийг хязгаарлах эрх зүйн зохицуулалт, үр дагаврыг хянан үзэх шаардлагатай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон иргэн сонгуульд оролцох эрхгүй ба эдгээр иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр хуульчилсан.<sup>33</sup> Сэтгэцийн өвчний улмаас хүнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцохыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх бөгөөд иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах хүсэлтийг тухайн иргэний гэр бүлийн гишүүн, эсхүл сонирхогч бусад этгээд, асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргадаг.<sup>34</sup> Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүний иргэний эрх зүйн чадамжийг гагцхүү шүүхийн шийдвэрээр хязгаарлах боловч уг хүсэлтийг гаргах нь сайн дурын шинжтэй, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй боловч эрх зүйн чадамжгүй гэж шүүхээр тогтоолгоогүй бол сонгуульд оролцох эсэх нь тодорхойгүй, үүний улмаас тухайн хүний сонгох эрх гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчийн дур зоргоор хязгаарлагдах эсхүл энэ эрхийг бусад хүн хэрэгжүүлэх боломжийг үүсгэж байна.

<sup>33</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 20 дугаар зүйлийн 20.6.1.

<sup>34</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.3, 141-144 дүгээр зүйл.

### **7.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог дэмжих байгууллагууд**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог дэмжих байгууллагуудад өргөн хүрээнд хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын болон Сонгуулийн ерөнхий хороо зэрэг төрийн байгууллагууд, ТББ-ууд, хувийн хэвшил орох боловч хуулийн дагуу тодорхой чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын үүрэг, оролцоог эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтээр дамжуулан дүгнэж буй тул энэ хэсэгт улс төрийн нам, ИНБ зэрэг сайн дурын, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг товч дүгнэлээ.

ХЭҮК-ын судалгаанд оролцогчдын 9.9 хувь нь улс төрийн намын гишүүн, 18.1 хувь нь ТББ, 11.2 хувь нь сайн дурын бүлэг, 7.6 хувь нь шашны байгууллагын гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон нийтийн үйл ажиллагаа, байгууллагад хамрагдах байдал бага байна.

#### **Улс төрийн намууд**

Улс төрийн намуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн идэвх, оролцоог дэмжиж бодлого, үйл ажиллагаа сул, энэ чиглэлд авсан цөөн эерэг арга хэмжээ нь удирдагчийн санаачилга шинжтэй, намын бодлогод тусгагдаагүй байна. Улсын дээд шүүхэд 2024 оны 3 дугаар сарын байдлаар 37 улс төрийн нам бүртгэлтэй байна.<sup>35</sup> Эдгээрээс УИХ-д суудалтай намууд болох МАН, АН, ХҮН намын хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцоо, сонгогдох эрхийг дэмжих талаарх бодлого, үйл ажиллагааг судалж үзэхэд, "... дээрх намууд жилийн төсөвтөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх хөрөнгө тусгаагүй нь өмнөх жилүүдэд энэ талаарх ажлууд дутмаг байсан эсвэл цаг үеийн шинжтэйгээр хэрэгждэг буюу тогтмол байгаагүйг харуулж байна." гэж дүгнэжээ.<sup>36</sup> МАН-аас 2024 оны УИХ-ын сонгуулийн жагсаалтын эхний тавд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нэр дэвшүүлэхээ мэдэгдсэн нь хамгийн бодитой дэмжих алхам байна. ХҮН нам гишүүдээ "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтад хамруулсан, нам нийгмийн бүх бүлгүүдийг төлөөлөх чадвартай байхад анхаардаг гэсэн бол АН тодорхой бодлого баримтлаагүй, арга хэмжээ аваагүй гэжээ.<sup>37</sup>

Намаас нэр дэвших нь санхүүгийн хувьд хязгаарлагдмал, мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулах туршлага нимгэн, нийгмийн харилцаа холбоо багатай хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд чухал дэмжлэг болдгийг судалгаанд

<sup>35</sup> <https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=69&pr=63&tp=list> цахим хуудсанд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хандсан.

<sup>36</sup> ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 148 дахь тал.

<sup>37</sup> Мөн тэнд, 148 дахь тал.

оролцогч тэмдэглэжээ. Гэвч тэдний туршлагаас нам дэмжиж нэр дэвшихийг санал болгосон, сөрөг хандлага мэдрээгүй боловч санхүүгийн дэмжлэг байгаагүй тул хамгийн том бэрхшээлийг ганцаараа үүрсэн гэжээ. Бие даан нэр дэвшигчийн хувьд хуулиар тогтоосон босго болох 801 дэмжигчийн гарын үсгийг цуглуулах томоохон бэрхшээл болжээ.

#### Тохиолдол 7.2

...Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд нэрээ дэвшүүлэхэд нам, эвслээс дэмжих, анхаарах асуудлын хувьд нам, эвслүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар мэдлэг ойлголтоо сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гишүүнээр элслүүлэх бодлоготой болох, энэ нь ардчиллын төлөөлөх зарчмыг, олон улсын гэрээг биелүүлэхэд чухал болохыг ойлгох, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай хуульд квот оруулах, ялангуяа иргэдийн хуралд 5-10 хувь хөгжлийн бэрхшээлтэй төлөөлөгч байх квот оруулах хэрэгтэй. Улс төрийн намууд хөгжлийн бэрхшээлтэй хүн нэр дэвшүүлж байгаа тохиолдолд хөрөнгө босгоход туслалцаа үзүүлэх, дохионы хэлмэрч, налуу зам зэрэг дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулахад анхаарах шаардлагатай гэжээ.

...ИЗНН-аас нэр дэвшихэд Сонгуулийн хороонд бүртгүүлэх, мөрийн хөтөлбөрөө боловсруулах бүх ажлыг нам нь хийж өгсөн, сурталчилгааны самбар, ухуулах байр гаргаж өгсөн. Сурталчилгаа хийх, өөрийгөө таниулах ажлыг өөрөө хийсэн. Намаас дэмжлэггүй тул санхүүгийн бэрхшээлтэй байсан.

...Хөгжлийн бэрхшээлтэй иргэн сонгуульд нэрээ дэвшүүлэхэд хувь хүний зүгээс анхаарах ямар асуудал байгаа талаар тодруулахад өөрийнхөө имижийг сайн бүрдүүлэх, өөрийн зорилгоо сонгогчдод сайн ойлгуулах чадвартай байх, сайн баг бүрдүүлэх, өөрийгөө хөгжүүлж олон талын мэдлэгтэй байх, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг ярихаас гадна ахмад настан, ядуу өрх, зорилтот бүлгийн асуудлыг цогцоор нь мөрийн хөтөлбөртөө тусгаж, сурталчилгаагаа хийх гэж ярьж байв.

(УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хийсэн ярилцлагаас)<sup>38</sup>

### Иргэний нийгмийн байгууллагууд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон нийтийн байгууллагад хамрагдсан байдлын талаарх дээрх судалгааны үр дүн хөгжлийн бэрхшээлтэй иргэд улс төрийн намаас илүү ИНБ-ын үйл ажиллагаанд хамрагдаж байгааг илтгэж байна. Судалгаанд оролцогчдын 28.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг хангахад хувь хүн өөрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар ажилладаг ИНБ-ын оролцоо чухал гэж үзжээ.<sup>39</sup> Гэвч ИНБ, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар ажилладаг ИНБ-ын тогтвортой ажиллах боломж хязгаарлагдмал байна.

<sup>38</sup> Мөн тэнд, 149-153 дахь тал.

<sup>39</sup> ХЗҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 120 дахь тал.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар ажилладаг гэх 600 гаруй ТББ бүртгэгдсэн байгаагаас 48 байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.<sup>40</sup> Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй ИНБ-уудын 12.5 хувь нь л зорилго чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Санхүүгийн бие даасан байдал хангагдаагүй нь ИНБ оршин тогтнох, идэвхтэй, үр дүнтэй ажиллахад учирч буй хамгийн том бэрхшээл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар ажилладаг ИНБ-уудад татварын хөнгөлөлт эдлэх, төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бий боловч ийм санхүүжилт багасах хандлагатай байна. Тухайлбал, Татварын ерөнхий газрын мэдээллээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн байгуулсан ТББ-д дэмжлэг үзүүлэх татвар төлөгчийн тоо 2022 онд өссөнийг эс тооцвол сүүлийн жилүүдэд дараалан буурсан, 2023 онд огцом буурсныг судлаач илтгэж байна.<sup>41</sup> Ихэнх ИНБ-ууд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, улс төрийн оролцоог дэмжих, улс төрд бэлтгэх чиглэлээр тогтвортой, тууштай ажилладаг ИНБ байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар ажилладаг зарим ИНБ-уудын төлөөллийг төрийн байгууллагуудын дэргэд байгуулсан зөвлөл, хороонд оруулах боловч бодитой, үр дүнтэй оролцоог хангаж чадахгүй байгааг судалгаа харуулжээ.<sup>42</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар ажилладаг ИНБ-уудын үйл ажиллагаа, засаглал, дотоод ардчилал, төлөвшил, нийгмийн үр нөлөөний үр дүнгийн талаар дагнасан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

<sup>40</sup> ХНХЯ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2020 он, 127-134 дэх тал. [hbi\\_nom2020.pdf \(mlsp.gov.mn\)](https://mlsp.gov.mn/hbi_nom2020.pdf)

<sup>41</sup> “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгааг улс төр судлаач, эрдэмтэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр ажилладаг ИНБ-ын шинжээчидтэй хамтран явуулсан. Судалгааны багт цугларсан мэдээлэл.

<sup>42</sup> Энэ илтгэлийн 5 дугаар бүлэг, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн 2 дугаар бүлгийн 2.4 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

## 7.4 ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Санхүүгийн хомсдол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог хязгаарлаж буй гурван гол хүчин зүйлийн нэг байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 34.9 хувийн өрхийн сарын орлого хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2023)-нээс доогуур буюу 500,000.00 төгрөг хүрэхгүй байна. Тэдний 42.6 хувь нь өрхийн орлогоо хэрэгцээндээ арай ядан хүргэдэг, 84.7 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авдаг, 23.8 хувьд авч буй халамж нь өрхийн орлогын тал хувийг, 16.0 хувь нь бүхэлдээ өрхийн орлогыг бүрдүүлж байна.<sup>43</sup>

### Хүснэгт 7.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сарын дундаж зарим зардал

Зардал (төрөл, төгрөгөөр)	Хоол хүнсний бүтээгдэхүүн	Боловсрол сургууль	Эрүүл мэнд, эмчилгээ
ХБИ-ий сарын дундаж зардал	387 000	188 000	230 600
Улсын дундаж	472 022	707 400	156 200
Зөрүү (Хувиар)	18 хувиар бага	73 хувиар бага	47 хувиар илүү

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд хамгийн бага зардал гаргаж, эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээнд орлогынхоо ихэнхийг зарцуулж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчид Монгол Улсын дундаж өрхөөс 47 хувиар их эрүүл мэндийн зардал гаргаж, боловсролд 73,0 хувиар бага зарцуулалт хийж байна. Хүнсний бүтээгдэхүүний зардал улсын дундажтай харьцуулахад 18 хувиар бага байна. Боловсролд зарцуулах төсөвгүй шахам байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан нийгмийн харилцаанд оролцох, бусадтай харилцах, бие даан шийдвэр гаргах чадвар эзэмшихэд маш том хязгаарлалт болж байна. Мөн судалгаанд оролцогчдын 28.3 хувь нь санхүүгээ өөрөө мэдэж, захиран зарцуулж үзээгүй гэжээ.

### Тохиолдол 7.3

...Нэг ба түүнээс дээш хүн нь хөгжлийн бэрхшээлтэй монгол өрхийн хувьд ядуурлын тохиолдол хөгжлийн бэрхшээлгүй өрхөөс хоёр дахин их байна. Хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн 36% нь ажилгүй байхад тухайн насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 70% нь ажил хөдөлмөр эрхлэхгүй байна. 15 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн үйл ажиллагааны түвшин 2014 онд 25.2 хувь байсан бол нийт хүн амын дунд 62.1 хувь байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын дундаж цалин нь нийт хүн амын дундаж цалингийн ердөө 50 хувь байна.

(Судалгааны тайлангаас)<sup>44</sup>

<sup>43</sup> ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 56-58 дахь тал.

<sup>44</sup> Ж.Батжаргал, О.Баасантогтох, Д.Номун-Эрдэнэ нар "Нийгмээс тусгаарлагдах эрсдэлт зарим бүлгүүд: шалтгаан, асуудал бэрхшээл", ШУА-ийн Философийн хүрээлэн, "Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар", 2023 он, 276 дахь тал

ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 62.0 хувь нь ямар нэг ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэжээ. Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох,<sup>45</sup> шинэ туршлага нэвтрүүлэх<sup>46</sup> зэрэг арга хэмжээ авч, ажлын байрны тоо нэмэгдсэн<sup>47</sup> талаар мэдээлж байгаа боловч эдгээр арга хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьжиргааг бодитоор дээшлүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл (өмнө хүчин төгөлдөр байсан хуулийн 111 дүгээр зүйл)-ийн дагуу өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, энэ үүргийг биелүүлээгүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлөх үүрэг хүлээдэг. ХНХЯ-ны хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа, нийгмийн даатгалын санд бүртгэлтэй, 25-аас дээш ажилтантай 6.5 мянган байгууллагаас судалгаанд хамрагдсан 3.2 мянган байгууллага 9.6 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7.2 мянга гаруй иргэн ажиллуулж байгаа нь хуулийн хэрэгжилт аж ахуйн нэгж, байгууллагад 61 хувь, төрийн байгууллагад 59 хувь байжээ.<sup>48</sup>

Монгол Улсад бүх төрлийн сонгуульд нэр дэвших зардал амьжиргааны төвшинтэй харьцуулахад маш өндөр байгаа нь эмэгтэйчүүд, залуус, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг хүч, нөлөө багатай нийгмийн бүлгүүд, цалин хөлсний орлогоор амьдардаг хүмүүсийн улс төрд идэвхтэй оролцоог хязгаарладаг үндсэн бэрхшээл юм.<sup>49</sup> Ийм нөхцөлд хөдөлмөр эрхлэх

<sup>45</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь Хөдөлмөрийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд, тэдгээрийг дагаж гарсан дүрэм, журам, хөтөлбөрөөр зохицуулагдаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой шинэ зохицуулалтуудыг тусгасан нь НҮБ-ын ХБХЭХ-оос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид нийцсэн.

<sup>46</sup> ХНХЯ ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг боловсруулж, нөлөөллийн ажилтан бэлтгэх, хүний нөөцийг хөгжүүлэх, ажил олгогчдын сүлжээтэй болох, ажлын байрны тохируулгатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгдөг ажлын байранд дадлагажуулагчийн механизмыг бий болгож байна.

<sup>47</sup> ХЭДС-ийн санхүүжилтээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2022 онд 9.5 тэрбум төгрөг зарцуулж, 1.2 мянга гаруй ажлын байр, 2023 онд 10.5 тэрбум төгрөг зарцуулж, 1.3 мянга гаруй ажлын байр бий болгосон талаар ХБХХЕГ-аас мэдээлжээ.

<sup>48</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, өмнө хүчин төгөлдөр байсан хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүйн төлбөрөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016 онд 349.5 сая төгрөгийг төвлөрүүлж байсан бол энэ хэмжээ жил бүр өсөж, 2021 онд 11.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Харин 2022 онд төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоосны дагуу тухайн онд 4.7 тэрбум, 2023 онд 6.9 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн талаарх ХНХЯ-ны мэдээлжээ.

<sup>49</sup> Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/12 дугаар тушаалаар 2024 оны УИХ-ын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын хэмжээг тойргоос хамаарч 894.8 саяас 1.5 тэрбум төгрөг байхаар баталжээ.

боломж хязгаарлагдмал, өрхийн орлого нь амьдралын наад захын хэрэгцээнд арай ядан хүрдэг ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд улс төрийн нам зэрэг институтийн дэмжлэггүйгээр улс төрийн идэвхтэй байх, сонгуульд өрсөлдөх боломж туйлын хязгаарлагдмал юм. Орлогын ядуурал нь Монгол Улсын нийт иргэдийн хувьд нийгмээс тусгаарлагдах тэргүүлэх хүчин зүйл болж байна.<sup>50</sup>

#### Тохиолдол 7.4

... УИХ 2004 оны сонгуульд нэр дэвшсэн, мөнгө босгоно гэж явж байсан боловч миний хүрээлэл тааруу мөнгөгүй хүмүүс байсан. Тэр үед намаас мөнгөгүй учир нэрээ тат гэсэн. Би нэрээ татаж, миний оронд дэвшсэн хүн УИХ-ын гишүүн болсон...

(Судалгаанд оролцогчийн ярилцлагаас)<sup>51</sup>

## 7.5 НИЙГЭМ, СОЁЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС

Нийгмийн биет байгууламж, дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан зорчих боломжийг бүрдүүлсэн эсэх, нийгмийн бусад гишүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрд оролцох боломж, чадавхыг хэрхэн үнэлж байгааг нийгэм, соёлын хүчин зүйлс гэж үзсэн болно.

### 7.5.1. Орчны хүртээмж

#### Ерөнхий нөхцөл байдал

Сонгуулийн байр, санал авах үйл явц хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй байсан ч нийгмийн биет байгууламж, дэд бүтэц, тээврийн хэрэгсэл, мэдээлэл хүртээмжгүй бол улс төрийн оролцоо хязгаарлагдах нь ойлгомжтой. Нийтийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчиход саадгүй болгох талаар 2006 оноос эхлэн хууль, бодлого, стандарт тогтоож, хэрэгжүүлсэн боловч дорвитой өөрчлөлт гараагүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогчдын 83.1 хувь нь Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад огт ээлгүй гэж үзсэн бөгөөд шалтгааныг тодруулахад 41.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад шаардлагатай дэд бүтэц байхгүй гэж хариулжээ.<sup>52</sup> Судалгаанд оролцогчдын

<sup>50</sup> “2022 оны байдлаар Монгол Улсад хүн амын 27.1 хувь буюу нийт хүн амын 914.2 мянга нь ядуу амьдарч байна. 2022 онд нэг хүнд ногдох сарын хэрэглээ үндэсний ядуурлын шугамаас доогуур буюу 418 090 төгрөгөөс доош бол ядуу гэж тооцогддог ажээ. Ядуурлын шугамнаас доогуур амьдарч буй иргэд амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байна гэсэн үг юм. Нийт ядуу хүн амын 37.0 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.” ҮСХ, Дэлхийн банк, “Ядуурлын дүр төрх” судалгааны танилцуулга, 2024 он. <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/75662406>

<sup>51</sup> ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 151 дэх тал.

<sup>52</sup> Мөн тэнд, 158 дахь тал.

45.1 хувь нь явган хүний замд, 48 хувь нь явган хүний замын гадаргуугийн материалд, 50.3 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд маш их сэтгэл ханамжгүй байдгаа илэрхийлсэн байна.<sup>53</sup>

2022 онд ХНХЯ, БХБЯ, ЗТХЯ, ЦХХХЯ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийтийн тээвэр, зам, замын байгууламж, бүх яамд, НЗДТГ, нийслэлийн 6 дүүргийн ЗДТГ-ын барилга байгууламж, цахим хуудасны хүртээмжтэй байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээг 53 шалгуур үзүүлэлтээр хийхэд шаардлага хангасан байгууллага байхгүй ба эдгээр яамдын барилгуудаас сайжруулах шаардлагатай нь 56 хувь, шаардлага хангаагүй 44 хувь, НЗДТГ, болон 6 дүүргийн ЗДТГ-ын барилгуудаас шаардлага хангасан байгууллага байхгүй. Харин сайжруулах шаардлагатай 66 хувь, шаардлага хангаагүй 34 хувь гэж дүгнэжээ.<sup>54</sup>

#### Тохиолдол 7.5

... Тэр автобуснууд зөвхөн хотын төвөөр явдаг, хотын зах руу явахгүй. Автобус чинь цагтайгаа уралдана. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэхийн тулд заавал карма луугаа орж брожуртай ижил төвшинд зогсож байж налуу замаа буулгах ёстой гээд аймаар цаг ордог учраас би нэг удаа сууж байхад ерөөсөө амар байгаагүй. Бараг л татаад орчих, үсрээд орчих, босож чадах уу гэж асуугаад байсан...

...Гэр хороололд гудамжаар тэргэнцэртэй явна гэдгийг та нар төсөөлөөд үзэх юм бол маш хэцүү шүү дээ. Өвөл дэгэн догонттой, нэг чулуун дээр очоод л дугуй гацчихна. Энэ бэрхшээлтэй байдлаасаа болоод олон зуун мундаг чадвартай залуучууд нийгэмд гарч хөдөлмөрлөж чадахгүй гэртээ байгаад байна...

(“Untold: Хүн бүрд хүртээмжтэй Монголыг бүтээх түүхүүд” ярилцлагаас <sup>55</sup>)

Барилга байгууламжийн хүртээмжтэй байдлын талаарх судалгаа, дүн шинжилгээ Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байна. Монгол Улсын иргэдийн нийгмээс тусгаарлагдсан байдал хотоос хөдөө уруу ихэсдэг, үүнд орон зай, зам, байгууламжийн хүртээмжгүй байдал нөлөөлдөг болохыг судалгаа анхааруулжээ.<sup>56</sup> Цаг уур, газар зүйн нөхцөл байдал нийгмийн тусгаарлалт, орчны хязгаарлалтад нэмэлт хүндрэл үүсгэж байна. Өвлийн улирал, төвөөс алслагдсан байдал нь нийгмээс тусгаарлагдахад шууд нөлөө үзүүлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч орчны хязгаарлалт ялгаатай. Хөдөлгөөний хязгаарлалтай хүмүүст нийтийн тээвэр, зам талбай, барилга байгууламж, харааны бэрхшээлтэй хүмүүст зорчих, бичмэл мэдээллийг олж

<sup>53</sup> Мөн тэнд, 98 дахь тал.

<sup>54</sup> ХНХЯ, “Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээний нэгдсэн тайлан”, 2022 он.

<sup>55</sup> Фридрих-Эбертийн сан, Бодлогын Инновацын хүрээлэн хамтарсан бүтээл, “Untold: Хүн бүрд хүртээмжтэй Монголыг бүтээх түүхүүд”, 2021 он, 14, 55 дахь тал

<sup>56</sup> Ц.Пүрэв, Ж.Батжаргал, “Нийгмээс тусгаарлагдах үйл явц: шинж онцлог, нөлөөлж буй хүчин зүйл”, ШУА-ийн Философийн хүрээлэн, “Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар”, 2023 он, 78-80 дахь тал



авах, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүстэй харилцахад хамгийн их бэрхшээл тулгардаг.

### **Сонгуулийн үйл явц, санал авах байрны хүртээмж**

ХЭҮК-оос УИХ-ын 2020 оны, Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал өгөх үйл явц хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй эсэхэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй гэж дүгнэсэн билээ.<sup>57</sup> Уг үнэлгээнд 2020 оны сонгуулийн үеэр нийслэлийн 6 дүүргийн 59, аймаг орон нутагт 93 нийт 152 санал авах байр, 2021 оны сонгуулийн үеэр Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргүүдээс 40 хэсгийн хороо, 18 аймгийн нийт 80 хэсгийн байр хамрагдсан. Санал авах байрууд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод зориулсан бүхээтэй боловч стандартад нийцэх эсэх нь тухайн санал авах байрны талбай, нөхцөлөөс хамааралтай байв. Цөөнгүй санал авах байр сургууль, цэцэрлэгийн барилгын хоёрдугаар давхарт байршсан бөгөөд тэргэнцэртэй сонгогчийг өргөж оруулна гэж Хэсгийн хорооны гишүүд тайлбарлаж байсан. Орон нутгийн санал авах байрны хүртээмж Улаанбаатар хотоос доогуур төвшинд байлаа. Үнэлгээнд хамрагдсан орон нутгийн хэсгийн хороодын ихэнх нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны хүртээмж ба MNS 6055:2009” стандартад нийцээгүй, санал бэлтгэх ширээний хаалт саналын нууцлалыг хамгаалахгүй төвшинд хэт нам, ширээ хоорондын зай хэт ойрхон байв.

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайл үсгийн хавтас, томруулдаг шил ихэнх санал авах байранд бэлтгэсэн байв. Харин сул хараатай иргэдэд зориулсан 16-аас доошгүй үсгийн фонтоор хэвлэсэн мэдээлэл аль ч байранд байгаагүй. Дохионы орчуулагч ажиллуулсан санал авах байр байгаагүй. Санал авах байрны ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тэмдэг, тэмдэглэгээг өөрсдөө бэлдэж байршуулсан бөгөөд зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж санал бэлтгэх бүхээг бэлтгээгүй, стандартын дагуу тэмдэг байршуулаагүй тохиолдол цөөнгүй байв.

### **7.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломж, чадавхын талаарх нийгмийн төсөөлөл**

Олон нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрд идэвхтэй оролцох чадвар, чадавхад ихэнхдээ эргэлзэж буй боловч энэ талаар хатуу тогтсон хандлага байхгүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн 63.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ойлгож туслахад бэлэн гэсэн хэдий ч 60.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд бие даан оролцож, нийгмийн гишүүдтэй зэрэгцэн ажиллаж амьдарч чадна гэдэгтэй

<sup>57</sup> ХЭҮК, Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн илтгэх хуудас, 2020 он. ХЭҮК, Зорилтот бүлгийн сонгогчдын сонгох эрхийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, мониторинг хийсэн илтгэх хуудас, 2021 он.

санал нийлэхгүй гэж үзжээ.<sup>58</sup> Мөн 56.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн удирдах албан тушаалтан болж бодлого боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжгүй гэж үзсэн байна. Тэдний 29.8 хувь нь 2024 оны УИХ-ын сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг дэмжиж санал өгнө гэж хариулсан байхад 19.4 хувь нь дэмжихгүй, 50.8 хувь нь одоогоор сайн хэлж мэдэхгүй гэжээ. ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс бүгд хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн гишүүнийхээ хувьд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх ёстой гэдэгтэй санал нийлж байгаагаа илэрхийлсэн байна.<sup>59</sup> Эдгээр үзүүлэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх нийгмийн хандлага тэдний улс төрийн идэвхтэй оролцоог их хэмжээгээр хязгаарлахгүй байж болохыг илтгэж байна.

Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн 59.4 хувь нь хөгжлийн бэрхшээл гэж юу болох талаар тодорхой ойлголтгүй гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмээс тусгаарлагдсан байдлыг илтгэж байна.<sup>60</sup>

## 7.6 ХУВЬ ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС


Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэм, улс төрийн амьдралд идэвхтэй оролцох, ялангуяа сонгуульд нэр дэвшихэд нөлөөлөх үндсэн хүчин зүйл бол хувь хүний боловсрол, чадавх юм. Энэ нэг талаас хувь хүний асуудал боловч төрийн үйлчилгээ, нийгмийн нөхцөл байдлын нөлөөллөөр хувь хүн, гэр бүл төлөвшдөг тул төрийн бодлогын асуудал болно. ХЭҮК-ын судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгогдох эрхийг хязгаарлаж буй хамгийн чухал хүчин зүйлс нь санхүүгийн байдал, хувь хүний хөгжил, нийгмийн харилцаанд бие даан оролцох дадал байна.

<sup>58</sup> ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 163 дахь тал.

<sup>59</sup> Мөн тэнд, 161 дэх тал.

<sup>60</sup> Мөн тэнд, 156 дахь тал.

Зураг 7.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс



### 7.6.1. Бие дааж шийдвэр гаргах, амьдрах дадал

ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үнэмлэхүй олонх нь амьдралын наад захын асуудлаар бие даан шийдвэр гаргаж, нийгмийн харилцаанд оролцохгүй байна. Тухайлбал, харааны бэрхшээлтэй иргэдийн 8.4 хувь, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 7.9 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 11.8 хувь, унаж татдаг хүмүүсийн 2.3 хувь, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын 5.5 хувь, оюуны хомсдолтой оролцогчдын 1.3 хувь нь л бие даан нийгмийн харилцаанд оролцдог гэжээ. Тэдний ахуйн хүрээнд бие даан хийж чаддаг үйлдэл нь нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээс харьцангуй олон байна. Судалгаанд оролцогчид ахуйн хүрээнд бие даан хийдэг үйлдлүүдээ дунджаар 4.3, нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээ 3.8 гэж үнэлжээ.<sup>61</sup> Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 хувь нь гэрээс гадуур ганцаараа явж чаддаг бол 42.0 хувь нь гэр бүлийн гишүүдийн тусламжтай гадуур явдаг, 2 хувь нь огт гэрээсээ гардаггүй байна.<sup>62</sup> Бие даан нийгмийн харилцаанд ороход улирлын шинж байдал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжгүй байдал, гэр бүл, нийгмийн гишүүдийн хандлага сөргөөр нөлөөлдөг гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцох байдал өвлийн улиралд 88 орчим хувиар хязгаарлагддаг байна.<sup>63</sup>

<sup>61</sup> "Судалгаанд оролцогчид ахуйн хүрээнд хийдэг үйлдлүүдээ бие дааж огт хийж чадахгүй бол 1, ихэнхдээ бие дааж хийж чаддаггүй бол 2, бусдын дэмжлэгийг хааяа авдаг бол 3, ихэнхдээ бие дааж хийдэг бол 4, ганцаараа бие дааж хийж чаддаг бол 5 оноо өгч үнэлсэн." ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 100 дахь тал.

<sup>62</sup> Мөн тэнд, 95, 96 дахь тал

<sup>63</sup> Мөн тэнд, 99 дэх тал.

## Тохиолдол 7.6

...Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийнхнээсээ 100 хувь хамааралтай болчихдог. Хоёрдугаарт, гэр бүлийнхэн хэт их хайрлах, хамгаалах сэтгэхүйгээр харж ханддаг учраас хөгжлийн бэрхшээлтэй хүн идэвхгүй, өөрийнхөө асуудлыг бусдад даатгасан иргэн болж хувирдаг юм байна...

(Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүний<sup>64</sup> ярилцлагаас.)

Өдрийг хэрхэн өнгөрүүлэх зэрэг амьдралын наад захын шийдвэрийг өөрөө гаргаж дадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тогтоосон хүний эрх, эрх чөлөөний баталгаа, сонгуулийн үйл ажиллагааны хүртээмжтэй байхаас үл шалтгаалан төрд төлөөлүүлэх улс төрчөө өөрийн хүсэл зоригоор сонгох, сонгуульд нэр дэвшиж, төрийн үйл хэрэгт шууд оролцох нь ихэнхдээ “холын” хэрэг юм. Сонгуульд саналаа өгөх, намд элсэх, улс төрийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг улс төрийн оролцооны хувьд 18-25 насны оролцогчдын 8.7 хувь, 26-35 насны оролцогчдын 10 хувь, 36-45 насны оролцогчдын 15.6 хувь, 46-65 насны 12.8 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 6.5 хувь нь л бие даан шийдвэр гаргаж байна.<sup>65</sup>

### 7.6.2. Өөрийн үнэлэмж, нийгэм, улс төрийн үйл хэрэгт оролцох эрмэлзэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, улс төрийн амьдралд идэвхтэй оролцох хүсэл эрмэлзэл харьцангуй өндөр байна. Тухайлбал, судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 39.8 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцож, шийдвэр гаргах бодлого төлөвлөх үйл явцад оролцохыг маш их хүсдэгээ илэрхийлжээ.<sup>66</sup> Харин 14.0 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцох ямар ч сонирхолгүй, 15.0 хувь нь энэ талаар идэвх, санаачлага гаргадаггүй гэсэн байна. Судалгаанд оролцогчдын 20.0 орчим хувь нь бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад оролцож чаддаггүй гэсэн нь бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санаа, бодол тодорхой хэмжээнд тусгагдаж байгааг илтгэх эерэг үзүүлэлт байна.

Судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийгөө бусдаас өөр ялгаатай гэж үзэх байдал (stigma) харьцангуй бага байж болохыг судалгааны үр дүн харуулж байна. Судалгаанд оролцогчдын 14.8 хувь нь бусдаас хамааралтай хэрэгцээнүүдээс болоод туйлддаг бол 3.9 хувь нь бусад хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнө хариуцлага хүлээсэн юм шиг харагддаг байдлаас

<sup>64</sup> Фридрих-Эбертийн сан, Бодлогын Инновацын хүрээлэн хамтарсан бүтээл, “Untold: Хүн бүрд хүртээмжтэй Монголыг бүтээх түүхүүд”, 2021 он, 43 дахь тал

<sup>65</sup> “18-25 насны оролцогчдын 33.7 хувь, 26-35 насны оролцогчдын 40 хувь, 36-45 насны оролцогчдын 46 хувь, 46-65 насны оролцогчдын 42 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 13 хувь нь бие даан нийгмийн харилцаанд орохыг маш ихээр хүсдэг болохоо илэрхийлсэн байдаг.” ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 129 дэх тал.

<sup>66</sup> Мөн тэнд, 128 дахь тал.

залхдаг, 4.2 хувь нь өөрийгөө тийм ч эерэгээр мэдэрч чаддаггүй, 4.2 хувь нь өөрийгөө хэнд ч хэрэггүй хүн гэдэгтэй, 5.2 хувь нь өөрийгөө ямар ч хэрэггүй хүн юм шиг санагддаг гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 95.0 орчим хувь нь өөрийнхөө талаар сөрөг төсөөлөлгүй байна.

### 7.6.3. Боловсрол

УИХ-аас 2023 онд Боловсролын багц хуулийг шинэчлэн баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээнээс үл хамаарч чанартай боловсрол, бусдын нэг адил эзэмших боломжийг бүрдүүлэх бодлогыг хуульчилсан.<sup>67</sup> Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн боловсрол эзэмшүүлэх дэмжих төв ажиллуулах, эцэг, эхийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, туслах багш ажиллуулах, сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, тохирох орчин бүрдүүлэх, хичээлийг цагийг уян хатан зохицуулах, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох зохицуулалтыг бий болгосон.<sup>68</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан талаар авсан арга хэмжээ ч цөөнгүй бий боловч бодит байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсрол эзэмших боломж Монгол Улсад маш хязгаарлагдмал байгааг ХЭҮК-ын судалгаа, хяналт шалгалтын дүн илтгэдэг. Тухайлбал, 2023 онд ХЭҮК-оос Нийслэлийн Ерөнхий боловсролын 116, 29 дүгээр сургуулиудад хийсэн хяналт шалгалтаар 1965 онд байгуулагдсан улсын ууган сургуулиудад хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгох аргазүй бий болоогүй, орчин, хэрэглэгдэхүүн, багшлах боловсон хүч хангалтгүй болохыг дүгнэж, арга хэмжээ авхуулсан.<sup>69</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах үзэл баримтлалыг бодитой үр дүн болгох нь урт хугацааны, тууштай, тогтвортой хичээл, зүтгэл, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан ажил юм. Үүний зэрэгцээ Монгол Улсад боловсролд хамрагдалт харьцангуй сайн боловч боловсролын чанарын үзүүлэлт хангалтгүй байгаа макро төвшний чиг хандлагыг анхаарах шаардлагатай. Албан ёсны мэдээллээр манай улсын нийт хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан, 64 улсаас өрсөлдөх чадвараар 60, ур чадварын

<sup>67</sup> “Боловсролын багц хуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг бүх шатны боловсролд тэгш хамруулах чиглэлээр 40 орчим заалт тусгагдсан байна.” БШУЯ-ны мэдээлэл.

<sup>68</sup> “Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулан сургах чиглэлд багш, менежерүүдийн чадавхыг хөгжүүлэх материаллаг нөхцөлд (ариун цэврийн өрөө, хаалга, шат г.м) тохируулга хийн өөрчлөх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж буй багш нарт нэмэлт цалин хөлс олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллах зэрэг санаачилга гарган ажиллаж байна.” гэж БШУЯ-аас мэдээлжээ.

<sup>69</sup> ЕБС-ын 29 дүгээр сургууль руу явуулсан 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Комиссын гишүүний шаардлага, ЕБС-ын 116 дугаар сургууль руу явуулсан 2023 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн Комиссын гишүүний шаардлага.

үнэлгээгээр 61 дугаар байр (БШУЯ, ҮСХ 2022)-т жагссан гэжээ. Гэтэл насанд хүрэгчдийн бичиг үсгийн чадварын судалгаагаар оролцогчдын 52.2 хувь нь зөв бичгийн дүрмийн алдаатай, 53.4 хувь нь найруулгын алдаатай, 15.5 хувь нь учир зүйн алдаатай гаргаж байгааг судалгааны дүн илтгэжээ.<sup>70</sup>

2020 онд 10, түүнээс дээш настай нийт хүн амын 26.4 хувь нь дээд (үүний 2.1 хувь нь магистр, 0.1 хувь нь доктор) боловсролтой байхад хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 11.4 хувь нь дээд боловсролтой эзэмшсэн байна.<sup>71</sup> Боловсрол, мэргэжил эзэмшээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөртөө итгэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, сонгуульд нэр дэвших боломж бага юм.

#### **7.6.4. Мэдээлэл хүлээн авах боломж, нөхцөл**

Чанартай мэдээлэл хомс, хүртээмжгүй байдал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог хязгаарлах бодитой хүчин зүйл болж байна. Судалгаанд оролцогчдын 14.0-16.0 хувь нь нэр дэвшигч, түүний мөрийн хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэл авч чадаагүй нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөөгүй нэг шалтгаан болжээ.<sup>72</sup> Тэдний 7.1 хувь нь мэдээллийн чанартаа “маш их сэтгэл ханамжтай”, 45.0 хувь нь “сэтгэл ханамж дунд” гэсэн үнэлгээг өгсөн байна. Мэдээлэл хүлээж авах ялгаатай байдалд нийцүүлж, төрөл бүрийн арга хэрэгслээр мэдээлэл дамжуулдаг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цөөн, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлдэггүйгээс мэдээллийн чанарт сэтгэл ханамжгүй гэсэн байна. Судалгаанд оролцогчид төр засгийн, хувь хүний хөгжил, чөлөөт цагийн мэдээ мэдээлэл илүүтэй авах сонирхолтой гэжээ.


Судалгаанд оролцогчдын 74.1 хувь нь телевиз, 59.3 хувь нь нийгмийн сүлжээний суваг, 27.5 хувь нь найз нөхөд, гэр бүлийн гишүүдээс, 10.9 хувь нь радио, 13.8 хувь нь сэтгүүл, бусад мэдээллийн эх сурвалжаас нийгэм, улс төрийн мэдээлэл авдаг, 16 хувь нь мэдээлэл хүлээж авах боломжгүй гэжээ.

<sup>70</sup> “Гэрэлма Гуруучин, Дарья Бадмаева Гедеева 2020”, О.Баасантогтох, “Нийгмийн институтчилэл ба тусгаарлагдмал байдал”, ШУА-ийн Философийн хүрээлэн, “Монголын нийгэм дэх тусгаарлагдах үйл явц, үр дагавар”, 2023 он, 190 дэх тал.

<sup>71</sup> ҮСХ, “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого – Боловсрол, бичиг үсгийн мэдлэг”, 2020 он, 15 дахь тал, “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого – Хөгжлийн бэрхшээл”, 2020он, 42 дахь тал.

<sup>72</sup> ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 109 дэх тал.

### Бүдүүвч 7.1 Нийгэм, улс төрийн мэдээлэл авдаг мэдээллийн эх сурвалж<sup>73</sup>



Цахим болон тоон технологийн хөгжил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх, амьдралын чанар, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гар утас, интернэтийн хэрэглээ өгсөн байна. Тухайлбал, 2010 онд зургаа ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний 55.1 хувь нь гар утас хэрэглэдэг байсан бол 2020 онд 73.2 хувь болж, өмнөх оны тооллогоос 18.1 нэгж хувиар өсжээ. 2010 онд зургаа ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10.3 хувь нь интернэт хэрэглэдэг байсан бол 2020 онд 35.3 хувь болж, өмнөх тооллогоос 25 нэгж хувиар өсжээ.<sup>74</sup>

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлд авсан арга хэмжээ цөөнгүй байна. Тухайлбал, e-Mongolia, ndaatgal, e-halamj, e-Job цахим системийг нэвтрүүлсэн, Монгол брайл бичгийн стандартыг баталсан, Монгол хэлний бичвэрийг ярианд хөрвүүлэх программ хангамжийг хөгжүүлэн туршиж байгаа зэрэг нь эерэг үр дүн гарах эхлэл болжээ. Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийг сургаж, сонсголгүй иргэдэд Зайнаас туслан зөвлөх төвийг байгуулж, олон нийтийн телевизэд дохионы орчуулга болон үсгэн тайлбар оруулах олон улсын стандарт Н.702-г нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж, веб сайтын болон IP телевизийн хүртээмжийг хангах олон улсын зөвлөмж /WCAG2.0/-ийг батлах зэрэг сонсголын бэрхшээлтэй

<sup>73</sup> ХЭҮК, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт”, 2024 он, 87-90 дэх тал.

<sup>74</sup> “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого – Хөгжлийн бэрхшээл”, 2021 он, 56, 59 дахь тал.

хүмүүсийн мэдэх эрхийг хангах арга хэмжээ авсан нь бодитой үр дүн гаргаж байна.<sup>75</sup> 2022 онд нийт 35 телевизээр мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн бол 2023 оны байдлаар нийт 42 телевизээр нийт хөтөлбөрийн 3.8 хувь нь дохионы хэлтэй, харин 16 телевизийн хөтөлбөрүүдийн 1.2 хувь нь хадмал тайлбар болсон талаар ХНХЯ мэдээлжээ. Цаашид цахим технологийн тусламжтай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, амьдралын чанарыг нэмэгдүүлэх тулхтай бодлого шаардлагатай юм.

---

<sup>75</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ эхлэлийн төвшинд байгаа, цаашид хийх ёстой олон ажил, арга хэмжээ хүлээгдэж байгаа юм. Жишээлбэл, ХНХЯ-ны хийсэн үнэлгээний "Мэдээллийн технологи, харилцаа холбооны үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хэсгийн дүгнэлтээр үнэлгээнд хамрагдсан 9 цахим хуудас нь бүгд хүртээмжтэй байдлын шаардлагад нийцээгүй, шалгуур хангасан үзүүлэлт байхгүй байна гэсэн дүгнэлт гарчээ." ХНХЯ, "Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээний нэгдсэн тайлан", 2022 он.



## 7.7. ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд бусад хүмүүсийн адил, үр дүнтэй оролцох боломжийг бий болгох нь ХБХЭК-д нэгдэж орсноос хойш Монгол Улсын нийгмийн бодлогод гарсан үзэл санааны өөрчлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь энэ бодлогын цөм зорилго, бие даасан хүний эрх болно. Нөгөө талаас, нийгмийн бүлгүүд улс төрд идэвхтэй оролцсоны дүнд тэдний амьдрал, нөхцөл байдал, хүсэл эрмэлзэл төрийн бодлого, хууль тогтоомжид илүүтэй тусгагдах тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хангах нь бусад эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг дээшлүүлэх арга зам юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөөх дэлхийн хөдөлгөөн “Бидний асуудлыг бидний оролцоогүй шийдэхгүй” (“Nothing about us, without us”) уриа дор нэгдэж, өргөн хүрээтэй нийгмийн эерэг өөрчлөлтийн төлөө тэмцэж ирсэн билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол өнөөгийн нийгмээс хамгийн их тусгаарлагдсан нийгмийн бүлэг юм. Амьдралын наад захын шийдвэрийг өөрөө гаргах дадал бага, бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох чадвар сул, хөдөлмөр эрхлэхгүй, эдийн засгийн чадавхгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвх, оролцоонд саад учруулж буй тэргүүлэх хүчин зүйлс байна. Орчны хүртээмжгүй байдал, бие даан чөлөөтэй зорчих боломжгүй, бэрхшээлийн онцлогт тохирсон байдлаар мэдээлэл авч чадахгүй байгаа нь нийгмийн идэвхтэй харилцааг хязгаарлах удаах хүчин зүйл болж байна. Орчны хязгаарлалт ялангуяа Улаанбаатар хотын хувьд өвлийн улиралд нэмэгддэг. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төр, нийгмийн амьдралд оролцох хүсэл, эрмэлзлэлтэй, өөрийгөө бусдаас ялгаатай гэж үзэх хандлага харьцангуй бага, хөгжлийн бэрхшээлтэй улс төрчийг дэмжих хандлага нийгмийн бусад гишүүдэд харьцангуй их байгаа тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ үр дүнд хүрэх боломжтойг илтгэж байна. Богино хугацаанд улс төрийн намуудын санаачлага, хөгжлийн бэрхшээлтэй улс төрчдийг санхүүжилтээр дэмжлэх, урт хугацаанд боловсролын хүртээмж, чанарын өөрчлөлт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хангахад бодитой түлхэц үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан нийгмийн харилцаанд орох хүсэл, өөртөө хамааралтай асуудлаар шийдвэр гаргах, улс төрийн оролцоонд хүйсийн ялгаатай байдал ажиглагдаагүй. Энэ нь нэг талаас өөрийн чадвар, чадавхын талаарх төсөөлөлд хүйс төдийлөн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйл биш болохыг, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо маш бага учраас хөгжлийн бэрхшээл ба нийгмийн бусад хүчин зүйлсийн харилцан хамаарлыг мэдрэх туршлага байхгүйг илтгэж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийн талаарх энэхүү дүгнэлт нийгмийн бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогыг эрэмбийг тогтооход чухал сануулга өгч байна. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хуулиар баталгаажуулж, намууд хөгжлийн бэрхшээлтэй улс төрчийг бэлтгэх үүрэг хүлээж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлсэн намд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгох зэрэг эрх зүй, институтийн арга хэмжээ авсан. Эдгээр арга хэмжээ нь боловсрол эзэмшсэн, санхүүгийн хувьд харьцангуй хараат бус цөөн тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төрд оролцоход дэмжлэг болж болох боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог өргөн хүрээнд нэмэгдүүлэхэд өгөөж багатай. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 70 орчим хувь нь бие даан амьдрах хэвшилгүй, өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, санхүүгийн гачигдалтай амьдардаг бөгөөд орчны хүртээмжгүй байдлаас нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцож чадахгүй байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлаас гаргах, боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлж, хувь хүнийг хөгжүүлэхгүйгээр тэдний улс төрийн оролцоо өргөн хүрээнд, бодитой нэмэгдэхгүй. Өөрөөр хэлбэл, нийгмийн тулгамдсан асуудлыг ихэнх тохиолдолд хууль тогтоомж, бодлогыг өөрчилж, асуудал эрхэлсэн байгууллага үүсгэснээр бодитой шийдэхгүй, харин тухайн асуудалд нөлөөлж буй хувь хүний, нийгэм-соёлын, эдийн засгийн, улс төр, эрх зүйн суурь хүчин зүйлсийг тодорхойлж, авах арга хэмжээний эрэмбийг тогтоох нь илүү үр дүнтэй байж болохыг энэ бүлгийн дүн шинжилгээ сануулж байна.

## САНАЛ

1. ХБХЭК-ын 33 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг тогтоон хуульчлах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүргээ биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулиудад нарийвчлан тусгах, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох;
2. Бүх шатны сонгуульд нэр дэвшиж буй хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид сурталчилгааны материал хэвлүүлэх, түгээх, хүртээмжтэй тээврийн хэрэгсэл, сурталчилгааны байраар хангах, дохионы хэлмэрч, хувийн туслах ажиллуулах зэрэг дэмжих үйлчилгээ авахад төрөөс санхүүгийн дэмжлэг, төлбөр, татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;
3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд чуулганы танхим, хуралдааны мэдээлэл хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлог хэрэгцээнд нийцсэн байх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнд шаардлагатай хувийн туслах, дохионы хэлмэрч, туслах технологиор хангах зохицуулалт тусгах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадавхжуулах, бие даан шийдвэр гаргах, сонголт хийх хэвшил, дадал төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн ИНБ-уудтай хамтран зохион байгуулах;
5. Монгол Улсын цахим хөгжлийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тусган хэрэгжүүлэх.

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ УЛС  
ТӨРИЙН ОРОЛЦОО,  
СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг тунхаглаж, 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцыг нэмэлт протоколын хамт соёрхон баталж, 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталж, албан ёсоор тунхагласан билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, болон холбогдох бусад хууль, тогтоомжоор баталгаажуулсан хэдий ч одоог хүртэл Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл байхгүй байна. Мөн Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн арван жил “Эрхийг бодит болгоё” Инчеоны тунхаглал (2013-2022)-ыг дүгнэх үед Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар албан ёсны тоо баримт гардаггүй, шийдвэр гаргах түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгогдож чадахгүй байгаа шалтгаан нөхцөлийг судалсан судалгаа, мэдээлэл хангалтгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баталгаажуулж, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлд “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлийн b-д “Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй” болохыг, сонгуулийн эрх бүхий иргэн аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр, хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой, тогтмол явагддаг сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй болохыг Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрч, хуульчилсан билээ.

Монгол Улсад 850 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн 81 хуульд (2023 оны 06 дугаар сарын байдлаар) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар тусгаж тэдгээрийг 153 зүйл, заалтаар дэлгэрүүлэн зохицуулжээ<sup>76</sup>.

<sup>76</sup> НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Богд Судалгааны хүрээлэн, “ЮНЕСКО”-гийн Монголын Үндэсний Комисс, Улаанбаатар хот, 2023 он

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор улс төрийн институтууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийн талаар зарим нэг судалгааг хийсэн байна. Тухайлбал, МАН-ын дэргэдэх Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэнгээс 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар судалгааг дурдаж болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэд хийсэн ажиглалтын тайлан<sup>77</sup>, Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэний сонгох эрхийн зарим асуудал нийтлэл<sup>78</sup>, Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг Улс төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байхуу? Сэдэвт нийтлэл<sup>79</sup> зэргийг дурдаж болно.

2020 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон зөрчлийн улмаас баривчлагдсан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогчдын сонгох эрхийн хэрэгжилтэд хийх мониторингийн удирдамж”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхийн хэрэгжилтэд мониторинг, 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үеэр олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох эрхээ эдэлж байгаа эсэхэд хяналт үнэлгээ, мониторингийн ажлыг тус тус зохион байгуулсан. Мониторинг үнэлгээгээр хууль, тогтоомжид заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрхтэй холбоотой заалтууд (Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.4, 56.5 дах хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3, 62.4, 62.5 дах хэсэг)-ын талаар сонгуулийн хэсгийн хороод харилцан адилгүй ойлголттой байна. Тиймээс хэрэгжилт нь хангалтгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө оролцож шийдвэр гаргаснаар хүний эрхэм чанар, амьдралын чанар сайжирна. Хөгжлийн бэрхшээлийн хөдөлгөөнд “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” гэдэг уриа онцгой байр суурь эзэлдэг бөгөөд НҮБ 2004 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдрийн уриа болгож байсан. Тус уриа нь сонгох, сонгогдох эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоонд чухал ач холбогдолтой.

<sup>77</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийн хэрэгжилт: Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль ажиглалтын тайлан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (АНУОУХА), 2021

<sup>78</sup> З.Өнөржаргал, Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэний сонгох эрхийн зарим асуудал, Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл, 2016/02 дугаар

<sup>79</sup> С.Номынбаясгалан, Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг Улс төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байхуу?, Төрийн байгуулал судлал №03, Конрад-Аденауэр-Сан, Улаанбаатар хот, 2021 он

Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дараагийн 10 жил болох 2023-2032 онд “Эрхийг бодит болгоё” Инчеоны тунхаглалыг эрчимжүүлэх Бээжингийн тунхаглалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж НҮБ-ын Ази-Номхон далайн нийгэм, эдийн засгийн хэлтэс (UNESCAP)-ээс улс орны Засгийн газруудтай хамтран Жакартагийн Тунхаглалын гаргаж, 2 дугаар зорилтдоо хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшинд дэх оролцоог дэмжихээр тусгажээ.

Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн арван жил “Эрхийг бодит болгоё” Инчеоны тунхаглал (2013-2022)-ыг дүгнэх үед Улсын Их Хурал, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд суудалтай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь (Үзүүлэлт 2.1), УИХ-ын гишүүд, хөгжлийн бэрхшээлээр, хүйсээр (Үзүүлэлт 2.1.1) гаргаагүй бөгөөд энэ нь Тогтвортой хөгжлийн зорилтын (Үзүүлэлт 16.7.1 Төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар, хүйсээр, насны бүлгээр, хувиар, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр, Үзүүлэлт 5.5.1 УИХ, орон нутгийн эрх барих хуралд суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь) зэрэг харгалзах үзүүлэлтэд хариулж чадаагүй. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саналын нууцлалыг хангах Улаанбаатар хот дахь хүртээмжтэй санал өгөх цэгүүдийн эзлэх хувь (Үзүүлэлт 2.4), Улаанбаатар хотын санал өгөх цэгүүдийн хүртээмж (Үзүүлэлт 2.4.1)-ийн тоог нотолгоо, судалгаатай гаргаж ирээгүй нь Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд оролцдог эсэхийг баталгаажуулах бичиг баримт байхгүй, мөн тэднийг оролцуулдаггүй нь илт байна.<sup>80</sup>

Орон нутгийн сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй нэг хүн сонгогдсоныг үл тооцвол УИХ-д хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл байхгүй байсаар байна. Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан судалгаанаас “Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн 39,474 иргэнийг төлөөлдөг” гэснээс үзэхэд Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл 2-3 гишүүн байх зайлшгүй хэрэгцээ байна.<sup>81</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн болон шийдвэр гаргах түвшин дэх оролцоо хангалтгүй байгаагаас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөлтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилтийг үнэлэх” судалгааг хийлээ.

<sup>80</sup> Ази-Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн арван жилийн (2013-2022) хэрэгжилтийн эцсийн тойм, Засгийн газраас авсан статистик судалгаа, НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хэлтэс, Засгийн газрын асуумж Б хэсэг, 2022 он

<sup>81</sup> С.Номынбаясгалан, Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг Улс төрийн намын тухай хуульд тусгах нийгмийн хэрэгцээ цаашид байсаар байхуу?, Төрийн байгуулал судлал №03, Конрад-Аденауэр-Сан, Улаанбаатар хот, 2021 он

Энэхүү судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн талаарх онолын суурь үзэл баримтлал судлагдсан байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, ХБИ-ний сонгох, сонгогдох эрхийн талаарх олон нийтийн хандлага, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн зохицуулалт зэрэг агуулгыг тусгалаа.



## БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ТАЛААРХ ОНОЛЫН СУУРЬ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ СУДЛАГДСАН БАЙДАЛ

Сонгох эрх нь хүний үндсэн суурь эрхийн нэг бөгөөд энэ нь ардчиллыг илүү төгс төгөлдөр болгож байдаг хүчин зүйлүүдийн хамгийн чухал хэсэг нь юм<sup>82</sup>. Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйл, Иргэний болон Улс төрийн эрхийн конвенцын 25 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 29 дүгээр зүйл, улс орнуудын Үндсэн хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүний (ХБИ)-ийн эрхийг хангах чиглэлд хэрэгжиж буй хууль эрх зүйн баримт бичгүүд нь нийгмийн бүх гишүүний эдлэх эрх, нийгмийн хамгааллын тогтолцооны хувьд тэгш байх ёстой гэдгийг баталгаажуулан тунхагласан байдаг.


Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн эрхийн хэрэгжилтийн талаар олон улсад хийгдэж байгаа судалгааны ажлуудад харьцуулсан шинжилгээ хийхдээ “Scoping review methodology”<sup>83</sup> буюу судлагдахууны гол түлхүүр үг, онолын үзэл баримтлал, тухайн улсын судалгааны туршлагын онцлог, судалгааны ажлын орон зайн ойлголтын хүрээнд харьцуулан үзэх арга зүйг ашигласан.



<sup>82</sup> Fishkin, Joseph. (2011). Equal Citizenship and the Individual Right to Vote. *Indiana Law Journal*, 86 (4), pp. 1289-1360.

<sup>83</sup> Arksey, Hilary & O'Malley, Lisa. (2005). Scoping Studies: Towards a Methodological Framework. *International Journal of Social Research Methodology*, 8 (1), pp. 19-32. <https://doi.org/10.1080/1364557032000119616>

Сэдвийн судлагдсан байдлын судалгааны хүрээнд шинжилгээ хийж үзэхэд 1997-2020 оны хооронд JSTOR, Science Direct, Scopus, Springer, SAGE, and Taylor & Francis судалгааны цахим сангуудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрх”-тэй холбоотойгоор нийтдээ 1709 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдсэн байна. Үүнээс хамгийн их ишлэгдсэн 103 эрдэм шинжилгээний өгүүлэлд иж бүрэн баримтын шинжилгээг хийсний үндсэн дээр судалгааны загвараа боловсрууллаа. Хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийн цаг хугацааны дарааллыг авч үзвэл:



Дээрх зураглалаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрх”-ийн талаарх судалгаануудын хугарлын цэгийг харж болохоор байна. Эрдэм шинжилгээний бүтээлүүдэд улс орнуудын жишээг авч үзсэн байдлаар нь харвал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны ажлуудын судалгааны үндсэн асуудал нь дараах чиглэлд байгаа нь ажиглагдсан. Үүнд:

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны талаарх онолын суурь үзэл баримтлал;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны хязгаарлалт;
- ✓ Санал өгөхөд шаардлагатай туслах бүтээгдэхүүн;
- ✓ Сонгуулийн практик туршлага;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог хангахад талуудын оролцоо, үүрэг;

- ✓ Сонгуулийн санал өгөх байрны хүртээмж ба алтернатив загвар.

Судалгааны бүтээлүүдэд агуулгын шинжилгээг хийж үзэхэд улс төрийн оролцооны мөн чанар, улс төрийн оролцоонд тулгарч байгаа хязгаарлалтууд, сонгогдох эрхийн хэрэгжилт ба боломж, сонгуульд оролцох, санал өгөх байрны хүртээмж (туслах бүтээгдэхүүний тусламжтайгаар сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, санал өгөх байрны хүртээмж)-ийн асуудал гэсэн 4 чиглэлд олон улсын судалгааны ажлууд хийгдсэн байна.

Гэвч сүүлийн судлагдсан байдлын судалгааны хүрээнд хязгаарлагдмал агуулгатайгаар харьцангуй бага судлагдсан асуудал нь оюуны бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцооны талаарх судалгаа, дүн шинжилгээ байна.

Улс төрийн оролцооны талаар судлахдаа гол төлөв сонгуулийн санал өгөх байрны хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн туслах бүтээгдэхүүний талаар л судлах хэв шинж ажиглагдсаар байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны талаарх онолын суурь үзэл баримтлал:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн эрх, улс төрийн оролцоо гэдэг нь улс төрд хэрхэн оролцох, үзэл бодлоо хэрхэн илэрхийлэх, засаглах үйл явцад хэрхэн оролцох зэрэг олон талт нийгэм, улс төрийн харилцааг илэрхийлсэн ойлголт юм. Aseka-Oluchina, Schur & Kruse нар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо гэдэг нь сонгуульд оролцож санал өгөх, төрийн удирдах үйл хэрэгт оролцох, улс төрийн шийдвэр гаргах эрх мэдэл бүхий албан тушаалд сонгогдох, улс төрийн нам байгуулах, гишүүнээр элсэх, бусад нийтийн эрх ашигт хамааралтай шийдвэр гаргах үйл явцад оролцох, зохион байгуулах эрхийн нэгдэл”<sup>84</sup> Schur, Meera & Ameri нар дээрх судлаачдын тодорхойлолтод дээрх санаануудаас гадна “сонгуулийн кампанит ажилд оролцох, зохион байгуулалцах, хандив өргөх, сонгуулийн кампанит ажлын сонгуулийн зохион байгуулах үйл явцад оролцох”<sup>85</sup> хэмээн нэмэлтээр тайлбарласан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн эрх, оролцооны хэрэгжилтийн талаарх асуудлыг «иргэний оролцоо судлал»-ын чиглэлийн судалгаануудад Meekosha & Dowse, Morris, болон Lister <sup>86</sup> нар оруулан судлах болсон байна.

Эдгээр судлаач бүтээлдээ “Орчин үеийн иргэн гэж хэнийг, ямар хүнийг хэлэх талаар хийгдэж байгаа судалгааны бүтээлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй

<sup>84</sup> Aseka-Oluchina, William. (2015). The Right to Political Participation for People with Disabilities in Africa. African Disability Rights Yearbook, 3, pp. 309-327. <http://dx.doi.org/10.17159/2413-7138/2015/v3n1a14>

<sup>85</sup> Schur, Lisa; Meera, Adya & Ameri, Mason. (2015). Accessible Democracy: Reducing Voting Obstacles for People with Disabilities. Election Law Journal, 14 (1), pp. 60-65. <https://doi.org/10.1089/elj.2014.0269>

<sup>86</sup> Meekosha, Helen & Dowse, Leanne. (1997). Enabling Citizenship: Gender, Disability and Citizenship in Australia. Feminist Review, 57 (1). <https://doi.org/10.1080/014177897339650>

хүмүүсийн талаар авч үзэхгүй байгаа нь хөгжлийн бэрхшээл нь иргэн гэдэг ойлголтод хамаарахгүй байгааг илэрхийлж байгаа учраас энэ чиглэлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлд тууштай судалгаа шинжилгээний ажил хийх шаардлагатай байна” хэмээн анхлан дурдсан байдаг.

Энэ үзэл санааг ч судлаач Rankin “Иргэний эрх нь улс төрийн болон нийгмийн эрхүүдээс бүрэлдэх бөгөөд иргэн болох тухай асуудал бол эрх чөлөөтэй байх, өмчтэй байх, хууль шүүхийн өмнө ялгаварлан гадуурхалгүй тэгш эрх эдлэхээс эхэлнэ. Улс төрийн эрх нь улс төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд оролцохыг хэлнэ. Нийгмийн эрх нь нийгмийн соёлын бүхий л салбарт тэгш эрхээр хангагдах боломж юм”<sup>87</sup> гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл иргэний оролцооны талаар судалгаа хийдэг судлаачдын хувьд хөгжлийн бэрхшээлтэй байх нь иргэн гэдэг статуст хамаарах ойлголтоос гадна огт өөр шинэ зүйл мэтээр тусгайлан авч үзэх асуудал биш гэдгийг судалгааны бүтээлээрээ анхлан гаргаж ирсэн байдаг. Үүний нэгэн адил санааг судлаач Morris бүтээлдээ тусгахын зэрэгцээгээр “Хөгжлийн бэрхшээл нь иргэний оролцооны талаарх судалгааг дараах гурван чиглэлд өргөжүүлэн судлах боломжийг олгож байна. Үүнд: чөлөөтэй сонголт хийх, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх боломж хязгаарлагдсан иргэний эрх, оролцоог хэрхэн хангаж, нийгэм соёлын амьдралд бие даан оруулах хувь нэмрийг нь хэрхэн нэмэгдүүлэх талаар судлах шаардлага бий болж байна”<sup>88</sup> гэж үзсэн байдаг. Үүний нэгэн адил судлаач Lister “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд эвлэлдэн нэгдэх, үзэл санаагаа илэрхийлэх, удирдах шийдвэр гаргах үйл хэрэгт оролцох гэдэг нь хүртээмжтэй иргэний оролцооны талаарх асуудал болохоос биш тусгайлсан ялгаатай судлагдахуун биш”<sup>89</sup> юм хэмээн үзсэн байдаг.

Сүүлийн үеийн судалгаануудаас харахад судлаач Hvinden “идэвхтэй биет оролцоотой иргэн” гэдэг нь хэн, юуг, яаж хийхийг хэлэх талаарх ойлголт бөгөөд хэн гэдэг нь хөгжлийн бэрхшээлгүй хүний талаар биш, нийгмийн бүх гишүүнд хамаарна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд “идэвхтэй биет оролцоо”-г хангах нь иргэний оролцооны талаарх асуудлыг “нийгмийн нэг гишүүний нийгмийн амьдрал болон хувийн амьдралдаа гаргах шийдвэр нь бусад хүмүүсээс хамааралтай болсон байгаа тохиолдолд хэрхэн, яаж гэдэг чиглэлд асуудлыг авч үзэх шаардлагатай болгож байна”<sup>90</sup> хэмээн үзсэн байдаг.

<sup>87</sup> Rankin, Joanna C. (2009). Disability, Citizenship & Identity. [PhD Thesis]. York University, Toronto. <https://pvac-sites.leeds.ac.uk/cds/files/library/rankin-Final-Citizenship-Disability-Identity.pdf>

<sup>88</sup> Morris, Jenny. (2005). Citizenship and Disabled People: A Scoping Paper Prepared for the Disability Rights Commission. Centre for Disability Studies, University of Leeds. <https://disability-studies.leeds.ac.uk/wp-content/uploads/sites/40/library/morris-Citizenship-and-disabled-people.pdf>

<sup>89</sup> Hvinden, Bjørn et al. (2017). Is Public Policy in Europe Promoting the Active Citizenship of Persons with Disabilities? In: Halvorsen, Rune; Hvinden, Bjørn; Bickenbach, Jerome; Ferri, Delia & Guillén Rodriguez, Ana Marta (Eds.). The Changing Disability Policy System. Active Citizenship and Disability in Europe Volume 1. Abingdon: Routledge.

<sup>90</sup> Hvinden, Bjørn et al. (2017). Is Public Policy in Europe Promoting the Active Citizenship of Persons with Disabilities? In:

Судлаач Morris, Lister, Hvinden нарын хувьд хөгжлийн бэрхшээлийг тусгайлан авч үзэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн “иргэн” гэдэг талаас нь харж хөгжлийн бэрхшээл бол иргэний оролцоо судлалыг өргөн хүрээг хамарсан хүртээмжтэй болгох чиглэлд өөрчлөгдөх суурийг тавьсан гэж үзэж болохоор байна.

Онолын үзэл баримтлалын хувьд Beckman,<sup>91</sup> Agran&Hughes<sup>92</sup>, Lawn<sup>93</sup> болон Korpi нар иргэний оролцооны талаарх ойлголтыг илүү өргөн хүрээтэйгээр авч үзэхийн зэрэгцээгээр ардчилсан тогтолцоог илүү хууль эрх зүйн хувьд баталгаажуулж байдаг гол ойлголт бол “иргэн”-ий эрх гэж үзээд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд нийгэм улс төрийн амьдралд чөлөөтэй оролцох, төрийг удирдах үйл хэрэгт оролцох эрхийн тухай асуудал бол ардчиллын нэг чухал баталгаа хэмээн үзсэн байдаг.

Үүнтэй төстэй үзэл санааг “IDEA” байгууллагын зөвлөмжид “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог тэлэх нь ардчилсан тогтолцоо оршин байгаа эсэхийн гол шалгуур юм”<sup>94</sup> хэмээн үзсэн байдаг. Судлаач Lister, “Ардчилсан тогтолцооны хувьд иргэний оролцооны тухай үзэл санаа нь нэг талаас оролцоог нийгмийн бүх гишүүдэд хамааруулж ойлгох хандлага нөгөө талаас тодорхой нийгмийн гишүүдийн хувьд тусгайлсан орчин үүсгэснээр оролцоог тэлэх тухай асуудлын хүрээнд яригдах болсон”<sup>95</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг. Судлаач Morris бүтээлдээ “Жинхэнэ ардчиллыг бүтээх үйл явц бол иргэний идэвхтэй болон идэвхгүй оролцооны аль алинд ч чиглэгдэх ёстой”<sup>96</sup> хэмээн үзсэн байдаг. Мөн тэрээр бүтээлдээ “идэвхтэй иргэн гэдэг нь өөрийн оршин амьдарч байгаа орон нутагтай холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцож саналаа өгч, нийгмийн өмнө хариуцлага хүлээсэн нэгэн гэдгээ мэдэрдэг нийгмийн гишүүнийг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь нэг талаараа идэвхтэй иргэн байх нь оролцоотой иргэн байх тухай үзэл санаатай агуулгын хувьд давхцаж байгаа юм. Судлаач Meekosha & Dowse нар бүтээлдээ “Идэвхтэй

---

Halvorsen, Rune; Hvinden, Bjørn; Bickenbach, Jerome; Ferri, Delia & Guillén Rodríguez, Ana Marta (Eds.). *The Changing Disability Policy System. Active Citizenship and Disability in Europe Volume 1*. Abingdon: Routledge.

<sup>91</sup> Beckman, Ludvig. (2009). *The Frontiers of Democracy*. London: Palgrave Macmillan.

<sup>92</sup> Agran, Martin & Hughes, Carolyn. (2013). You Can't Vote-You're Mentally Incompetent: Denying Democracy to People with Severe Disabilities. *Research & Practice for Persons with Severe Disabilities*, 38 (1). <https://doi.org/10.2511/027494813807047006>

<sup>93</sup> Lawn, S. et al. (2014). Mental Health Recovery and Voting: Why Being Treated as a Citizen Matters and How We Can Do It. *Journal of Psychiatric and Mental Health Nursing*, 21 (4), pp. 289-295. <https://doi.org/10.1111/jpm.12109>

<sup>94</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA). (2014). *Electoral Management Design. Revised Edition*. Strömsborg: International IDEA. <https://www.idea.int/publications/catalogue/electoral-management-design-revised-edition>

<sup>95</sup> Lister, Ruth. (2007). Inclusive Citizenship: Realizing the Potential. *Citizenship Studies*, 11 (1), pp. 49-61. <https://doi.org/10.1080/13621020601099856>

<sup>96</sup> Morris, Jenny. (2005). *Citizenship and Disabled People: A Scoping Paper Prepared for the Disability Rights Commission*. Centre for Disability Studies, University of Leeds. <https://disability-studies.leeds.ac.uk/wp-content/uploads/sites/40/library/morris-Citizenship-and-disabled-people.pdf>

иргэн байх нь эдлэх эрхээ мэддэг, эрхээ хамгаалуулахаар төрд шаардлага хүргүүлж чаддаг, эрхийг нь хамгаалж чадах хэн нэгэн, бүлэг хүмүүсийг төрд сонгож чаддаг байхыг хэлнэ”<sup>97</sup> хэмээн бүтээлдээ дурдсан байдаг.

Судлаач Lord, Ashley болон Fiala-Butora’s<sup>98</sup> нар хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн санаа бодол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “идэвхгүй оролцоо”-нд хэрхэн нөлөөлж байдаг талаар өмнө нь судалсан байдаг. Meekosha болон Dowse нар “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвхийн хязгаарлагдсан, сонгох эрхээ эдлэх боломж дутмаг байгаа нь тэд нийгмийн харилцаанд оролцож идэвхтэй иргэн байх, улс төрийн эрхээ эдлэх боломжоосоо татгалзчихсан гэсэн үг огт биш юм”<sup>99</sup> хэмээн мөн бүтээлдээ дурдсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн талаарх патерналист (нийгмийн хамгааллын тогтолцоог голчилсон хандлага) хандлагыг голчлон судалгааны бүтээлдээ дурддаг судлаачид болох Fiala-Butora, Ashley & Lord<sup>100</sup>, Barclay<sup>101</sup>, Combrinck<sup>102</sup>, Kopel<sup>103</sup>, болон Ryan, Henderson & Bonython<sup>104</sup> нар “иргэнийг чадавхжуулах, чадавхыг тэлэх” тухай ойлголтыг “оролцоо судлал”-д оруулж ирсэн бөгөөд ингэхдээ эмнэлгийн дүгнэлтээр сонгуулийн эрхээ хязгаарлуулсан, бусдын эрх чөлөөнд халдсаныхаа улмаас эрх чөлөөгөө хязгаарлуулсан нийгмийн гишүүдийн энэ эрхийг эдлүүлэх боломж нөхцөлийн талаар бүтээлүүддээ авч үзсэн байдаг.

Судлаач Sackey бүтээлдээ 1992 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 2013 онд анх удаа хөгжлийн бэрхшээлтэй хүн сайдаар томилогдож, үүнээс хойш хөгжлийн бэрхшээлтэй нэг ч хүнийг төрийн сайд, дүүргийн Засаг даргаар ч томилоогүй байна. Энэ нь нийгмийн бүхий л харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ялгаварлан гадуурхагдаж байгаагийн илрэл юм”<sup>105</sup>

<sup>97</sup> Meekosha, Helen & Shuttleworth, Russell. (2009). What’s so “critical” about Critical Disability Studies? *Australian Journal of Human Rights*, 15 (1), pp. 47-75. <https://doi.org/10.1080/1323238X.2009.11910861>

<sup>98</sup> Lord, Janet; Ashley, Michael & Fiala-Butora, János. (2014). Facilitating and Equal Right to Vote for Persons with Disabilities. *Journal of Human Rights Practice*, 6 (1), pp. 115-139. <https://doi.org/10.1093/jhuman/hut034>

<sup>99</sup> Meekosha, Helen & Dowse, Leanne. (1997). Enabling Citizenship: Gender, Disability and Citizenship in Australia. *Feminist Review*, 57 (1). <https://doi.org/10.1080/014177897339650>

<sup>100</sup> Fiala-Butora, János; Ashley, Michael & Lord, Janet. (2014). The Democratic Life of the Union: Toward Equal Voting Participation for Europeans with Disabilities. *Harvard International Law Review*, 55 (1), pp. 71-104.

<sup>101</sup> Barclay, Linda. (2013). Cognitive Impairment and the Right to Vote: A Strategic Approach. *Journal of Applied Philosophy*, 30 (2), pp. 146-159. <https://doi.org/10.1111/japp.12020>

<sup>102</sup> Combrinck, Heléne. (2014). Everybody Counts: The Right to Vote of Persons with Psychosocial Disabilities in South Africa. *African Disability Rights Yearbook*, 2, pp. 75-100

<sup>103</sup> Kopel, Charles. (2017). Suffrage for People with Intellectual Disabilities and Mental Illness: Observations on a Civic Controversy. *Yale Journal of Health Policy, Law, and Ethics*, 17 (1), pp. 209-250.

<sup>104</sup> Ryan, Trevor; Henderson, Andrew & Bonython, Wendy. (2016). Voting with an “Unsound Mind”? A Comparative Study of The Voting Rights of Persons with Mental Disabilities. *UNSW Law Journal*, 39 (3), pp. 1038-1071.

<sup>105</sup> Sackey, Emmanuel. (2014). Disability and Political Participation in Ghana: An Alternative Perspective. *Scandinavian Journal of Disability Research*, 17 (4), pp. 366-381. <https://doi.org/10.1080/15017419.2014.941925>

хэмээн бичжээ. Үүнтэй ижил дүгнэлтийг судлаач Schur and Adya нар 2006-2010 онуудад АНУ-д болсон сонгуулиудад шинжилгээ хийж үзээд “2006-2010 онд АНУ-д зохион байгуулагдсан бүхий л шатны улс төрийн сонгуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд санал өгөх улс төрийн оролцоо нь нийгмийн бусад гишүүдтэй харьцуулахад маш бага байсан. АНУ дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцооны хязгаарлагдмал байдал нь өөр хоорондоо ялгаатай улс төрийн тогтолцоотой дэлхийн бүхий л улс орнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд улс төрд идэвхтэй оролцож чадахгүй байгаагийн нотолгоо болж байна”<sup>106</sup> хэмээн үзсэн байдаг.

Зарим судлаачид хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн талаарх судалгаандаа дээрх эрхийг мэдээллийн тэгш хүртээмж, мэдэх эрхтэй холбож үзсэн байдаг. Судлаач Grobelaar, Mgijima & Njau, Fiala-Butora, Ashely & Lord, Morris нар хөгжлийн бэрхшээлтэй иргэд зөвхөн улс төрийн оролцооны хувьд биш нийгэм, соёл, эдийн засгийн бүхий л үзүүлэлтүүдээр тэгш бус байдалд байна” гэжээ. Судлаач Priestley нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн талаар авч үзэхдээ “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог судлахдаа хамгийн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш эрхийг зөвхөн улс төрийн хүрээнд биш нийгэм эдийн засгийн бусад бүх хувьсагчид хамтатган үзэх ёстой. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцооны талаар судлахдаа оюуны чадамжийн хязгаарлагдмал байдлын улмаас сонгуулийн эрхийг хуульчлан үгүйсгэх байдал, улс төрийн үйл явцын хүртээмжтэй байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хөдөлгөөний идэвх, улс төрийн хөдөлгөөн зэрэг онцгой хүчин зүйлүүдийг зайлшгүй авч үзэх хэрэгтэй”<sup>107</sup> хэмээн үзжээ.

Schur, Meera болон Ameri<sup>108</sup> нар судлаач Brady, Verba болон Lehman<sup>109</sup> нарын арга зүйгээр судалгаа хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгуулийн үл оролцоонд дараах гурван хүчин зүйл нөлөөлж байгааг тогтоосон байдаг. Үүнд:

1. Нөөцийн хязгаарлагдмал байдал;
2. Улс төрийн бүтцийн хязгаарлагдмал байдал (Улс төрийн нам болон зохион байгуулалтай бүтцийн гишүүнчлэлийн хязгаарлагдмал байдал);
3. Сэтгэлзүйн хязгаарлагдмал байдал.

<sup>106</sup> Schur, Lisa; Meera, Adya & Ameri, Mason. (2015). Accessible Democracy: Reducing Voting Obstacles for People with Disabilities. *Election Law Journal*, 14 (1), pp. 60-65. <https://doi.org/10.1089/elj.2014.0269>

<sup>107</sup> Priestley, Mark et al. (2016). The Political Participation of Disabled People in Europe: Rights, Accessibility and Activism. *Electoral Studies*, 42, pp. 1-9. <https://doi.org/10.1016/j.electstud.2016.01.009>

<sup>108</sup> Schur, Lisa; Meera, Adya & Ameri, Mason. (2015). Accessible Democracy: Reducing Voting Obstacles for People with Disabilities. *Election Law Journal*, 14 (1), pp. 60-65. <https://doi.org/10.1089/elj.2014.0269>

<sup>109</sup> Brady, Henry; Verba, Sidney & Lehman, Kay. (1995). Beyond Ses: A Resource Model of Political Participation. *The American Political Science Review*, 89 (2), pp. 271-294. <https://doi.org/10.2307/2082425>

Schur, Meera болон Ameri нарын судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн сонгуулийн оролцоонд боловсролын түвшин, санхүүгийн байдал, иргэний ур чадвар (бие даасан сонголт хийхэд нөлөөтэй ур чадварууд) зэрэг хүчин зүйл нөлөөлж байна гэж үзсэн.

Өөрөөр хэлбэл дээрх судлаачдын бүтээлд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог дээрх хүчин зүйлүүд хязгаарлаж байгаа учраас сонгуулийн идэвх буурах, сонгогдох эрх бүрэн хийгээд тодорхой нөхцөлөөр хязгаарлагдаж байгаа болох нь харагдаж байна. Судлаач Sackey бүтээлдээ Hillyugus хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн талаарх үзэл санаа чухал болохыг дурдаад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд нь тэдний улс төрийн боловсролын түвшнээс маш их хамаарч байна. Улс төрийн боловсрол гэдэг нь улс төрийн хувьд идэвхтэй оролцоход шаардлагатай ур чадвар, нөгөө талаас ардчилсан зарчмуудыг ойлгох мэдлэг юм”<sup>110</sup> гэж тодорхойлсон байдаг.

Мөн судлаач Schur, Meera & Ameri нарын бүтээлд “Мэдээлэл хүлээж авах албан болон албан бус эх сурвалжууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог хязгаарлахын зэрэгцээгээр мэдээллийн хүртээмж, мэдэх эрхийн хязгаарлагдмал байдал нь тэднийг “иргэн” гэх ойлголтоос тусгаарлагдахад хүргэж байна”<sup>111</sup> хэмээн үзсэн байдаг. Судлаач Kelley бүтээлдээ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй нэг хүчин зүйл бол тэдний нийгмийн янз бүрийн оролцооны институтжилт буюу зохион байгуулалттай ямар нэгэн бүлэгт хамрагдах, гишүүнчлэлийн асуудал чухал юм”<sup>112</sup> хэмээн тэмдэглэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд нөлөөлөх дараагийн нэг гол хүчин зүйл бол сэтгэл зүйн хүчин зүйл болох талаар судлаач өөрсдийн бүтээлүүддээ дурдсан байдаг. Судлаач Schur, Meera болон Ameri нар хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл зүйн ялгаатай байдлыг хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй харьцуулан судалсан байдаг. Мөн Ward, Baker болон Moon<sup>113</sup>, Lawn, Agran, Hughes<sup>114</sup> нар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хөгжлийн бэрхшээлээс үүдээд нийгмээс тусгаарлагдах, ялгаварлан гадуурхагдах нөхцөл болж байна гэж үзэх сэтгэл зүйн таагүй

<sup>110</sup> Sackey, Emmanuel. (2014). Disability and Political Participation in Ghana: An Alternative Perspective. *Scandinavian Journal of Disability Research*, 17 (4), pp. 366-381. <https://doi.org/10.1080/15017419.2014.941925>

<sup>111</sup> Schur, Lisa; Meera, Adya & Ameri, Mason. (2015). Accessible Democracy: Reducing Voting Obstacles for People with Disabilities. *Election Law Journal*, 14 (1), pp. 60-65. <https://doi.org/10.1089/elj.2014.0269>

<sup>112</sup> Kelley, Ryan. (2010). Toward an Unconditional Right to Vote for Persons with Mental Disabilities: Reconciling State Law with Constitutional Guarantees. *Boston College Third World Law Journal*, 30 (2), pp. 359-393.

<sup>113</sup> Ward, Andrew; Baker, Paul & Moon, Nathan. (2009). Ensuring the Enfranchisement of People with Disabilities. *Journal of Disability Policy Studies*, 20 (2). <https://doi.org/10.1177/1044207308325996>

<sup>114</sup> Agran, Martin & Hughes, Carolyn. (2013). You Can't Vote-You're Mentally Incompetent: Denying Democracy to People with Severe Disabilities. *Research & Practice for Persons with Severe Disabilities*, 38 (1). <https://doi.org/10.2511/027494813807047006>



байдал нь тэдний улс төрийн оролцоог хязгаарладаг” хэмээн үзсэн байдаг.

Ихэнх судалгааны бүтээлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн талаарх асуудал чухал сэдэв болохын зэрэгцээгээр судлагдсан байдлын хувьд хязгаарлагдмал, зөвхөн нэг талыг барьсан талаар тэмдэглэсэн байдаг. Судлаач Kanter, Russo нар “сонгуулийн санал өгөх байр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд “Саналаа нууцаар хэнээс ч үл хамааран бие даан өгөх” гэдэг ардчилсан сонгуулийн зарчим”-ыг ихэнхдээ алдагдуулсан байдаг”<sup>115</sup> гэж үзжээ. Судлаач Mercurio “саналаа нууцаар өгөх нь хувь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зайн нэг илрэл бөгөөд сонгуулийн явцад ийм орон зайгаар сонгогчдыг хангах нь сонгуулийн эрхийг бодит үйлдэл болгон хэрэгжүүлж байгаагийн илэрхийлэл бөгөөд энэ байдал нь ардчилсан тогтолцоотой улс бүрийн сонгууль зохион байгуулах институтийн зорилго байх ёстой”<sup>116</sup> гэжээ.

Судлаач Shaw<sup>117</sup> “Сонгуулийн санал өгөх байранд саналаа нууцаар хэнээс ч хамааралгүй бие даан өгөх эрхийг баталгаажуулахад чиглэсэн орчны нэмэлт хэрэгсэл нь сонгогчдын бие даасан сонголтод нөлөөлдөг” гэж үзсэн байна.

Ардчиллын үндсэн баталгаа нь ардчилсан сонгууль бөгөөд түүний шалгуур үзүүлэлт нь нийгмийн гишүүн бүрийг сонгуульд оролцож саналаа өгөх, нийгмийг удирдах, бодлого төлөвлөж шийдвэр гаргах үйл явцад бие даан оролцохын тулд эрх мэдэл бүхий албан тушаалд нэрээ дэвшүүлэн өрсөлдөх, сонгогдох бүхий л боломжийг хүн бүрд олгосон байх боломжоор загварчлагдсан байх ёстой юм.

## **Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоонд тулгардаг хязгаарлалтууд**

IFES & NDI-гийн судалгааны бүтээлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгуулийн эрхэд сонгуулийн зохион байгуулалт маш ихээр нөлөөлж байгааг тэмдэглэсэн байдаг.

Судлаач Van Hees, Boeije & De Putter<sup>118</sup>, Fiala-Butora, Ashely & Lord<sup>119</sup> нар бүтээлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог хязгаарлаж

<sup>115</sup> Kanter, Arlene & Russo, Rebecca. (2006). The Right of People with Disabilities to Exercise Their Right to Vote under the Help American Vote Act. *Mental & Physical Disability Law Reporter*, 30 (6), pp. 852-857.

<sup>116</sup> Mercurio, Bryan. (2003). Discrimination in Electoral Law: Using Technology to Extend the Secret Ballot to Disabled and Illiterate Voters. *Alternative Law Journal*, 28 (6). <https://doi.org/10.1177/1037969X0302800603>

<sup>117</sup> Shaw, Charley. (2006, January 26). MN Elections Officials Running into Problems with Compatibility of New Voting Equipment. *Minnesota Lawyer*. <https://minnlawyer.com/2006/01/26/mn-elections-officials-running-into-problems-with-compatibility-of-new-voting-equipment/>

<sup>118</sup> Van Hees, Suzanne; Boeije, Hennie & De Putter, Iris (2019). Voting Barriers and Solutions: The Experiences of People with Disabilities during the Dutch National Election in 2017. *Disability & Society*, 34 (5), pp. 819-836. <https://doi.org/10.1080/09687599.2019.1566052>

<sup>119</sup> Fiala-Butora, János; Ashley, Michael & Lord, Janet. (2014). The Democratic Life of the Union: Toward Equal Voting Participation for Europeans with Disabilities. *Harvard International Law Review*, 55 (1), pp. 71-104.

сонгуулийн идэвхийг бууруулдаг, сонгогдох эрхийн хязгаарлалтыг бий болгож байгаа олон хүчин зүйлүүдийг авч үзсэн байдаг.

Lord, Ashley болон Fiala-Butora<sup>120</sup>; Grobelaar, Mgiijima болон Njau<sup>121</sup>; Priestley et al. ; Ward, Baker & Moon<sup>122</sup>; Atkinson, Aaberg болон Darn<sup>123</sup>; Appelbaum<sup>124</sup> судлаачдын бүтээл болон Европын Холбооны Хүний эрхийн тунхаг (2019)<sup>125</sup>-т оюуны бэрхшээлтэй хүний сонгуулийн эрх, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх талаар судалгааны бүтээл, улс орны туршлага, улс төрийн хүсэл эрмэлзэл сул байгаа талаар тэмдэглэсэн байдаг.

Судлаач Kanter болон Russo,<sup>126</sup> Bell, McKay & Phillips,<sup>127</sup> Schur & Meera,<sup>128</sup> Combrinck<sup>129</sup> нар “Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжгүй санал авах байр, тэдэнд туслах бүтээгдэхүүн дутмаг байх, харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулсан саналын хуудас, эсвэл саналыг бичлэг хийж хүлээн авах аудио технологи байхгүй зэрэг хязгаарлалтууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгуулийн оролцоог хязгаарласан хэвээр байна” хэмээн судалгааны үндсэн дээр дүгнэлт хийсэн байдаг. Сонгуульд туслах олон улсын нийгэмлэг (IDEA)-ээс дэлхийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа сонгуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн эрх, улс төрийн оролцоог хангахад чиглэсэн санал авах байрны хүртээмж, нэмэлт бүтээгдэхүүний хязгаарлалтад ахиц дэвшил гарахгүй байгаа талаар 2014 онд дурдсан байдаг.

<sup>120</sup> Lord, Janet; Ashley, Michael & Fiala-Butora, János. (2014). Facilitating and Equal Right to Vote for Persons with Disabilities. *Journal of Human Rights Practice*, 6 (1), pp. 115-139. <https://doi.org/10.1093/jhuman/hut034>

<sup>121</sup> Grobelaar Du Plessis, Ilja; Mgiijima, Innocentia & Njau, Jehoshaphat. (2018). Art. 29 Participation in Political and Public Life In: Bantekas, Ilias; Ashley, Michael & Anastasiou, Dimitris (Eds.). *The UN Convention on the Rights of Persons with Disabilities: A Commentary*. Oxford: Oxford University

<sup>122</sup> Ward, Andrew; Baker, Paul & Moon, Nathan. (2009). Ensuring the Enfranchisement of People with Disabilities. *Journal of Disability Policy Studies*, 20 (2). <https://doi.org/10.1177/1044207308325996>

<sup>123</sup> Atkinson, Virginia, Aaberg, Rebecca & Darn, Staffan. (2017). Disability Rights and Election Observation: Increasing Access to the Political Process. *Nordic Journal of Human Rights*, 35 (4), pp. 375-391. <https://doi.org/10.1080/18918131.2017.1400348>

<sup>124</sup> Appelbaum, Paul S. (2000). "I Vote. I Count": Mental Disability and the Right to Vote. *Psychiatric Services*, 51 (7), pp. 849-863.

<sup>125</sup> European Union Agency for Fundamental Rights (FRA). (2019). Who Will (Not) Get to Vote in the 2019 European Parliament Elections? Developments in the Right to Vote of People Deprived of Legal Capacity in EU Member States. [https://fra.europa.eu/sites/default/files/fra\\_uploads/fra-2019-right-vote-ep-elections-legal-capacity\\_en.pdf](https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/fra-2019-right-vote-ep-elections-legal-capacity_en.pdf)

<sup>126</sup> Kanter, Arlene & Russo, Rebecca. (2006). The Right of People with Disabilities to Exercise Their Right to Vote under the Help American Vote Act. *Mental & Physical Disability Law Reporter*, 30 (6), pp. 852-857.

<sup>127</sup> Bell, Dorothy; McKay, Colin & Phillips, Kathryn J. (2001). Overcoming the Barriers to Voting Experienced by People with Learning Disabilities. *British Journal of Learning Disabilities*, 29 (4), pp. 122-127. <https://doi.org/10.1046/j.1468-3156.2001.00127.x>

<sup>128</sup> Schur, Lisa; Meera, Adya & Ameri, Mason. (2015). Accessible Democracy: Reducing Voting Obstacles for People with Disabilities. *Election Law Journal*, 14 (1), pp. 60-65. <https://doi.org/10.1089/elj.2014.0269>

<sup>129</sup> Combrinck, Hélène. (2014). Everybody Counts: The Right to Vote of Persons with Psychosocial Disabilities in South Africa. *African Disability Rights Yearbook*, 2, pp. 75-100.

Atkinson, Aaberg & Darn <sup>130</sup>, Wass ба бусад<sup>131</sup> нар “мэдээллийн хүртээмж, мэдэх эрхийн хязгаарлалт, барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжгүй байдал, нийгмийн гишүүн нэг бүрийн ялгаатай байдалд нийцээгүй тохиромжгүй байдал, нийгмийн тогтсон хандлага зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрийгөө бусдаас өөр байгаа гэдгийг мэдэрч нийгмээс өөрийгөө улам бүр хязгаарлах маш хүчтэй нөлөөлсөөр байна. Мөн сонгуулийн хэсгийн хороо, санал авах байранд сонгуулийг зохион байгуулахад оролцож байгаа албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэргэшсэн бус байдал, ойлголт, хандлагын хязгаарлагдмал байдал зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна”. Судлаач Hoerner<sup>132</sup>, Schur & Meera нар “тусгаарласан байдал (нийгмийн бүхий л салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусгаарласан орчинд сургах, ажиллуулах, амьдруулах хандлага), боловсрол, орлогын түвшин, бичиг үсэг тайлагдалтын хэмжээ, улс төрийн үйл ажиллагаанаас хүртэж байгаа ашиг, институцид итгэх итгэл, улс төрийн байгууллагаас хүлээх хүлээлт, тэдний үйл ажиллагаанаас авах сэтгэл ханамж зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийг хязгаарлаж байна” гэдгийг өөрсдийн судалгааны үр дүнгээр баталгаажуулсан байдаг.

Atkinson, Aaberg болон Darn, Thuo, Hoerner нар хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийг хязгаарлаж буй албан бус дараах хүчин зүйлүүдийг судалжээ. Судлаач Thuo<sup>133</sup> Кени Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн төлөв байдлыг судалж, албан бус дараах хязгаарлалт байна гэж үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнөөс шийдвэрийг гэр бүлийн нэг гишүүн эсвэл асран хамгаалагч нь гаргаж байгаа нь энэ хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд албан бус хязгаарлалт болж байна. Судлаач Fiala-Butora<sup>134</sup> бүтээлдээ “хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдийн хувьд эцэг эх нь төрөлтийн бүртгэл хийлгээгүйн улмаас тухайн улсын иргэний үнэмлэх авах, цаашлаад сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдэх, сонгуулийн үйл явцад оролцох, нийгмийн халамж хүртэх зэрэг бүхий л эрхийг хязгаарладаг албан бус хүчин зүйл болсоор байна” гэж үзсэн байна.

<sup>130</sup> Atkinson, Virginia, Aaberg, Rebecca & Darn, Staffan. (2017). Disability Rights and Election Observation: Increasing Access to the Political Process. *Nordic Journal of Human Rights*, 35 (4), pp. 375-391. <https://doi.org/10.1080/18918131.2017.1400348>

<sup>131</sup> Wass, Hanna; Mattila, Mikko; Rapeli, Lauri & Söderlund, Peter (2017). Voting While Ailing? The Effect of Voter Facilitation Instruments on Health-Related Differences in Turnout. *Journal of Elections, Public Opinion and Parties*, 27 (4), pp. 503-522. <https://doi.org/10.1080/17457289.2017.1280500>

<sup>132</sup> Hoerner, Benjamin. (2014). Unfulfilled Promise: Voting Rights for People with Mental Disabilities and the Halving of HAVA's Potential. *Texas Journal on Civil Liberties & Civil Rights*, 20. [https://works.bepress.com/benjamin\\_hoerner/1/download/](https://works.bepress.com/benjamin_hoerner/1/download/)

<sup>133</sup> Thuo, Lucianna. (2016). Implementation of Political Participation Standards for Persons with Intellectual Disabilities in Kenya. *Strathmore Law Journal*, 2 (1), pp. 97-131.

<sup>134</sup> Fiala-Butora, János; Ashley, Michael & Lord, Janet. (2014). The Democratic Life of the Union: Toward Equal Voting Participation for Europeans with Disabilities. *Harvard International Law Review*, 55 (1), pp. 71-104.

Цаашлаад судлаач Thuo, Meekosha болон Shuttleworth<sup>135</sup> нар энэхүү албан бус хязгаарлалтуудад нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд илүү ихээр нөлөөлж эмэгтэйчүүдийн хувьд гэрээс гарч нийгмийн харилцаанд ороход маш том хаалт болж байна гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, эмэгтэй сонгогчдын хувьд албан болон албан бус дээрх хязгаарлалтууд нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их нөлөөлдөг байна.

Мөн судлаач Kelley бүтээлдээ “сонгуулийн хэсгийн хороодын санал авах байрны ажилтан албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэхээс татгалзах, тэдний оролцоог хязгаарлах оролдлого дэлхийн улс орнуудад байсаар байгаа талаар мөн дурдсан байдаг.

### **Сонгуулийн санал авах байрны хүртээмж, нэмэлт туслах бүтээгдэхүүний талаарх судалгаа**

Takeaki ба бусад<sup>136</sup>, Kline & Ferri<sup>137</sup> нар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь туслах бүтээгдэхүүнийг хэрэглэснээр өдөр тутмын амьдралдаа нийгмийн харилцаанд бие даан оролцож, шийдвэр гаргах боломж бүрддэг” хэмээн үзжээ. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн талаарх судалгааны бүтээлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуулийн байранд очиж санал өгөхөд шаардлагатай нэмэлт туслах хэрэглэгдэхүүний талаарх судалгаа маш ховор байсан. Aseka-Oluchina<sup>138</sup>, Mercurio<sup>139</sup> болон McGrew<sup>140</sup> нар сонгуулийн байрны хүртээмж, санал өгөхөд шаардлагатай нэмэлт туслах бүтээгдэхүүний талаар бүтээлүүддээ авч үзсэн байдаг.

Судлаач Aseka-Oluchina бүтээлдээ “туслах бүтээгдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санал өгөх тэгш эрхийг хангах, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төрийн алба хашиж, бусадтай адил хөгжихөд зайлшгүй шаардлагатай шинэ технологи, технологийн дэвшлийг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Mercurio “Компьютержсон сонгуулийн систем үнэ өртөг өндөртэй хэдий ч улс орнууд төсвийн хязгаарлалтдаа тохирсон боломжоор энэ асуудлаа шийдэхийг хичээдэг. Гэхдээ аль ч хувилбар нь саналын хуудас, санал

<sup>135</sup> Meekosha, Helen & Shuttleworth, Russell. (2009). What's so "critical" about Critical Disability Studies? *Australian Journal of Human Rights*, 15 (1), pp. 47-75. <https://doi.org/10.1080/1323238X.2009.11910861>

<sup>136</sup> Takeaki, Shionome et al. (2017, 5-7 December). Complement of Incomplete Task Results for Real-Time Crowdsourcing Interpretation. 2017 International Conference on Asian Language Processing. *Asian Language Processing (IALP)*, Singapore. <https://ieeexplore.ieee.org/document/8300617>

<sup>137</sup> Kline, Jennifer & Ferri, Delia. (2017). Enabling People with Disabilities through Effective Accessible Technology Policies. In: Halvorsen, Rune; Hvinden, Bjørn; Bickenbach, Jerome; Ferri, Delia & Guillén Rodriguez, Ana Marta (Eds.). *The Changing Disability Policy System. Active Citizenship and Disability in Europe Volume 1*. Abingdon: Routledge.

<sup>138</sup> Aseka-Oluchina, William. (2015). The Right to Political Participation for People with Disabilities in Africa. *African Disability Rights Yearbook*, 3, pp. 309-327. <http://dx.doi.org/10.17159/2413-7138/2015/v3n1a14>

<sup>139</sup> Mercurio, Bryan. (2003). Discrimination in Electoral Law: Using Technology to Extend the Secret Ballot to Disabled and Illiterate Voters. *Alternative Law Journal*, 28 (6). <https://doi.org/10.1177/1037969X0302800603>

<sup>140</sup> McGrew, Greg. (2012). Assistive Technology for the Voting Process. *The Information Technology and Innovation Foundation, Working Paper, 002*. <http://elections.itif.org/reports/AVTI-002-McGrew-2012.pdf>

тоолох машин нь аудио болон дуу хоолойг таних программтай байх эсвэл түүнтэй төстэй технологийн өөр шийдэлтэй байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн оролцоо, саналаа нууцаар өгөх эрхийн баталгаа болно” хэмээн үзсэн байдаг.

Гэхдээ энэ чиглэлд хийгдэж байсан ямар ч судалгааны бүтээлүүд болон улс орнуудын туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай нэмэлт туслах хэрэглэгдэхүүний хувьд дэлхий нийтийн нэгдмэл стандартын тогтолцоо байхгүй байгаа нь харагдаж байна.

### **Сонгууль зохион байгуулах үйл явц хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоонд нөлөөлөх нь**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн талаарх ихэнх судалгаануудад сонгуулийн саад тотгорыг арилгах, сонгуулийн ажиглагчаар ажиллах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгон шалгаруулж ажиллуулах, санал авах байрны хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг практик асуудлуудыг авч үзсэн байдаг. Улс орнуудын “сайн туршлага” гэдэгт сонгууль зохион байгуулахад оролцож байгаа албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагын сургалтад хамруулж, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн тогтолцоог хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгох зэрэг ажлуудыг багтаан авч үзсэн байдаг.

Мөн нийтийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулах, энэ чиглэлд дэд бүтцийг хөгжүүлэх, улс төрийн намын хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөрт “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах” бодлогыг тусгах олон туршлагууд хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн үеийн судалгаануудад улс төрийн намуудын оролцоог хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй оролцогч тал гэж үзэж байна. Судлаач Aseka-Oluchina улс төрийн сонгуулийн үйл явцад улс төрийн намын үүрэг чухал учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвхтэй оролцоог хангахад улс төрийн намын манлайлал байх ёстой гэдгийг мөн өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуулийн систем дэх “пассив” буюу “идэвхгүй оролцогчид”-ын ангилалд ордог гэж таамаглах нь бас гадуурхах хандлагын нэг илрэл гэж үзсэн байдаг. Судлаач Combrinck үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгуулийн эрхийн хэрэгжилтэд амжилт олохын тулд нэн тэргүүнд тэднийг гадуурхсан, хэвшмэл хандлага эсвэл хэт тусгайлан авч үзэх зэрэг эмзэгшүүлсэн хандлагаас нийгмээрээ ангижрах шаардлагатай гэж үзсэн байна. Мөн судлаач Lister

хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхагдах зан үйлүүдийн ихэнх нь нийгмийн бусад гишүүдийн үзэл хандлага илүү тухайн улс орны дэд бүтцийн хөгжил, нийгмийн үйлчилгээний загвараас ихээхэн үүдэлтэй гэж үзсэн байдаг.

Ихэнх судалгааны бүтээлүүдэд сонгуулийн хэсгийн хорооны ажилтнууд болон сонгуулийн зохион байгуулалтад оролцож байгаа албан тушаалтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцах эсвэл тусламж үзүүлэх хангалттай мэдлэггүй, мөн хэвшмэл ойлголт, итгэл үнэмшил, хандлагатай шууд хамааралтай талаар авч үзсэн байдаг.

Судлаачид хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог өөр өөрийн өнцгөөс олон янзаар тайлбарладаг байна. Зарим нь улс төрд хэрхэн оролцох, үзэл бодлоо хэрхэн илэрхийлэх, засаглах үйл явцад хэрхэн оролцох зэрэг олон талт нийгэм улс төрийн харилцааг илэрхийлдэг гэж үзэж байхад зарим нь иргэн улс төрийн болон нийгмийн эрхтэй байх гэсэн нийгмийн амьдралд оролцох эрхээс салангид ойлголт гэж үзжээ. Гэхдээ аль ч судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарласан байдлаар авч үзээгүй буюу иргэний эрх дотор багтаан авч үзэж байна. Улмаар иргэний улс төрийн оролцоо нь ардчилсан тогтолцоог илүү хууль эрх зүйн хувьд баталгаажуулдаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгэм улс төрийн амьдралд чөлөөтэй оролцох, төрийг удирдах үйл хэрэгт оролцох эрхийн тухай асуудал бөгөөд ардчиллын нэг чухал баталгаа хэмээн үзжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоонд хязгаарлалт үүсгэх хүчин зүйлүүдийг судлаачид мөн тодорхойлжээ.

- ✓ Нөөц (сонгуулийн байрны орчны хүртээмж, санал өгөх байрны хүртээмж, саналаа нууцаар өгөх боломж бүрдүүлэлт, туслах технологи, шаардлагатай тохируулга)
- ✓ Институтын бүтэц, бодлого, хандлага (хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төрийн нам, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох бодлого, орчин нөхцөл, тэдгээр хүмүүсийн санал өгөх эрхийг зөвшөөрсөн байдал зэрэг)
- ✓ Хувь хүний мэдлэг боловсрол, санхүү, нөөц боломж (хөгжлийн бэрхшээлтэй хүн санал өгөх, сонгуулийн ач холбогдлын талаарх мэдлэг ойлголт, оюуны буюу бэрхшээлийн онцлог)

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төр, нийгмийн амьдралд оролцох боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд зарим нэмэлт, өөрчлөлт, зүйл заалтыг шинээр зохицуулсан байна.<sup>141</sup> Тухайлбал,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудад:

<sup>141</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын хоёр болон гуравдугаар нэгтгэсэн тайлан, 2020-2023 оны нэмэлт мэдээлэл, тайлангийн хэсгээс: 29 дүгээр зүйл, 2023 оны 08 дугаар сар

- Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байх;
- Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байх;
- Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байх зэрэг зохицуулалтуудыг тусгаж өгсөн.

Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 23 дугаар тогтоолоор “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, санал авах байр бэлтгэх заавар”-ыг шинэчлэн баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх асуудлыг нарийвчлан тусгасан. MNS6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлага, MNS6056:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар стандартыг үндэслэн санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагад дараах агуулгыг тусгажээ. Үүнд:

- Санал авах байрны гадна орчин явган болон тэргэнцэртэй иргэн зорчиход саадгүй байх, хэрэв саад үүссэн бол санал авах өдрөөс өмнө тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой байх,
- Санал авах байрны гадна талд хаяг, мэдээллийн самбарыг нийтэд хүртээмжтэй байдлаар байрлуулах /харааны бэрхшээлтэй иргэд, өндөр настан болон олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл болон хаягийг тод харагдахуйц том үсгээр байрлуулах/,
- Санал авах байр нь тэргэнцэртэй иргэн өөрөө орж гарах нөхцөл бололцоотой байх, орц гарц нь босготой бол тэргэнцэртэй иргэнд тохиромжтой байдлаар шийдэх,
- Санал авах байрны гадна талын үүдэн хэсгийн шал, шат нь иргэд халтирч гулгах эрсдэлгүй байх /гялгар плита, шалтай бол халтирч гулгахааргүй материалаар хамгаалалт хийх/, өндөр настан болон тэргэнцэртэй иргэд орж гарахад саадгүй, босгогүй байх, босготой тохиолдолд налуу байх,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногдсон нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээгийг зайлшгүй бэлтгэсэн байх,
- Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас, томруулдаг шилтэй байх,

- Санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байх.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа болон эрх зүйн орчны талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор СЕХ-ны [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn) цахим хуудсыг сул харааны бэрхшээлтэй иргэд унших боломжтой хувилбарыг нэвтрүүлж, цахим хуудсыг шинэчилсэн байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Их Хурлын 18, 28 дугаар тойрогт явагдсан нөхөн сонгуулиудаар сонгогчдод зориулсан мэдээ, мэдээллийг дохионы хэлээр тогтмол хүргэжээ. Мөн санал хураалтын дүн, үйл явцын талаарх шууд мэдээ, мэдээллийг олон улсын дохионы хэлээр, тэжээгч орчуулагчийн тусламжтайгаар анх удаа дохионы хэлний боломжит бүх хэлбэрийг ашиглан нэвтрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран сонгогчдод зориулсан шторк, уриалгыг зөвхөн дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэж нийтэд хүргэсэн байна.




## **БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн талаарх олон улсад хийгдсэн судалгаануудтай танилцаад судалгааны загвартаа дараах гол ойлголтуудыг хамруулах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг дангаар нь судлах боломжгүй гэж үзэж хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанар гэдэг ойлголтоор дамжуулан өргөн агуулгатайгаар судлах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарыг нийгмийн харилцаанд бие даан оролцох боломж, бие даан шийдвэр гаргах чадвар, идэвхтэй биет улс төрийн оролцоогоор тайлбарлах боломжтой гэж үзсэн;
- Улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд ХБИ-ний талаарх олон нийтийн санаа бодол, оролцооны зохион байгуулалт буюу институцийн дэмжлэгийг авч үзсэн;
- Бие даан шийдвэр гаргах чадварт хувь хүний чадавх, ХБИ өөрөө өөрийгөө хэрхэн үнэлж тодорхойлдог болох, бусадтай харилцаа холбоо тогтоох чадваруудыг нөлөөлнө гэж үзсэн;
- Нийгмийн харилцаанд бие даан оролцох боломжид нийгмээс үзүүлэх дэмжлэг, эрх чөлөөгөө эдлэх боломж, гэр бүлийн болоод нийгмийн орчинд бие даан хийх үйлдлүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн.

## Судалгааны загварын гол санааг зураглан харуулбал:



Энэхүү судалгааны ажлын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдэх эрх, нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар, улмаар улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн төлөв байдлыг судлан шинжлэх юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг үнэлэх судалгааг хоёр түвшинд хийсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 698<sup>142</sup> иргэнээс санал асуулга, УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшиж байсан хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнээс ганцаарчилсан ярилцлага авч судалгааны дүнг нэгтгэв.

<sup>142</sup> Үндэсний статистикийн хорооны 2022 оны статистик мэдээнд хөгжлийн бэрхшээлтэй 115,115 иргэн бүртгэгджээ. Нийт иргэний 1 хувийг санал асуулгад хамруулахаар зорьсон боловч судалгааг зохион байгуулсан цаг хугацаа нь өвлийн улиралд таарсан тул 698 иргэнийг судалгаанд хамруулсан.

### 2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон судалгаанд оролцогчдын мэдээлэл

Санал асуулгад 698 хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсоноос 56.3 хувь нь эмэгтэй, 43.7 хувь нь эрэгтэй, насны хувьд 13.2 хувь нь 18-25, 22.9 хувь нь 26-35, 30.4 хувь нь 36-45, 26.9 хувь нь 46-65, 6.6 хувь нь 65-аас дээш насны оролцогчид байна.

Судалгаанд оролцогчдын 12 хувь нь кластер 1 буюу Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Хөвсгөл аймгаас, 19.9 хувь нь кластер 2 буюу Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий, Дархан-Уул аймгаас, 16.6 хувь нь кластер 3 буюу Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Увс, Орхон, Говь-Сүмбэр аймгаас, 29.8 хувь нь Сэлэнгэ аймгаас, 21.6 хувь Улаанбаатар хотоос тус тус оролцсон байна. Судалгаанд оролцогчдын 62.2 хувь нь аймаг нийслэлийн төвд, 23.1 хувь нь сумын төвд, 6.9 хувь нь багийн төв, 7.9 хувь хөдөө амьдарч байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Үзүүлэлт		Тоо	Хувь
Хүйс	Эмэгтэй	393	56.3
	Эрэгтэй	305	43.7
Нас	18-25	92	13.2
	26-35	160	22.9
	36-45	212	30.4
	46-65	188	26.9
	65+	46	6.6
Судалгаанд оролцсон аймаг, нийслэл	Кластер 1: Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Хөвсгөл	84	12.0
	Кластер 2: Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий, Дархан-Уул	139	19.9
	Кластер 3: Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Увс, Орхон, Говьсүмбэр	116	16.6
	Кластер 4: Сэлэнгэ	208	29.8
	Кластер 5: Улаанбаатар	151	21.6
Амьдарч буй байршил	Аймаг, нийслэл	434	62.2
	Сумын төв	161	23.1
	Багийн төв	48	6.9
	Хөдөө	55	7.9
Бүртгэлтэй хаяг дээр амьдарч буй жил	1 хүртэлх жил	18	2.6
	1.1-3 жил хүртэл	37	5.3
	3 хүртэлх сар	8	1.1
	3.1-5 жил хүртэлх	67	9.6
	5-аас дээш жил	568	81.4

Гэрлэлтийн байдал	Бэлэвсэн	33	4.7
	Ганц бие	236	33.8
	Гэрлэсэн	380	54.4
	Гэрлэлт цуцлуулсан	40	5.7
	Тусдаа амьдардаг	9	1.3
Гэр бүлийн гишүүдийн тоо	1 гишүүнтэй	27	3.9
	2 гишүүнтэй	84	12
	3 гишүүнтэй	250	35.8
	5 хүртэлх гишүүнтэй	263	37.7
	5-аас дээш гишүүнтэй	74	10.6
Хамт амьдарч буй гэр бүлийн гишүүд	Ганцаараа	31	4.5
	Төрсөн ах эгч, дүү нартайгаа	62	8.9
	Эхнэр/нөхөр хүүхэдтэйгээ	417	59.7
	Ээж аавтайгаа	187	26.8
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	Бусад	146	20.9
	Оюуны хомсдол	31	4.4
	Сонсгол	81	11.6
	Сэтгэц	73	10.5
	Уналт таталт	42	6.0
	Хараа	100	14.3
	Хөдөлгөөн	188	26.9
Хэл яриа	37	5.3	

Судалгаанд оролцогчдын 4.7 хувь нь бэлэвсэн, 33.8 хувь нь ганц бие, 54.4 хувь нь гэрлэсэн, 5.7 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, 1.3 хувь нь тусдаа амьдарч байна. Өрхийн гишүүдээр нь авч үзэхэд 3.9 хувь нь 1 гишүүнтэй, 12 хувь нь 2 гишүүнтэй, 35.8 хувь нь 3 гишүүнтэй, 37.7 хувь нь 4-5 гишүүнтэй, 10.6 хувь нь 5-аас дээш гишүүнтэй амьдардаг бөгөөд тэдний 4.5 хувь нь ганцаараа, 8.9 хувь нь төрсөн ах, эгч, дүү нартайгаа, 59.7 хувь нь эхнэр/нөхөр хүүхэдтэйгээ, 26.8 хувь нь ээж аавтайгаа амьдардаг байна.

Эдгээр ХБИ-ний 26.9 хувь нь хөдөлгөөн, 14.3 хувь нь харааны, 10.5 хувь нь сэтгэцийн, 11.6 хувь нь сонсголын, 6 хувь нь уналт таталт, 5.3 хувь нь хэл ярианы, 4.4 хувь нь оюуны хомсдол, 20.9 хувь нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.


**Зураг 1. Судалгаанд оролцогсдын боловсрол эзэмшсэн байдал**



Боловсролын түвшингээр авч үзэхэд 6.7 хувь нь бичиг үсэг тайлагдаагүй, 10.3 хувь нь бичиг үсэг тайлагдсан, бага боловсролтой, 18.1 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 29.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 17.8 хувь нь дээд боловсролтой (бакалавр), 2.9 хувь нь дээд боловсролтой (магистр), 3.6 хувь нь огт сургуульд сураагүй (уншиж бичиж чаддаг), 11.2 хувь нь техник мэргэжлийн, тусгай боловсрол эзэмшсэн байна.


### 2.1.2. Судалгаанд оролцогчдын нийгэм, эдийн засгийн байдал, ажил эрхлэлтийн байдал

Зураг 2. Судалгаанд оролцогчдын өрхийн дундаж орлого




Судалгаанд оролцогчдын 40.7 хувь нь 501 000 - 1000 000 төгрөгийн, 30.7 хувь нь 101 000-500 000 төгрөгийн, 18.3 хувь нь 1000 001-1500 000 төгрөгийн, 3.9 хувь нь 1600 000-2000 000 төгрөгийн, 4.3 хувь нь 100 000 бага төгрөгийн, 2.1 хувь нь 2000 000 дээш төгрөгийн орлоготой байх бөгөөд 3.6 хувь нь өрхийн орлого хэрэгцээнд хангалттай хүрдэг гэсэн бол 42.6 хувь нь өрхийн орлого хэрэгцээнд арай ядан хүрдэг, 32.4 хувь нь заримдаа л хүрэлцдэг, 21.5 хувь нь огт хүрдэггүй гэж хариулжээ.

Зураг 3. Өрхийн орлого ба хэрэгцээний харьцаа




Зураг 4. Нийгмийн халамж өрхийн орлогод эзлэх хувь



Нийгмийн халамжийн сангаас тодорхой төрлийн халамж авдаг гэж оролцогчдын 84.7, үлдсэн 15.3 хувь нь ямар нэгэн төрлийн тэтгэмж авдаггүй байна. Нийгмийн халамж авдаг оролцогчдын 48.7 хувь нь халамжийн тэтгэмж нь өрхийн орлогын талаас бага хувийг, 11.4 хувь нь талаас илүү хувийг, 23.7 хувь нь тал хувийг, 16 хувь нь бүхэлдээ өрхийн орлогыг бүрдүүлдэг гэжээ.

Зураг 5. Нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалт



Нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийг 63.4 хувь нь гэр бүлийн гишүүдийн хэрэглээнд, 30.6 хувь нь өөрийн хэрэгцээнд зарцуулдаг бол 5.8 хувь нь юунд хэрхэн зарцуулагддаг болохыг мэдэхгүй байна. Сүүлийн 6 сарын хугацаанд бэлэн мөнгөтэй байсан эсэхийг судлахад судалгаанд оролцогчдын 67.3 хувь нь багахан хэмжээний хангалттай биш мөнгөтэй, 28.3 хувь нь огт мөнгөтэй байж үзээгүй гэсэн хариултыг өгсөн байна. Харин 4.3 хувь хүрэлцэхүйц хангалттай мөнгөтэй байсан гэж хариулжээ.


Хүснэгт 2. Зардлын шинжилгээ (сараар)

Зардлын хэмжээ	Хоол хүнсний бүтээгдэхүүний зардал	Орон сууц ба ба ус, цахилгаан, СӨХ-д холбогдох зардал	Боловсрол сургуультай холбоотой зардал	Эрүүл мэнд, эмчилгээний зардал	Тээвэр ба зорчих зардал
Хамгийн бага зардал	84,200	57,550	63,500	75,000	61,000
Хамгийн их зардал	1,500,000	1,000,000	800,000	1,500,000	600,000
Дундаж зардал	387,000	132,000	188,000	230,600	193,000

ХБИ хоол хүнсний бүтээгдэхүүнд 84,200-1,500,000, орон сууц ба СӨХ, ус цахилгааны зардалд 57,550-1,000,000, боловсрол, эзэмшихтэй холбоотой зардалд 63,500-800,000, эрүүл мэнд эмчилгээний зардалд 75,000-1,500,000, тээвэр ба зорчих зардалд 61,000-600,000 тус тус зарцуулдаг ба эндээс


дундажлаад үзвэл боловсрол сургуультай холбоотой зардал хамгийн бага буюу 188,000 төгрөг байна.

**Зураг 6. Орон сууцны төрөл**



Судалгаанд оролцогчдын 56 хувь нь өөрийн эзэмшлийн байшин/гэрт, 17.9 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууцанд, 9.6 хувь нь түрээсийн байшин/гэр, 6.1 хувь нь түрээсийн орон сууцанд, 2 орчим хувь нь нийтийн байр болон түрээсийн хажуу өрөөнд амьдарч байна.


**Зураг 7. Ажил эрхлэлтийн байдал**



Судалгаанд оролцсон ХБИ-ийн 62 хувь нь ямар нэгэн хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэггүй, 16.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 12.9 хувь нь төрийн байгууллагад, 5.6 хувь нь хувийн компани, аж ахуй нэгжид, 3.2 хувь нь төрийн бус байгууллагад ажил эрхэлдэг байна.



Зураг 8. Сургалтад хамрагдаж байгаа байдал




Судалгаанд оролцогчдын 94.1 хувь нь одоогоор ямар нэгэн сургалтад хамрагдаагүй байгаагаа илэрхийлсэн бол 3 хувь нь л сургалтад дамжаанд суралцаж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

### 2.1.3. Мэдэх эрхийн хэрэгжилтийн байдал

Нийгэм, улс төрийн мэдээлэл авдаг эх сурвалжийг тодруулахад 74.1 хувь нь телевиз, 59.3 хувь нь нийгмийн сүлжээ (фэйсбүүк, инстаграм, твиттер), 27.5 хувь нь найз нөхөд, гэр бүлийн гишүүдээс, 10.9 хувь нь радио, 13.8 хувь нь сэтгүүл, бусад мэдээллийн эх сурвалжаас авдаг гэсэн бол 16 хувь нь мэдээлэл хүлээж авах боломж байдаггүй гэж хариулжээ.

Зураг 9. Мэдээллийн эх сурвалждаа сэтгэл ханамжтай байдаг эсэх




Мэдээлэл авах эх сурвалждаа сэтгэл ханамжтай эсэхийг тодруулахад 7.1 хувь нь маш их сэтгэл ханамжтай, 13.6 хувь нь ерөнхийдөө сэтгэл ханамжтай, 18.3 хувь нь огт сэтгэл ханамжгүй, 15.9 хувь нь маш бага сэтгэл ханамжтай, 44.9 хувь нь сэтгэл ханамж дунд гэж үнэлжээ. Мэдээллийн эх сурвалжийн сэтгэл ханамжийн талаарх дээрх үр дүнд нас, хүйс, , хөгжлийн бэрхшээл, амьдарч буй байршлаар хамаарлын шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Үүнд:

Судалгаанд оролцсон эрэгтэй оролцогчдын 19 хувь, эмэгтэй оролцогчдын 31 хувь нь мэдээллийн эх сурвалждаа маш их сэтгал хангалуун байдаг байна. Сэтгэл ханамжгүй байдлыг тодруулахад:


- Мэдээлэл хүлээж авах ялгаатай байдлыг харгалзан үзсэн мэдээллийн хэрэгсэл бага;
- Телевизийн хөтөлбөрийн голчлон мэдээ, төрийн үйл ажиллагааны мэдээлэл нь хүлээн авах ялгаатай байдлыг харгалзан үзсэн байдаг нь дутагдалтай;
- Хувь хүний хөгжил, чөлөөт мэдээ мэдээлэл нь хүлээж авах ялгаатай байдалд тохироогүй;
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлдэггүй зэрэг шалтгаан нөлөөлдөг байна.

**Зураг 10. Хэвлэл, мэдээлэлд итгэх байдал, насны ангиллаар**



65 ба түүнээс дээш насны оролцогчдын 32.6, 46-65 насны оролцогчдын 28.7, 36-45 насны 25.6, 26-35 насны 25, 18-25 насны 19.6 хувь нь сонин, хэвлэл мэдээлэл (бичмэл)-д огт итгэдэггүй гэж хариулсан байна. Нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм)-нд 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 39.1, 46-65 насны оролцогчдын 27.1, 36-45 насны оролцогчдын 24.6, 26-35 насны оролцогчдын 20.6, 18-25 насны оролцогчдын 19.6 хувь нь огт итгэдэггүй гэжээ.


Зураг 11. Хэвлэл, мэдээлэлд итгэх байдал, боловсролын байдлаар



Дээд боловсролтой (бакалавр, магистр) оролцогчдын 28-32, бага боловсролтой оролцогчдын 29.2, бүрэн бус дунд боловсролтой оролцогчдын 22.2, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 23.3, техник мэргэжлийн тусгай боловсролтой оролцогчдын 23.1 хувь нь сонин, хэвлэл (бичмэл)-д огт итгэдэггүй гэж хариулсан байна.


Нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм)-г дээд боловсролтой (магистр) оролцогчдын 30, дээд боловсролтой (бакалавр) оролцогчдын 27.6, бага боловсролтой оролцогчдын 20.8, бүрэн бус дунд боловсролтой оролцогчдын 24.6, бүрэн дунд боловсролтой иргэдийн 22.3 хувь нь огт итгэдэггүй байна.

Зураг 12. Хэвлэл, мэдээлэлд итгэх байдал, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр




Сэтгэц, оюуны хомсдол, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 31-35, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 25.5, харааны бэрхшээлтэй оролцогчдын 26, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 21, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн 10.8 хувь нь хэвлэл (бичмэл)-д огт итгэдэггүй гэж хариулсан байна. Нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм)-г уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 42.9, оюуны хомсдолын бэрхшээлтэй оролцогчдын 32.3, харааны бэрхшээлтэй оролцогчдын 25 хувь нь огт итгэдэггүй гэж хариулжээ. Мэдээллийн эх сурвалжийн сэтгэл ханамжийн талаарх дээрх үр дүнд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, амьдарч буй байршлаар хамаарлын шинжилгээг хийж үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Үүнд:

**Зураг 13. Хэвлэл, мэдээлэлд итгэх байдал, байршлаар**




Аймаг, нийслэл сумын төвд амьдардаг оролцогчдын 28.9, хөдөө орон нутагт амьдардаг оролцогчдын 32.7 хувь нь сонин хэвлэл мэдээлэл (бичмэл) огт итгэдэггүй, харин нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм)-ний мэдээлэлд аймаг, нийслэлийн төвд амьдардаг оролцогчдын 28.2, хөдөө амьдардаг оролцогчдын 23.6 хувь нь огт итгэдэггүй байна.

**Зураг 14. Мэдэх эрх, мэдээлэл авах боломж ба сэтгэл ханамж**



Мэдэх эрх, мэдээлэл олж авах боломждоо сэтгэл хангалуун байдаг эсэхийг үнэлэхэд 70.5 хувь нь нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийн талаарх мэдээлэл авах, 63.4 хувь нь явган хүний гарцын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохионы талаарх мэдээлэл, 55.2 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээллийг ойлгож хүлээж авах, 53.7 хувь нь дэлгүүр үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхэд бараа бүтээгдэхүүний талаар мэдээлэл авах боломжид огт сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн бол ердөө 1.9-2.1 хувь нь сэтгэл ханамжтай байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдэх эрх, мэдээлэл олж авах боломжид маш том хязгаарлалт байгааг харуулж байна.

Зураг 15. Мэдээлэл, үйл ажиллагааны хүртээмж ба сэтгэл ханамж



Судалгаанд оролцогчдын 40.3 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 44.3 хувь нь Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, 40.1 хувь нь аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагын ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээ, 41.7 хувь нь сум, дүүрэг, баг, хорооны хэрэгжүүлж буй бодлого, 41.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах ИНБ-уудын үйл ажиллагаанд сэтгэл ханамж дунд зэрэг байгаагаа илэрхийлжээ. Ердөө 1.6-3.7 хувь нь л маш их сэтгэл ханамжтай гэж үнэлсэн нь бүх шатны төрийн захиргааны байгууллага, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилт, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүртээмж, мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байгаа нь харагдаж байна. ХБИ-ний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагад судалгаанд оролцогчдын 2.4 хувь нь маш их сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн нь цаашид анхаарах шаардлагатай гэж судлаачдын баг үзэж байна.


Гэр бүлийн гишүүд, найз нөхөд, нийгмийн бусад гишүүдийн харилцаа, хандлагад хэр зэрэг сэтгэл ханамжтай байдаг талаар үнэлэхэд оролцогчдын 43.4 хувь нь гэр бүлийн гишүүддээ, 36.5 хувь нь найз нөхөддөө сэтгэл ханамжтай байна. Нийгмийн бусад гишүүдийн хандлагад 45.3 хувь нь сэтгэл дундуур гэсэн бол 2.4 хувь нь хүмүүсийн хандлагад “маш их сэтгэл ханамжтай” байдаг гэжээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээ эдэлж чадахгүй байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна. Иймд нийгмийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт түгээх, ялгаатай хөгжлийн чиг хандлагыг хүлээн зөвшөөрөх, бусдадаа хүндэтгэлтэй хандаж сурах зэрэг нөлөөллийн арга хэмжээг нийгмийн бүхий л түвшинд хийх шаардлагатай болохыг харуулж байна.

### 2.1.4. Нийгмийн харилцаанд бие даан оролцоход тулгарч байгаа бэрхшээл

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд орохдоо 48 хувь нь гэрээс гадуур ганцаараа явж чаддаг бол 42 хувь нь гэр бүлийн гишүүдийн тусламжтайгаар гадуур гардаг, тэдний 2 хувь нь огт гэрээсээ гарч чаддаггүй байна.

Хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд ганцаараа бие даан гадуур гарч явж чаддаг бол бусад хэлбэрийн, сэтгэц уналт таталттай оролцогчид гэр бүлийн гишүүдийн тусламжтайгаар гадуур гардаг байна.


Зураг 16. Бие даан гадуур явж нийгмийн харилцаанд ордог оролцогчид, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь нийгмийн харилцаанд орохдоо гэр бүлийн гишүүдийн болон бусдын тусламжийг авдаг бол харааны бэрхшээлтэй иргэдийн 8.4 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн 11.8 хувь, уналт


таталтын бэрхшээлтэй иргэдийн 2.3 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн 5.5 хувь, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 7.9 хувь, оюуны хомсдолтой иргэдийн 1.3 хувь, бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн 13.8 хувь нь бие даан нийгмийн харилцаанд оролцож байна.

**Зураг 17. Зам, нийтийн тээврийн хэрэгсэл (сэтгэл ханамж)**



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцоход нийтийн эзэмшлийн зам талбай, дэд бүтэц, хүмүүсийн харилцаа, хандлага түгээмэл бэрхшээл тулгардаг байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь ХБИ-дэд зориулсан явган хүний зам, 48 хувь нь ХБИ-дэд зориулсан явган хүний замын гадаргуу болон материал, 50.3 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд ХБИ-дэд зориулсан хэсэг байдаггүй, 48.4 хувь нь нийтийн тээврийн хэрэгслийн хүлээлгийн хэсэгт хөгжлийн ялгаатай хэрэгцээнд тохируулаагүйд маш их сэтгэл ханамжгүй байдгаа илэрхийлжээ.

**Зураг 18. Улирлын шинж чанар, байгалийн зарим хүчин зүйлд ХБИ-ийн нийгмийн оролцоонд нөлөөлөх нь**



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд улирлын шинж байдлаас шалтгаалан үүсэх байгалийн зарим нэгэн хүчин зүйл (цас, үер ус)-с шалтгаалж нийгмийн харилцаанд ороход хүндрэл үүсдэг байна. Тухайлбал, өвлийн улирлын шинж чанар хамгийн их хүндрэлтэй гэж судалгаанд оролцогчдын 88 хувь нь үзжээ. Иймд өвлийн улиралд цас, гулгаа, халтиргаа зэрэг учирч болох бэрхшээлээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэрээс гарч нийгмийн харилцаанд орох нь хязгаарлагддаг байна.

## **2.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ИДЭВХ**

### **2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн сонгуулийн оролцооны идэвх**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд 73.5, 2020 оны ээлжит сонгуульд 73.6<sup>143</sup>, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд 59,3<sup>144</sup> хувь нь оролцож саналаа өгчээ.

Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд санал өгөх эрхтэй 82,013 хөгжлийн бэрхшээлтэй сонгогч бүртгэгдсэнээс 40,536 буюу 49.4 хувь нь сонгуульд оролцож, саналаа өгсөн бол 41,477 буюу 50.6 хувь нь сонгуульд оролцоогүй байгаагаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо хангалтгүй байгаа нь харагдаж байна<sup>145</sup>.

Судалгаанд оролцогчдын сонгуулийн оролцоог судалж үзэхэд 85.7 хувь нь УИХ-ын ээлжит сонгуульд, 84.1 хувь нь Орон нутгийн ээлжит сонгуульд, 84.7 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцож саналаа өгчээ. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн оролцоо буюу сонгох эрхийн хэрэгжилт боломжийн түвшинд байгаа боловч судалгаанд оролцогчдын 14-16 хувь нь аль ч сонгуульд оролцож саналаа өгөөгүй байна.

Сонгуульд оролцоогүй шалтгаан нь сонгуулийн байранд ганцаараа очих боломжгүй, хэн нэгний тусламж дэмжлэгийг авах зайлшгүй шаардлагатай, сонгуулийн хэсгийн санал авах байр хол, бүх шатны сонгуулийн талаарх мэдлэг, ойлголт муу, мэдээллийн хүртээмжийн хязгаарлагдмал, нийгмийн оролцооны идэвх сул зэргээс шалтгаалан сонгуульд оролцоогүй болохоо судалгааны явцад илэрхийлсэн байна.

<sup>143</sup> Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн, УБ, 2022 он


<sup>144</sup> Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, УБ, 2021

<sup>145</sup> НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, "Богд судалгааны хүрээлэн" НҮТББ, УБ, 2022 он



Иймд сонгуулийн хэсгийн санал авах байрны нөхцөл байдал, хүртээмжийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмж, тэдний ялгаатай байдалд тохирсон байдлаар мэдэх эрхийг хүндэтгэх, сонгогчдын боловсрол олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцооны идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байсан.


Зураг 19. Сонгуулийн оролцоо



Сонгуулийн оролцооны идэвхийг насны бүлгээр авч үзэхэд 18-25 насны ХБИ-ний 30.4 хувь нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож санаалаа өгөөгүй бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд 18-25 насны оролцогчдын 31.5 хувь, 2020 оны бүх шатны орон нутгийн сонгуульд 18-25 насны оролцогчдын 31.5 хувь нь оролцож санаалаа өгөөгүй байна.


Бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 29.8 хувь, огт сургууль суралцаагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 22.2 хувь нь 2020 оны УИХ-ын сонгуульд оролцож санаалаа өгөөгүй, мөн эдгээр оролцогчдын 18-28 хувь нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 2020 оны орон нутгийн сонгуульд оролцож санаалаа өгөөгүй гэж хариулсан байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд 2020-2021 онд зохион байгуулагдсан бүх шатны орон нутгийн сонгуулиудын оролцооны идэвхид хүйсийн ялгаатай байдал огт ажиглагдсангүй.

Зураг 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцооны идэвх



Сонгуульд оролцож саналаа өгөх, улс төрийн байр сууриа илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг улс төрийн биет оролцооны идэвхийн хувьд судалгаанд оролцогчдын 12 хувь нь маш идэвхтэй, 40.5 хувь нь идэвхийн хувьд дундаж, 17.6 хувь нь огт идэвхтэй биш, 14.9 хувь нь сул идэвхтэй хэмээн хариулсан байгаагаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвхтэй биет оролцоо тодорхой нөхцөлүүдээр хязгаарлагдаж байна

Зураг 21. Сонгуулийн оролцооны идэвх, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр




2020 оны УИХ-ын сонгуулийн хувьд сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын

20.5, харааны бэрхшээлтэй оролцогчдын 15, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 13.3, бусад хэлбэрийн бэрхшээлтэй оролцогчдын 14.5 хувьд оролцоогүй байна.

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд оюуны хомсдолын бэрхшээлтэй оролцогчдын 32.3, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 26, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 19 хувь нь сонгуульд оролцож саналаа өгөөгүй байна. 2021 онд зохион байгуулагдсан бүх шатны орон нутгийн сонгуульд оюуны хомсдол, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 22.6 хувь, харааны бэрхшээлтэй оролцогчдын 18 хувь, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 13.5 хувь нь оролцоогүй байна.

**Зураг 22. Сонгуулийн оролцооны идэвх, газар зүйн байршлаар**




Сумын төвд амьдардаг оролцогчдын 21.7, 2020 оны УИХ-ын ээлжит сонгуульд, 18 хувь нь 2020 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцоогүй бол аймгийн төвд амьдардаг оролцогчдын 17.6 хувь нь 2020 оны бүх шатны орон нутгийн сонгуульд оролцоогүй гэж хариулжээ.

### 2.2.2. Улс төрийн оролцооны институтжилт

Оролцогчдын 9.9 хувь нь улс төрийн намын гишүүн, 18.1 хувь нь төрийн бус байгууллага, 11.2 хувь нь сайн дурын бүлэг, эвсэл холбоод, 7.6 хувь нь шашны байгууллагад албан ёсны гишүүнчлэлтэй байна.


Зураг 23. Улс төрийн оролцооны институтжилт, насаар



18-25 насны оролцогчдын 3.3 хувь, 26-35 насны оролцогчдын 10.6 хувь, 36-45 насны 10 хувь, 46-65 насны оролцогчдын 12.2 хувь, 65 ба түүнээс дээш оролцогчдын 10.9 хувь нь улс төрийн намын гишүүнчлэлтэй байна.


Төрийн бус байгууллагын хувьд 18-25 насны оролцогчдын 17.4 хувь, 26-35 насны оролцогчдын 16.3 хувь, 36-45 насны оролцогчдын 20.4 хувь, 46-65 насны оролцогчдын 20.2 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 6.5 хувь нь төрийн бус байгууллагад, 18-25 насны оролцогчдын 9.8 хувь, 26-35 насны оролцогчдын 12.5 хувь, 36-45 насны оролцогчдын 14.2 хувь, 46-65 насны оролцогчдын 9.6 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 2.2 хувь нь сайн дурын бүлэг холбоодод, 18-25 насны оролцогчдын 9.8 хувь, 26-35 насны оролцогчдын 5.6 хувь, 36-45 насны оролцогчдын 4.8 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 8.7 хувь шашны байгууллагын гишүүнчлэлтэй байна.

Зураг 24. Улс төрийн оролцооны институтжилт, хүйсээр



Улс төрийн оролцооны институтжилтын хувьд оролцогчдын хүйсийн ялгаатай байдал нөлөөлөхгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.


**Зураг 25. Улс төрийн оролцооны институтжилт, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр**



Хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 16.2, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 26.1, харааны бэрхшээлтэй оролцогчдын 21, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 7.1, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 17.8, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 16 хувь нь төрийн бус байгууллагын гишүүнчлэлтэй, Хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 13.5, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 16.5, харааны бэрхшээлтэй оролцогчдын 10, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 11.9, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 6.8, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 8.6 хувь нь сайн дурын эвсэл холбоодын гишүүнчлэлтэй, Хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 2.7, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 10.1, харааны бэрхшээлтэй оролцогчдын 7, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 9.5, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 5.5, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 4.9,

шашны байгууллагад, Хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 13.5 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 11.2 хувь, харааны бэрхшээлтэй оролцогчдын 12 хувь, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 9.5 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 6.8 хувь, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 4.9 хувь нь улс төрийн намын гишүүнчлэлтэй байна.

**Зураг 26. Улс төрийн оролцооны институтжилт, газар зүйн байршлаар**




Газар зүйн байршлын хувьд улс төрийн намын гишүүнчлэлтэй судалгаанд оролцогчдын 8.8 хувь нь хот, суурин газарт, 33.7 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна.


### 2.2.3. Төрийн болон улс төрийн институцид итгэх итгэл

Төрийн институцид итгэх итгэлийг тодруулахад судалгаанд оролцогчдын 30.7 хувь нь хууль тогтоох институци буюу УИХ-д, 28.2 хувь нь гүйцэтгэх засаглалын институци буюу Засгийн газарт, 29.4 хувь нь Ерөнхийлөгчийн институцид, 29.7 хувь нь бүх шатны шүүх засаглалын институцид огт итгэдэггүй хэмээн хариулсан байна. Нөгөө талаас эдгээр институцид маш итгэдэг гэдэг хувь судалгаанд оролцогчдын 1.7-2.0 хувийг эзэлж байна. Нээлттэй асуулгын хүрээнд шинжилгээ хийж үзэхэд эдгээр институцийн талаарх ойлголт, яг юу хийдэг талаар мэдэхгүй, мэдээлэл байхгүй, бодлого, шийдвэр үйл ажиллагаа нь өөрсдийнх нь амьдралын чанарт нөлөөлөхгүй байгаа учраас огт итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн байна. Шүүх институцийн хувьд судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэд “шударга шүүхээр шүүлгэх” эрхээ эдэлж чадахгүй байгаа учраас огт итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн болохоо задгай асуулгад хариулахдаа дурдсан байна.

Зураг 27. Төрийн, улс төрийн болон нийгмийн бусад институцид итгэх итгэл




Зураг 28. Бусад институцид итгэх итгэл




Судалгаанд оролцогчдын 26.5 хувь нь цагдаа хүчний байгууллагад огт итгэдэггүй, 27-30.4 хүртэлх хувь нь ерөнхийдөө итгэдэг гэж хариулсан байна. Бүх шатны засаг захиргааны байгууллагын хувьд судалгаанд оролцогчдын 19.2 хувь нь огт итгэдэггүй, 24-26.5 хувь нь ерөнхийдөө итгэдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагын хувьд нийт судалгаанд оролцогчдын 19.3 хувь нь огт итгэдэггүй, 26.6-35 хувь нь ерөнхийдөө итгэдэг, 15 хувь нь маш их итгэдэг гэж тус тус хариулсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд судалгаанд оролцогчдын 26.1 хувь нь огт итгэдэггүй, 36.1 хувь нь бага зэрэг итгэдэг байна. Харин нийгмийн сүлжээний сувгуудад судалгаанд оролцогчдын 33.1 хувь нь маш их итгэдэг бол 24.6 хувь нь огт итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Зураг 29. Төрийн, улс төрийн болон нийгмийн бусад институцид итгэх итгэл, насаар



65 ба түүнээс дээш насны оролцогчдын 13 хувь УИХ болон Засгийн газарт огт итгэдэггүй, 46-65 насны оролцогчдын 27.8-28.2 хувь нь л УИХ болон Засгийн газар, бүх шатны шүүхийн байгууллагад огт итгэдэггүй гэж тус тус хариулсан байна. Бусад насны ангилал тус бүрийн 32-33 хувь нь УИХ, Засгийн газар, бүх шатны шүүхийн байгууллагад огт итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн байна. Харин 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 32.6 хувь нь бүх шатны шүүхийн байгууллагад огт итгэдэггүй гэж хариулсан байна.

Зураг 30. Төрийн, улс төрийн болон нийгмийн бусад институцид итгэх итгэл, боловсролын байдлаар






Судалгааны үр дүнгээс харахад огт сургуульд сураагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчид болон дээд боловсролтой(магистр) оролцогчдын хувьд УИХ, Засгийн газар, бүх шатны шүүхийн байгууллагад огт итгэхгүй байгаа хувь нь бусад боловсролын түвшинтэй оролцогчдоос хавьгүй илүү байгааг харж болохоор байна.


Аймаг, нийслэл, сумын төвд амьдардаг оролцогчдын 2.5 хүртэлх хувь нь УИХ-д, Засгийн газар, Ерөнхийлөгч, бүх шатны шүүхийн байгууллагад итгэдэг гэсэн хариултыг өгсөн байналтыг өгсөн байна. Төвөөс алслагдсан байрлал, хөдөө орон нутагт амьдарч байгаа оролцогчдын 3 хүртэлх хувь нь УИХ-д, Засгийн газарт, Ерөнхийлөгчид, бүх шатны хүүхдийн байгууллагад итгэдэг гэсэн хариултыг өгсөн байна. Харин 18-25 насны оролцогчдын 5.4 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн бус байгууллагад, 4.3 хувь нь орон нутгийн засаг захиргааны байгууллагад итгэдэг гэж хариулсан байна. 26-65 насны оролцогчдын 4 хүртэлх хувь нь цагдаа хүчний байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн бус байгууллага, бүх шатны засаг захиргааны байгууллагад итгэдэг гэж хариулсан байна.

**Зураг 31. Төрийн, улс төрийн болон нийгмийн бусад институцид итгэх итгэл, боловсролын байдлаар**



Дээд боловсролтой (Бакалавр) оролцогчдын 8 хүртэлх хувь, бичиг үсэг тайлагдсан бага боловсролтой оролцогчдын 2.8 хувь нь л цагдаа хүчний байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах төрийн бус байгууллага, орон нутаг, засаг захиргааны байгууллагад итгэдэг гэсэн хариулт өгсөн байна.

**Зураг 32. Улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хязгаарлалтууд**



ХБИ-ийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн хувьд судалгаанд оролцогчдын 23.4 хувь нь зам харилцаа, дэд бүтцийн хүртээмжгүй байдал, 19.8 хувь нь бие даасан сонголт хийх чадвартай бие хүн болгон төлөвшүүлэх тогтолцоо байхгүй учраас зөв сонголт хийхэд юу хэрхэн нөлөөлдгийг мэдэхгүй, 18 хувь нь сонгох, сонгогдох эрхийн талаарх ойлголт байхгүй, 16.2 хувь нь нийгмийн хандлага, 13.5 хувь нь сонгуулийн үеийн мэдээлэл, зар сурталчилгаа, нэр дэвшигчийн талаарх мэдээлэл ХБИ-дэд тохирсон биш байдаг, 9 хувь нь ХБИ өөрсдийн идэвхгүй байдал хэмээн тус тус хариулсан байна. Зам харилцаа дэд бүтцийн хүртээмжгүй байдал гэдэгт сонгуулийн санал өгөх байр гэрээс хол, сонгуулийн санал өгөх байрны гэрэлтүүлэг маш муу, сонгуулийн санал өгөх байрны орц, гарц ХБИ-дэд тохиромжгүй, гэрээс сонгуулийн санал авах байрхүртэлх зам тэргэнцэртэй иргэд явахад тохиромжгүй зэрэг хариултуудыг өгсөн байдаг. Сонгуулийн үеийн мэдээлэл, зар сурталчилгаа, нэр дэвшигчийн талаарх мэдээллийн хүртээмжгүй байдал гэдэгт мэдээлэл сурталчилгааны материал нь харааны бэрхшээлтэй иргэдэд уншиж танилцах боломж олгогдоогүй, гэрээсээ гарч чаддаггүй ХБИ-д нэр дэвшигчийн уулзалтад оролцож чаддаггүй, сонгуулийн мөрийн хөтөлбөрт ХБИ-ийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ огт тусгагдаагүй байдаг зэрэг хариултуудыг өгсөн байна.

Энэхүү судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд талуудын оролцоо чухал гэж үзээд


төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, улс төрийн нам, ХБИ-ийн өөрсдийн оролцоо чухал гэж үзэн энэхүү шинжилгээг хийсэн. Ингэхэд судалгаанд оролцогчдын 17.19 хувь нь төрийн байгууллагын оролцоо огт нөлөөлөхгүй, 26.07 хувь нь дунд зэрэг нөлөөлнө гэж үзсэн байна.

### 2.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо

18-25 насны оролцогчдын 38 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 30.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгогдох, сонгох эрхийн хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагын үүргийг ерөнхийдөө чухал гэж хариулсан байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог ерөнхийдөө чухал гэж 18-25 насны оролцогчдын 28.3 хувь, 65 ба түүнээс дээш оролцогчдын 21.7 хувь нь үзсэн байна.

**Зураг 33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо, насаар**




Улс төрийн намын оролцоог ерөнхийдөө чухал гэж 65 ба түүнээс дээш оролцогчдын 34.8 хувь нь, 18-25 насны оролцогчдын 27.2 хувь нь үзсэн байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө маш чухал нөлөөтэй гэдгийг 18-25 насны оролцогчдын 15.2 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 15.2 хувь, 26-45 хүртэлх насны оролцогчдын 13.8 хувь нь үзсэн байна.

**Зураг 34. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо, боловсролын байдлаар**




Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагын оролцоо огт нөлөөлөхгүй гэж судалгаанд оролцсон бага боловсролтой оролцогчдын 27.8 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 30.1 хувь, дээд боловсролтой (магистр) оролцогчдын 25 хувь нь хариулсан байна. Иргэний нийгмийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд хамгийн ихээр нөлөөлөх боломжтой гэж дээд боловсролтой оролцогчдын 15 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 4.4 хувь нь л үзсэн байна. Дээд боловсролтой (магистр) оролцогчдын 30 хувь нь, дээд боловсролтой (бакалавр) оролцогчдын 21.1 хувь, бага боловсролтой оролцогчдын 13.9 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 13.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө маш чухал нөлөөтэй оролцогч тал гэж үзсэн байна.

**Зураг 35. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо, газар зүйн байршлаар**




Аймаг нийслэл сумын төвд амьдардаг оролцогчдын 24-29 хувь нь, төвөөс алслагдсан байрлал, хөдөө амьдардаг оролцогчдын 14.5 хүртэлх хувь нь төрийн байгууллагын нөлөөг чухалчилсан байна. Харин иргэний нийгмийн байгууллагын нөлөөг аймаг, нийслэл сумын төвд амьдардаг оролцогчдын 37 хүртэлх хувь нь, хөдөө орон нутагт амьдардаг оролцогчдын 41.7 хүртэлх хувь нь дунд зэрэг гэж хариулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө ерөнхийдөө чухлаар нөлөөлнө гэж аймаг, нийслэл сумын төв дээр амьдардаг оролцогчдын 27.3 хүртэлх хувь, хөдөө орон нутагт амьдардаг оролцогчдын 21 хүртэлх хувь нь хариулсан байна.

**Зураг 36. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо, насаар**



Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд хувийн хэвшил маш бага нөлөөтэй 18-25 насны судалгаанд оролцогчдын 33.7 хувь, 26-35 насны оролцогчдын 35.6 хувь, 36-45 насны оролцогчдын 27.5 хувь, 46-65 насны оролцогчдын 30.9 хувь, 65 ба түүнээс дээш оролцогчдын 32.6 хувь нь тус тус хариулсан байна. Бүх шатны засаг захиргаан байгууллагын нөлөөг дунд зэрэг гэж 18-25 насны оролцогчдын 28.3 хувь, 26-35 насны 31.3 хувь, 36-45 насны оролцогчдын 33.2 хувь, 46-65 насны оролцогчдын 31.4 хувь нь үзсэн байна. 18-25 насны судалгаанд оролцогчдын 35.9 хувь, 26-35 насны оролцогчдын 21.3 хувь, 36-45 насны 18 хувь, 46-65 насны оролцогчдын 20.7 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 34.8 хувь нь Сонгуулийн ерөнхий хороог ерөнхийдөө нөлөөлнө гэж хариулсан байна.

Зураг 37. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд оролцогч талуудын оролцоо, газар зүйн байршлаар




Аймаг, нийслэл, сумын төвд амьдардаг оролцогчдын 33.7 хувь нь, хөдөө амьдардаг оролцогчдын 29.1 хувь нь хувийн хэвшлийн нөлөөг дунд зэрэг гэж хариулсан байна. Бүх шатны засаг, захиргааны байгууллагын хувьд аймаг нийслэл, сумын төвд амьдардаг оролцогчдын 24.2 хувь нь, хөдөө амьдардаг оролцогчдын 16.4 хувь нь ерөнхийдөө нөлөөлнө гэж хариулсан байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын нөлөөг аймаг, нийслэл, сумын төвд амьдардаг оролцогчдын 35.1 хувь нь, хөдөө амьдардаг оролцогчдын 29.1 хувь нь дунд зэрэг нөлөөтэй гэсэн хариултыг өгсөн байна.

### Төрийн байгууллагын оролцоо

Судалгаанд оролцогчдын 15.47 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн оролцоо огт нөлөөлөхгүй, 36.1 хувь нь дунд зэрэг нөлөөлнө, 25.9 хувь нь маш бага нөлөөтэй, 5.5 хувь нь маш их нөлөөлнө гэж үзжээ.

**Зураг 38. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоо**



ХБХХЕГ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх хууль тогтоомж, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Олон нийтэд улс төр, нийгмийн идэвх оролцоо, соёлын олон арга хэмжээгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг түгээх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралаас олсон туршлага, мэдлэг, чадварыг дэмжих, нийгмийн өөрчлөлтөд тэднийг хамгаалахад анхаарал хандуулж байна.

ХНХЯ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчилэн найруулах ажлыг зохион байгуулж, энэ хүрээнд нийгмийн оролцоо тэр дундаа улс төрийн оролцоог хангах зохицуулалтыг тусгасан байна. ХБХХЕГ-аас 2020 оны Улсын Их хурлын болон орон нутгийн сонгууль мөн Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороо болон улс төрийн намуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг хангах талаар зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос ХБИ сонгууль өгөх зарим санал авах байрыг засварлаж тохижуулж дэд бүтцийн хүртээмжийг сайжруулжээ. ХБИ-дийн сонгох эрхийг хангах чиглэгдсэн үйл ажиллагаа үе шаттай сайжирч байна. Тухайлбал, зарим нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө брайл үсгээр хэвлэж сонгогчид хүргэсэн. Мөн хараагүйчүүдийн холбооны байранд сонгуулийн хорооноос тусгай

бэлтгэсэн зааварлагч, тусалж дэмжих хүн гаргах, брайл үсгээр хэвлэсэн сонгуулийн хуудсаар харааны бэрхшээлтэй хүнээс санал хураасан. Цахим хөгжлийн хороотой хамтран хэвлэл, мэдээллийн байгууллагад албан бичиг явуулж, телевиз, сайтын мэдээг дохионы хэлмэрчээр хүргэж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Конрад Аденауэрийн сангаас жил бүр хөгжлийн бэрхшээлтэй 20 залуучуудыг сонгож, улс төрийн боловсрол олгох, мэдлэг ур чадварыг дээшлүүлдэг ч төгсөгчдийн манлайлал бага байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад бүх шатны төрийн байгууллага, улс төрийн нам, эвслэл, иргэний нийгэм, аж ахуйн нэгж байгууллага, иргэд бүхий л түвшинд мэдлэг ойлголттой болж, дэмжиж идэвхтэй байх шаардлагатайг онцлов.

#### Тохиолдол

...хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны санхүүжилт зөвхөн хөдөлмөр эрхлэлтэд чиглэгдсэн байдаг. Харин бусад нийгмийн оролцоо хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилт байдаггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйл болон Улс төрийн намын тухай хуулиар ХБИ-ний сонгох, сонгогдох эрхийн талаар зохицуулалсан ч нарийвчилсан зохицуулалт дутмаг байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний квотоор санхүүжилт олгох заалт байгаа ч ХБИ-ний жендэрийн квот тодорхойгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад тодорхой квот тогтоогоогүй тул намууд дураараа амлалт өгч байна. СЕХ-д зөвлөмж хүргүүлж, ХБИ талаар ойлголт өгөх сургалтад сонгуулийн штабыг хамруулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангах, улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намын ойлголтыг өөрчлөх, зайлшгүй шаардлагатай байна.

...ХБИ дийлэнхдээ мөнгө, санхүүгийн дэмжлэг л хүсдэг, хамтран ажиллахыг санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэж ойлгодог, өөрсдийгөө чадваржуулах тал дээр анхаардаггүй.

(Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хийсэн ярилцлагаас)

МУИС-ийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн асуудал хариуцсан тусгай нэгж байдаггүй ч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан МУИС-ийн суралцагчдад чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

- Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, эссэ, салбар дундын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;



- “Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ”-г хийж, суралцагчид болон багш ажилтанд чиглэсэн эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Жишээ нь: Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан дараах үйлчилгээг үзүүлэх журам батлагдаж, төрийн буцалтгүй тусламжид хамруулах, боловсролын зээлийн үйлчилгээнд хамруулах, оюутны дотуур байранд давуу эрхтэй сонголт хийлгэх, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтарсан хөтөлбөр (эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа) хэрэгжүүлж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургаж, чадавхжуулахад сургалтын орчин, түүний хүртээмж, ХБИ-ний сэтгэл зүй, нөхцөл байдлыг даван туулах чадвар, материаллаг бааз, ХБИ-ийг суралцахад зориулсан шаардлагатай техник, тоног төхөөрөмж, дэд бүтцийн дутагдал, санхүүгийн боломж зэрэг бэрхшээл тулгарч байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд МУИС төсвийн хэдэн хувийг зарцуулдаг талаар нарийн мэдээлэл байхгүй байна. ҮСХ-ны мэдээллээс харахад 2003 онд ХБИ 60,435 байсан бол 2022 онд 115,115 болж өссөний 57,4 хувь нь эрэгтэйчүүд байна. ХБИ-дийн тоо жил тутам өсөж, бүр 2 дахин өссөн байна. Уг өсөлтөд нөлөөлж байгаа нөхцөлийг цаашид засах, залруулах, бууруулахад ХБИ-ний өөрсдийн оролцоо чухал байна. Тухайн жилийн орлогын хэдэн хувийг ХБИ-дэд зарцуулагдаж байгаа талаарх нэгдсэн мэдээлэл бага байна, зөвхөн зарим нэг тайланд ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд зарцуулсан дүн мэдээлэл л байна. Мөн нийтийн тээврийн үйлчилгээнд ХБИ-ийн зорчсон тоонд үндэслэсэн санхүүжилт олгодог гэсэн боловч тодорхой мэдээлэл байхгүй, мөн ХБИ-дэд чиглэсэн эрүүл мэнд, халамжийн бодлого, үйл ажиллагааны мэдээлэл дутмаг байгаа талаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн ахлах багш өгсөн мэдээлэлдээ онцолсон.

## Тохиолдол


...Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор хууль эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч учир дутагдалтай асуудал байна. Тухайлбал, ХБИ-ний сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах асуудал гарч болзошгүй тул урьдчилан сэргийлж энэ асуудлыг зохицуулах дүрэм, журам гаргах шаардлагатай. Сэтгэц, хэл яриа, хөдөлгөөн, хараа, сонсгол, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй зэрэг олон бүлгүүдийн төлөөлөл сонгогдох эрхээ эдэлж болно, тиймээс сонгуулийн үйл ажиллагаа, санхүүжилт, мөрийн хөтөлбөрийн уялдааг хангах шаардлагатай.

(МУИС-ийн Бизнесийн сургуулийн ахлах багштай хийсэн ярилцлагаас...)

### Улс төрийн намын оролцоо

Оролцогчдын 22.78 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжилтэд улс төрийн намын оролцоо ерөнхийдөө нөлөөтэй, 18.34 хувь нь огт нөлөөлөхгүй гэж үзсэн байна.

Зураг 39. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийг нэмэгдүүлэхэд улс төрийн намын оролцоо



Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн нам хамгийн чухал үүрэгтэй институци учраас улс төрийн намын хувьд энэ асуудалд ямар байр суурьтай байх ёстой талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 62 хувь нь улс төрийн нам гэж ямар байгууллага болох талаар огт ойлголт байхгүй. 6.1 хувь нь улс төрийн нам ХБИ-ийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд идэвхтэй ажиллах, 7.2 хувь нь улс төрийн намын байрны хувьд ХБИ орж гарахад тохиромжтой, хүртээмжтэй дэд бүтцийг бий болгох, 6.3

хувь нь улс төрийн намын квотод ХБИ-ийг оруулах шаардлагатай, 4.4 хувь нь ХБИ-ийн мэдээлэл хүлээж авах ялгаатай байдалд тохирсон улс төрийн мэдлэг боловсрол олгоход анхаарах, 4.1 хувь нь ХБИ-тэй санал солилцдог тэднийг сонсдог байх, 3.9 хувь нь улс төрийн намын дотоод бүтцэд ХБИ орж ажиллах боломжоор хангах, 3.3 хувь нь сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрт ХБИ-ийн асуудлаар тусгадаг байх, 2.8 хувь нь ХБИ-ийг бие даан нэр дэвших боломжоор хангах шаардлагатай гэж үзжээ.

#### Тохиолдол


...Нам сөргөөр ханддаггүй ч санхүүгийн дэмжлэггүй байсан. Дэмжиж байгаа төрийн бус байгууллагууд сайн дураараа ажилласан. Цаг хугацаа нь богино байсан.

.... 2008 онд намын жагсаалтаар Социалдемократ намаас нэр дэвшсэн ч нам нь өөрөө сурталчилгаагаа хий гэсэн. Мөн л мөнгөгүй учир нэг удаа сонин гаргаж тараагаад таарсан. Социалдемократ намыг хүмүүс сайн мэдэхгүй ойлгохгүй байсан, олонд танигдаагүй, ойлгоогүй байсан байх нэг ч суудал аваагүй. Мөнгөгүй болохоор юу ч хийж чадахгүй болсон.

... Намын мөрийн хөтөлбөрт асуудлаа тусгуулж байж тэр хүн хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар асуудал ярих боломжтой болно.

(УИХ-д нэр дэвшиж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас)

**Зураг 40. ХБИ-ийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намын анхаарах асуудал**



Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд улс төрийн намын гүйцэтгэх үүргийн талаар тодруулахад МАН-ын дэргэдэх Социал демократ Монголын залуучуудын холбооны төлөөлөл “МАН нь тэгш хүртээмжтэй байдлыг эрхэмлэж, хүний эрхийн мэдрэмжийн, дэвшилтэт нам байх зорилтыг өнгөрөгч 30 дугаар их хурлаараа тодорхойлон ХБИ-ийн улс

төрийн оролцоог үргэлж дэмжиж, бодлого шийдвэртээ оролцуулж, оролцооны хүртээмжийг хангаж, хүний эрхийг дээдэлж ажиллаж байна. Тухайлбал, МАН-ын төв байр буюу Тусгаар тогтнолын ордны орчны хүртээмжийн судалгааг хийж, бүх иргэдэд хүртээмжтэй байхаар намын байрны 1 дүгээр давхрын ариун цэврийн өрөөг ХБИ-д хүртээмжтэй хэлбэрээр тохижуулж, брайл үсэг бүхий наалтууд байрлуулжээ.

“Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ 2023 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт”-ийн судалгааг хийж, 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр судалгааны тайлан, санал, зөвлөмжийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, Засгийн газар, СЕХ, ХЭҮК, ХНХЯ, Агентлагаас гадна 28 төрийн бус байгууллагын 80 гаруй төлөөлөл, Парламентад суудалтай 3 намын удирдлагууд оролцуулсан. Уг хэлэлцүүлэгт оролц улс төрийн нам болон төрийн байгууллагууд цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төр, нийгмийн эрх тэр дундаа сонгох, сонгогдох эрхийг бүрэн, дүүрэн эдлүүлэх тал дээр дэмжиж ажиллахаа мэдэгдсэн. Судалгааны хүрээнд МАН-ын төв байр болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж санал, зөвлөмжийг авсан. Судалгааны зөвлөмж болон хүртээмжийн үнэлгээний зөвлөмжийн дагуу намын зүгээс цаашид анхаарч засан сайжруулалтыг хийж ажиллахаар төлөвлөсөн байна. МАН-ын хувьд хөгжлийн бэрхшээлтэй гишүүд, сонгогчдын асуудлыг хариуцсан тусдаа нэгжгүй байна. МАН-ын дарга, МУ-ын Ерөнхий сайд 2024 оны УИХ-ын сонгуулийн жагсаалтын эхний 5-д ХБИ-ийг нэр дэвшүүлэхээ мэдэгдсэн. Мөн өөрийн нийгмийн бодлогын зөвлөхөөр ХБИ-ийг ажиллуулж байгаа нь тус намын хувьд сайн туршлагын эхлэл гэж харж байгаа юм байна. ХЭДБХ-нд судлаачаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг дараах байдлаар авч үзсэн байна.

### Хүснэгт 3. Оролцогч талуудын үүрэг хариуцлага

Оролцогч талууд	Хүлээх үүрэг хариуцлага	Албан, албан бус аль нь болох
Бүх шатны төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Бүхий л төрлийн үйлчилгээгээ хүртээмжтэй болгох</li> <li>- Харилцаа хандлагаа сайжруулах</li> <li>- дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллах</li> <li>- Эрхээ бүрэн, дүүрэн эдэлж чадаж байгаа эсэх дээр хяналт тавих</li> </ul>	Албан

Улс төрийн нам	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлого, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллах</li> <li>- Нэр дэвшигч нартаа нийгмийн ялгаатай хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар хэрхэн мөрийн хөтөлбөр, танилцуулга боловсруулах талаар сургалт зохион байгуулах</li> <li>- Намаас болон бие даан нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааг хэрхэн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрт тохирсон байдлаар мөрийн хөтөлбөр болон танилцуулга бэлтгэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах</li> </ul>	Албан
Иргэний нийгмийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Олон нийтэд чиглэсэн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах</li> <li>- Төрийн байгууллагуудтай үр дүнтэй, түншлэн хамтран ажиллах</li> <li>- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, хяналт үнэлгээ, мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулах, ингэхдээ ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх</li> </ul>	Албан бус
Хувийн хэвшил	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах</li> </ul>	Албан бус
Иргэд	<ul style="list-style-type: none"> <li>- Бусдыг ялгаварлан гадуурхахгүй байх</li> </ul>	Албан бус

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг чадавхжуулахад дэд бүтцийн болон мэдээллийг хүртээмжгүй байдал, боловсролын хүртээмжгүй байдал, нийгмийн сөрөг хандлага, санхүүжилт хангалтгүй зэрэг саад бэрхшээлүүд байдаг гэжээ.

#### Тохиолдол

...АН-ын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар тусгайлсан бодлого байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд сонгох, сонгогдох эрх нь чөлөөтэй. Мөн ямар нэгэн квот байхгүй. Намын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог дэмжихэд тодорхой ажил хийгдээгүй...

(АН-ын хорооны гишүүн, .... хорооны үүрийн даргатай ярилцсан ярилцлагаас...)

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангах, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд улс төрийн намын хувьд:**


1. ХБИ-дэд улс төрийн оролцоотой байх боломж буюу хүртээмжийг нэмэгдүүлэх, оролцуулахаа зарлах, тунхаглах нэг асуудал, оролцох боломж олгох буюу хүртээмжийг бий болгох

2. Төвлөрсөн арга хэмжээнүүдэд ХБИ-ийг оролцуулдаг байх.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тухайлан авч үзэхээ болих.
4. Оюуны санааны буюу эрх зүйн чадамжгүй ХБИ-ээс бусад ХБИ-ийн оролцоог нэмэгдүүлэхэд намын бүх шатны нэгжүүдээр дамжуулж анхаарах, хэрэгжүүлэх гэж үзэж байгаагаа судалгаанд хамрагсад дурдсан байна.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрсдийн идэвх, оролцоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд тухайн хүний өөрийн оролцоо чухал эсэхийг үнэлэхэд судалгаанд оролцогчдын 25.9 хувь нь ерөнхийдөө нөлөөлнө, 14.6 хувь нь огт нөлөөлөхгүй, 26.6 хувь нь дунд зэрэг, 19.2 хувь нь бага зэрэг нөлөөлнө хэмээн үзсэн байна.

Зураг 41. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд ХБИ-ийн өөрийн идэвх оролцоо



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуульд нэрээ дэвшүүлэх, сонгогдох байдал маш бага байна. УИХ болон орон нутгийн долоон удаагийн сонгуульд нийт зургаан хөгжлийн бэрхшээлтэй хүн нэр дэвшиж, өрсөлджээ. Тэдгээр хүмүүсийн тав нь хөдөлгөөний бэрхшээлтэй, нэг нь сонголын бэрхшээлтэй бөгөөд хүйсийн хувьд таван эрэгтэй, нэг эмэгтэй нэр дэвшигч байна. УИХ-ын гишүүнээр хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгогдож байгаагүй.

#### Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд нэр дэвшсэн байдал

Д/д	Төрөл	Он	Тойрог	Нам, эвсэл, бие даасан байдал
1	Улсын Их Хурал	2004	63 дугаар тойрог	Ардчилсан нам
			Баянгол дүүрэг	Иргэний зориг ногоон нам
		2008	Сонгинохайрхан дүүрэг	Бие даагч
		2012	Баянзүрх дүүрэг	Бие даагч
		2016	Сэлэнгэ аймаг	Тусгаар тогтнол эв нэгдлийн нам
		2020	Хэнтий аймаг	Шинэ нам
		2020	Баянзүрх дүүрэг	Ардчилсан нам
2	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2016, 2020	Чингэлтэй дүүрэг, 16 дугаар тойрог	Ардчилсан нам
Нийт		7		

#### Тохиолдол

...Өөрийгөө бэлтгэх явдал чухал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхгүй ядуу, ахмад настан, хүүхэд гээд өргөн хүрээний асуудлыг бодох ёстой.

...Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвшээд анхаарлыг татаад байх нь ийм хүмүүс нэр дэвших чухал юм гэдэг мессеж нийгэмд өгөх нь маш чухал. Их хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүн байх ёстой гэдгийг ойлгуулах, мессежийг өгөх ёстой.

(УИХ-д нэр дэвшиж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас)

Сонгуульд нэрээ дэвшүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогдох эрхээ эдлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг бодитоор хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, баталгаажуулахад санал бодлоо хэлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, нийгмийн уламжлалт хандлагыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулах зорилгоор сонгуульд өрсөлдөх шийдвэр гаргасан байна.<sup>146</sup> Тэдний хувьд хандив цуглуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон биечлэн сурталчилгаа хийх, материал хэвлүүлэх тараах, сонгуулийн штабын байрны болон ухуулагчдын зардлаа төлөх зэрэг санхүүгийн асуудал хамгийн хэцүү, дохионы хэлмэрчгүй ажилласан, уулзалтын байрны хүртээмжгүй байдал, сонгогчдод өөрийгөө таниулахад бэрхшээл учирсан гэжээ.

<sup>146</sup> Энэ үзүүлэлт нь улс төрийн намууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйл ажиллагаандаа идэвхтэй оролцуулахыг дэмжих бодлого байхгүйг илтгэж байна. Энэ талаарх дэлгэрэнгүй дүгнэлтийг судалгааны 153-154 дэх хэсгээс үзнэ үү. ХЭҮК, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт", 2024 он, 149 дэх тал.

## Тохиолдол

... Дохионы орчуулагчгүй ажилласан. Санхүүгийн чадамж муутай байсан. Нэр дэвшихэд шалгуур хангахгүй гэсэн шалтгаанаар хассан. Захиргааны хэргийн шүүхэд давж заалдаад шүүхэд ялсан. Гэхдээ шүүхийн захирамжийн хариуг 5-7 хоног хүлээсэн. Хугацаа алдсан.

... Олонд танигдсан хүн биш бол нийгэм болон сонгогчид огт танихгүй, хүлээж авдаггүй  
...Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад хүмүүсийн дэмжлэгтэй ямар ч байсан сонгуульд оролцож амжилттай дуусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өрсөлдөж болдгийг харуулж 8000 орчим хүний санал авч байсан.

...баг бүрдүүлж багаараа сайн ажиллах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад өрсөлдөгч нараас эдийн засгийн хувьд дутмаг байдаг учраас санхүүжилтээ бэлтгэхэд анхаарахгүй бол өрсөлдөгчдөөс хол хоцордог.

... Санал авах байр, уулзалтын байрнуудын орц гарц нь хүндрэлтэй, ирж очих унаа машин байхгүй, менежерийн машинаар явж байсан. Сурталчилгааны самбар байршуулах хэцүү байсан.


(УИХ-д нэр дэвшиж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрөө оролцоо, тэд сонгох, сонгогдох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна. Улс төрийн намууд нэр дэвшүүлэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрийг огт дэвшүүлдэггүй, харин оролцохыг сонирхсон цөөн тооны хүмүүс жижиг намын нэрийн өмнөөс нэр дэвших тохиолдол сонгуулиудад тогтмол ажиглагдаж байдаг. Улс төрийн намууд ТББ-уудын хүсэлтээр мөрийн хөтөлбөртөө тэдний асуудлыг тусгахыг амлаж, зарим асуудлыг тусгадаг. Гэвч асуудлыг ерөнхий тусгадаг учир хэрэгжилтийг үнэлэхэд төвөгтэй байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр хийсэн үйл ажиллагаа тодорхой бус байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг дэмжигч хүчин зүйлүүд үр дүнтэй байдаг гэж үзэхгүй. Харин ч хүртээмжтэй орчин бүрдүүлэн мэдээллээр хангах, орох гарах нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байгаа нь тэд бусдын адил тэгш улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна. Энэ нь дэд бүтцийн саадаас гадна удаан хугацаагаар нийгмээс хөндийрсөн, зохих боловсролыг эзэмшиж чадаагүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмд утга учиртай оролцох боломжийг бүрэн болон ямар нэг хэмжээгээр хааж, хязгаарладаг болохыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын зүгээс үзэж байна.



## Бүх шатны Засаг захиргааны байгууллагын оролцоо

Зураг 42. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд бүх шатны засаг захиргааны байгууллагын оролцоо



Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд бүх шатны засаг захиргааны байгууллагын оролцоо маш их чухал гэж судалгаанд оролцогчдын 5.87 хувь нь үзсэн бол 31.52 хувь нь дунд зэрэг, 23.78 хувь нь бага зэрэг, 21.06 хувь ерөнхийдөө нөлөөлнө гэж үзсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 17.48 хувь нь огт нөлөөлөхгүй гэсэн хариултыг өгчээ.


## Хэвлэл, мэдээллийн байгууллагын оролцоо

### Тохиолдол

... Телевизороор ярилцлага өгөхөд намаас нь зохицуулсан учир хүндрэл гараагүй намаас нэр дэвшихийн онцлог нь тэр юм билээ.

(УИХ-д нэр дэвшиж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас)

Зураг 43. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо




Судалгаанд оролцогчдын 34.9 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд дунд зэрэг нөлөөлнө гэж үзсэн байна. Харин 26.2 хувь бага зэрэг, 14.6 хувь нь дунд зэрэг, 8.4 хувь нь маш их нөлөөлнө гэсэн бол 15.7 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо огт нөлөөлөхгүй гэж үзсэн байна.

### Сонгуулийн ерөнхий хорооны оролцоо


Судалгаанд оролцогчдын 8.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд сонгуулийн ерөнхий хорооны оролцоо маш их нөлөөлнө, 23.5 хувь нь бага зэрэг, 24.3 хувь нь дунд зэрэг, 22.9 хувь нь ерөнхийдөө нөлөөлнө гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдын 20.34 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд огт нөлөөлөхгүй гэж үзжээ.

**Зураг 44. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд сонгуулийн ерөнхий хорооны оролцоо**




Судалгаанд оролцогчдын 5.87 хувь нь өмнө дурдсан оролцогч талуудаас өөр оролцогчийн нөлөөлөл маш их чухал гэж үзсэн байна. Харин 32.52 хувь нь бусад оролцогч талуудын нөлөө огт байхгүй гэж үзсэн байна.

**Зураг 45. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд бусад талын оролцоо**




Зураг 46. Сонгох, сонгогдох эрхийн төлөв байдал



Судалгаанд оролцогчдын 33.52 хувь нь сонгох сонгогдох эрхийн төлөв байдлыг дундаж гэж үнэлсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 8.02 хувь нь энэ эрхээ хангалттай сайн эдэлж байна гэж хариулсан байна. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхээ хангалттай эдэлж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Зураг 47. Бодлого төлөвлөж, шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо




Судалгаанд оролцогчдын 12.61 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бодлого төлөвлөж, шийдвэр гаргах үйл явцад хангалттай сайн оролцож чадаж

байна гэж хариулсан байна. Нийт оролцогчдын 34.24 хувь нь бодлого төлөвлөж, шийдвэр гаргах үйл явц дах оролцоогоо дундаж, 20.20 хувь нь ерөнхийдөө оролцож чадаж байна, 19.77 хувь нь огт оролцож чадахгүй байгаа гэж тус тус хариулсан байна.


### Нийгмийн бусад оролцооны идэвх

Судалгаанд оролцогчдын 39.83 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцож, шийдвэр гаргах бодлого төлөвлөх үйл явцад оролцохыг маш их хүсдэгээ илэрхийлсэн байдаг. Харин 14 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцох ямар ч сонирхолгүй болохоо илэрхийлсэн байдаг.

Зураг 48. Нийгмийн харилцаанд оролцох эрмэлзэл




Зураг 49. Нийгмийн бусад оролцооны идэвх



Судалгаанд оролцогчдын нийгмийн бусад оролцооны идэвх (нийгэмд тустай үйл хийх, өөрийгөө хөгжүүлэх шийдвэр гаргах гэх мэт)-ийг судлахад 33.67 хувь нь дундаж, 21.06 хувь нь маш идэвхтэй, 20.49 хувь нь ерөнхийдөө идэвхтэй, 14.78 хувь нь огт идэвхгүй хэмээн хариулсан байна.


Тухайлбал, 18-25 насны оролцогчдын 33.7 хувь, 26-35 насны оролцогчдын 40, 36-45 насны оролцогчдын 46 хувь, 46-65 насны оролцогчдын 42 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 13 хувь нь бие даан нийгмийн харилцаанд орохыг маш ихээр хүсдэг болохоо илэрхийлсэн байдаг. Харин 18-25 насны оролцогчдын 18.5 хувь, 26-35 насны оролцогчдын 15.6 хувь, 36-45 насны 25.1 хувь, 46-65 насны оролцогчдын 26.1 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 4.3 хувь нь л гадагшаа гарах, найз нартайгаа уулзах, хоббигоо хөгжүүлэх зэрэг нийгмийн оролцооны асуудалд бие даан шийдвэр гаргаж чаддаг гэж хариулсан байна.

Зураг 50. Нийгмийн бусад оролцооны идэвх, насаар



Сонгуульд оролцох саналаа өгөх, намд гишүүнээр элсэх, улс төрийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг улс төрийн оролцооны хувьд 18-25 насны оролцогчдын 8.7 хувь, 26-35 насны оролцогчдын 10 хувь, 36-45 насны оролцогчдын 15.6 хувь, 46-65 насны 12.8 хувь, 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 6.5 хувь нь л бие даан шийдвэр гаргаж чаддаг гэж хариулжээ.


Зураг 51. Нийгмийн бусад оролцооны идэвх, боловсролын байдлаар



Дээд боловсролтой оролцогчдын 61 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 40.3 хувь, бага боловсролтой оролцогчдын 38.9 хувь нь нийгмийн харицлаанд бие даан оролцох хүсэлтэй байдаг. Харин өөртөө хамаатай асуудлаар шийдвэр гаргахад дээд боловсролтой оролцогчдын 39 хүртэлх хувь, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 4.3 хувь, бичиг үсэг тайлагдсан бага боловсролтой оролцогчдын 16.7 хувь, бүрэн бус дунд боловсролтой оролцогчдын 21.4 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 19.9 хувь, техник мэргэжлийн тусгай боловсролтой оролцогчдын 12.8 хувь нь л бие даан шийдвэр гаргаж чаддаг гэж хариулсан байна.

Улс төрийн оролцоотой холбоотой асуудлаар бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 6.4 хувь, бага боловсролтой оролцогчдын 13.9 хувь, бүрэн бус дунд боловсролтой оролцогчдын 11.9 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 10.2 хувь, дээд боловсролтой (бакалавр) оролцогчдын 22 хувь, техник мэргэжлийн тусгай боловсролтой оролцогчдын 7.7 хувь нь л бие даан шийдвэр гаргаж чаддаг гэж хариулсан байдаг.


**Зураг 52. Нийгмийн бусад оролцооны идэвх, хүйсээр**




Бие даан нийгмийн харилцаанд орох хүсэл, өөртөө хамааралтай асуудлаар бие даан шийдвэр гаргах, улс төрийн оролцооны шийдвэр гаргах үйл явцад хүйсийн ялгаатай байдал ажиглагдахгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.



Зураг 53. Нийгмийн бусад оролцооны идэвх, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр



Зураг 54. Нийгмийн бусад оролцооны идэвх, газар зүйн байршлаар



Хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 26.1 хувь, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 21 хувь, харааны бэрхшээлтэй оролцогчдын 20 хувь, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 23.8 хувь, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 21 хувь, оюуны хомсдолтой оролцогчдын 6.5 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 5.5 хувь нь өөрт хамаатай аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад бие даан оролцож шийдвэр гаргаж чаддаг гэж хариулсан байна. Харин улс төрийн оролцооны хувьд хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 19.1 хувь, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 10.8 хувь, сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 8.8 хувь, харааны бэрхшээлтэй оролцогчдын 8 хувь нь л бие даасан шийдвэр гаргаж чаддаг гэж хариулсан байна.

## Бие даах чадварыг үнэлэх

Хүснэгт 5. Ахуйн болон нийгмийн харилцаанд бие даан хийж чаддаг үйлдэл

АХУЙН ХҮРЭЭНД БИЕ ДААН ХИЙЖ ЧАДДАГ ҮЙЛДЭЛ	4.3	НИЙГМИЙН ХАРИЛЦААН БИЕ ДААН ХИЙЖ ЧАДДАГ ҮЙЛДЭЛ	3.76
[Хөдөлж явах]	4.16	[Өөртөө болон бусдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх]	3.96
[Суух, босох]	4.28	[Өөрт тулгамдаад байгаа асуудлаа бусадтай хуваалцах]	3.69
[Дээд, доод давхарт гарах]	4.16	[Өөртөө болон гэр бүлдээ худалдан авалт хийх]	3.79
[Хоол идэх, цай уух]	4.37	[Эмнэлэгт үзүүлэх]	3.77
[Шүд угаах, үс самнах]	4.36	[Төрийн үйлчилгээ авах]	3.70
[Угаалга хийх]	4.15	[Соёл үзвэрийн газарт очих, үзвэр үзэх]	3.58
[Хувцас өмсөх, тайлах]	4.29	[Өөрийнхөө асуудлыг бие даан шийдвэрлэх]	3.79
[Усанд орох]	4.14	[Бие даан сонголт хийх]	3.85
[Ариун цэврийн өрөө орох]	4.28	[Нийгэмд болж байгаа асуудал, үйл явцын талаар мэдэлэлэл авах, мэдэх эрх]	3.76
[Хүнд хөнгөнөөр бие засах]	4.21		

Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан хийдэг үйлдлийг ахуйн (гэр дотор) болон нийгмийн хүрээнд бие даан хийж чаддаг үйлдлийг тодруулах асуулгуудыг оруулсан. Ингэхдээ 1 бол бие дааж огт хийж чадахгүй, 2 ихэнхдээ бие дааж хийж чаддаггүй, 3 бол бусдын дэмжлэгийг хааяа авдаг, 4 бол ихэнхдээ бие дааж хийдэг, 5 бол ганцаараа бие дааж хийж чаддаг үйлдэл гэж судалгаанд оролцогчдоор үнэлүүлсэн. Ахуйн хүрээнд бие даан хийж чаддаг үйлдэл нь нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээс харьцангуй олон байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид ахуйн хүрээнд бие даан хийдэг үйлдлүүдээ дунджаар 4.3, нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээ харьцангуй багаар буюу 3.76 гэж үнэлсэн байна. Энэ нь судалгаанд оролцогчдын хувьд ахуйн хүрээнд зарим үйлдлийг бие даан хийж чаддаг байхад нийгмийн харилцаанд бие даан хийж чаддаг үйлдэл хязгаарлагдмал байгааг харуулж байна.


Хүснэгт 6. Нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдэл


[Нийгэмд болж байгаа асуудал, үйл явцын талаар мэдэлэлэл авах, мэдэх эрх]	Буса	Mean	3.98	[Бие даан сонголт хийх]	Буса	Mean	4.10	[Өөрийнхөө асуудлыг бие даан шийдвэрлэх]	Буса	Mean	4.01
			Median		5.00				Median	5.00	
	Оюун	Mean	2.52		Оюун	Mean	2.52		Оюун	Mean	2.42
		Median	2.00			Median	2.00			Median	2.00
	Сонс	Mean	3.96		Сонс	Mean	4.09		Сонс	Mean	4.05
		Median	4.00			Median	5.00			Median	5.00
	Сэтг	Mean	2.95		Сэтг	Mean	3.08		Сэтг	Mean	2.97
		Median	3.00			Median	3.00			Median	3.00
	Унал	Mean	4.19		Унал	Mean	4.07		Унал	Mean	4.12
		Median	5.00			Median	4.00			Median	5.00
	Хара	Mean	3.97		Хара	Mean	4.05		Хара	Mean	4.08
		Median	4.50			Median	5.00			Median	5.00
	Хөдө	Mean	3.86		Хөдө	Mean	3.91		Хөдө	Mean	3.81
		Median	5.00			Median	4.00			Median	4.00
	Хэл	Mean	3.62		Хэл	Mean	3.95		Хэл	Mean	3.89
		Median	4.00			Median	4.00			Median	4.00

[Соёл үзвэрийн газарт очих, үзвэр үзэх]	Буса	Mean	3.81	[Төрийн үйлчилгээ авах]	Буса	Mean	3.87	[Эмнэлэгт үзүүлэх]	Буса	Mean	3.92
		Median	4.00			Median	4.00			Median	4.00
	Оюун	Mean	2.52		Оюун	Mean	2.61		Оюун	Mean	2.77
		Median	3.00			Median	3.00			Median	3.00
	Сонс	Mean	3.86		Сонс	Mean	3.95		Сонс	Mean	4.06
		Median	4.00			Median	4.00			Median	4.00
	Сэтг	Mean	3.01		Сэтг	Mean	3.22		Сэтг	Mean	3.33
		Median	3.00			Median	3.00			Median	4.00
	Унал	Mean	3.90		Унал	Mean	4.10		Унал	Mean	4.12
Median		4.00	Median	4.00		Median	4.00				
Хара	Mean	3.76	Хара	Mean	3.93	Хара	Mean	3.97			
	Median	4.00		Median	4.00		Median	4.00			
Хөдө	Mean	3.52	Хөдө	Mean	3.63	Хөдө	Mean	3.71			
	Median	4.00		Median	4.00		Median	4.00			
Хэл	Mean	3.51	Хэл	Mean	3.70	Хэл	Mean	3.68			
	Median	4.00		Median	4.00		Median	4.00			
[Өөртөө болон гэр бүлдээ худалдан авалт хийх]	Буса	Mean	3.91	[Өөрт тулгамдаад байгаа асуудлаа бусадтай хуваалцах]	Буса	Mean	3.88	[Өөртөө болон бусдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх]	Буса	Mean	4.08
		Median	4.00			Median	4.00			Median	5.00
	Оюун	Mean	2.68		Оюун	Mean	2.55		Оюун	Mean	2.65
		Median	3.00			Median	2.00			Median	3.00
	Сонс	Mean	4.21		Сонс	Mean	3.90		Сонс	Mean	4.27
		Median	5.00			Median	4.00			Median	5.00
	Сэтг	Mean	3.33		Сэтг	Mean	2.86		Сэтг	Mean	3.42
		Median	5.00			Median	3.00			Median	4.00
	Унал	Mean	4.00		Унал	Mean	4.02		Унал	Mean	4.33
Median		4.00	Median	4.00		Median	5.00				
Хара	Mean	3.92	Хара	Mean	4.01	Хара	Mean	4.14			
	Median	4.00		Median	4.00		Median	5.00			
Хөдө	Mean	3.73	Хөдө	Mean	3.76	Хөдө	Mean	3.98			
	Median	4.00		Median	4.00		Median	4.00			
Хэл	Mean	3.92	Хэл	Mean	3.54	Хэл	Mean	4.03			
	Median	4.00		Median	4.00		Median	4.00			


Ахуйн хүрээнд дэх судалгаанд оролцогчдын өгсөн дундаж үнэлгээ нь 4.3 буюу ихэнхдээ бие дааж хийдэг гэсэн хариултыг өгсөн байна. Ахуйн хүрээнд хийгддэг үйлдэл тус бүр дээр хөгжлийн бэрхшээлийн онцлогоор авч үзэхэд хөдөлж явах болон суух босох үйлдэл дээр хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчид дунджаас доогуур үнэлгээ өгсөн байгаа бөгөөд энэ нь тухайн үйлдлийг гүйцэтгэхэд бусдын тусламжийг авдаг гэдгийг илэрхийлж байна. Дээшээ, доошоо буух, хоол унд идэж уух, шүдээ угаах, үсээ самнах, угаалга хийх зэрэг үйлдлүүдийн хувьд оюуны, хөдөлгөөний, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчид хувьд бие даан хийж чаддаггүй гэж хариулсан байна.

Зураг 55. Нийгмийн харилцаанд бие даан хийж чаддаг үйлдэл, хөгжлийн бэрхшээлийн ялгаатай хэлбэрээр







23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?




23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?




23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?



23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?




23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?



23. Та ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?

Нийгэмд болж байгаа асуудал, үйл явцын талаар мэдээлэл олж авах, соёл үзвэрийн газар очих, төрийн үйлчилгээ авах, эмнэлэгт үзүүлэх, худалдан авалт хийх, бусадтай сэтгэл санаагаа хуваалцах, бие даан сонголт хийх оюуны болон сэтгэц, хөдөлгөөний, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын хувьд бусад хэлбэрийн бэрхшээлтэй оролцогчидтой харьцуулахад бие даан хийх чадвар сул байгаа судалгааны үр дүнгээс харагдаж байна.


Зураг 56. Буруу ойлголт



Судалгаанд оролцогчдын 14.8 хувь нь бусдаас хамааралтай байгаа хэрэгцээнүүдээс болоод туйлддаг бол 3.9 хувь нь нийгмийн бусад гишүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнө хариуцлага хүлээсэн юм шиг харагддаг байдлаас залхдаг, 4.2 хувь нь өөрийгөө тийм ч эерэгээр мэдэрч чаддаггүй, 4.2 хувь нь өөрийгөө хэнд ч хэрэггүй хүн гэдэгтэй, 5.2 хувь нь өөрийгөө ямар ч хэрэггүй хүн юм шиг санагддаг гэж хариулсан байна. Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрийгөө бусдаас өөр ялгаатай гэж үзэх (стигма) байдал маш бага байгаа нь харагдаж байна.


Хувь хүний хөгжлийн чадавх, нийгмийн орчноос ирэх нөлөөллийг даван туулах чадварыг үнэлсэн дундаж оноо нь оюуны бэрхшээлтэй иргэдийн хувьд харьцангуй бага буюу 2.35 байна. Харин энэ 2 чадварын хувьд оюуны, сэтгэцийн бусад хэлбэрийн бэрхшээлтэй оролцогчдын 50 хувь нь дундажаас доогуур буюу 2 гэж үнэлсэн байна.

Зураг 57. Өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө сэтгэл хангалуун байх



Өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө сэтгэл хангалуун байх тал дээр оюуны бэрхшээлтэй оролцогчид өөрсдийгөө дунджаас доогуур гэж үнэлсэн байна. Энэ 2 чадварын хувьд оюуны болон сэтгэцийн хэлбрээс бусад бэрхшээлтэй оролцогчдын 50 хувь нь дунджаас дээгүүр гэж үнэлсэн байна.







Зураг 58. Бусадтай харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдалд дасан зохицох чадвар







Бусадтай харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдалд дасан зохицох чадварын

хувьд оюуны болон уналт таталтын бэрхшээлтэй оролцогчид өөрсдийгөө дунджаас доогуур хэмээн үнэлсэн байна. Энэ 2 чадварын хувьд сонсгол, уналт таталт, хараа, хөдөлгөөн, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 50 хувь нь дундаж ба түүнээс дээгүүр үнэлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд эрхээ эдлэх боломжид хамгийн их, шууд нөлөөлж байгаа ямар хувьсагч байгааг тодруулахын тулд судалгааны үр дүнд шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн харагдаж байна.





Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд эрхээ эдлэх боломжид шууд нөлөөлж байгаа дараах хувьсагчид байна. Үүнд:


1. Институцид итгэх итгэл буюу хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд төрийн болон улс төрийн институцууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахад хичээнгүйлэн ажиллах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл УИХ-аар батлагдан гарч байгаа холбогдох хуулиудад тусгагдсан ХБИ-тэй холбоотой зүйл, заалтуудын хэрэгжилтийг хангахад холбогддог төрийн байгууллагууд идэвх санаачлагатай ажиллах, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлд төрийн байгууллагуудын санал санаачлагуудыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
2. Нийгмийн хандлага- Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн болон улс төрийн оролцооны талаарх олон нийтийн санаа бодол бусад хязгаарлалтуудыг бууруулахад чиглэсэн нийгмийг соён гэгээрүүлэх ажил шаардлагатай байна. Энэхүү зорилго дээр төрийн болон улс төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
3. Сонгох сонгогдох эрхийг бодитой болгохын тулд юуны түрүүнд улс төрийн оролцооны идэвхийг нэмэгдүүлэх шаардлага бөгөөд улс төрийн оролцооны идэвхид нийгмийн хандлага хамгийн ихээр нөлөөлж байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцоо, сонгуулийн



эрхийг хангахад улс төрийн нам, хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө хамгийн их нөлөөтэй байна гэдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Гэсэн хэдий ч ХБИ сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд ИНБ, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо чухал хэвээр байгаа гэдгийг мартаж болохгүй юм.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, улс төрийн оролцооны идэвх, сонгуулийн эрхийн хэрэгжилтийг хангахад хамгийн анхаарах шаардлагатай асуудал бол

- 1) хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд бие даан оролцох чадварыг сайжруулах
- 2) хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, улмаар санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулах
- 3) хувь хүнийх нь хөгжих, суралцах боломжоор хангах шаардлагатай болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.







Select points to use as focal records


This chart is a lower-dimensional projection of the predictor space, which contains a total of 25 predictors.

## 2.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

Зураг 59. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түүний хамаарал








Монгол Улсын Үндсэн хууль болон, Хүний эрхийн Түгээмэл тунхаглалд тусгагдсан эрхээ эдэлж чадаж байгаа эсэх талаар тодруулахад 34 хувь нь амьд явах эрх, эрх чөлөөтэй байх, 29.1 хувь нь эрх чөлөөтэй байх, 26 хувь нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрх, 24.2 хувь нь сонгох эрх, 22.1 хувь нь шашин шүтэх, эс шүтэх эрх, 8.9 хувь нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, 16.4 хувь нь сонгогдох эрх, 14.1 хувь нь шударга шүүхээр шүүлгэх эрх, 12.9 хувь нь эвлэлдэн нэгдэх эрх, 12.6 хувь нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх, 11.6 хувь нь боловсрол эзэмших эрх, 11.8 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, 11.6 хувь нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, 9.6 хувь нь нийгэм соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрх, 9.2 хувь нь хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрхээ тус тус “Маш сайн эдэлж чадаж байна” гэж үнэлжээ.


Харин судалгаанд оролцогчдын 18.2 хувь нь хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрх, 16.3 хувь нь сонгогдох эрх, 15.7 хувь нь боловсрол эзэмших, 14.6 хувь нь нийгэм соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ огт эдэлж чадахгүй байгаа гэдгээ илэрхийлсэн байна.

**Зураг 60. Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, насаар**




Амьд явах, эрх чөлөөтэй байх, шашин шүтэх эс шүтэх эрхээ эдлэх боломжийн хувьд насны ангилал тус бүрийн хувьд ялгаатай байдал ажиглагдахгүй байна. Харин эдгээр эрхийг огт сургуульд сураагүй оролцогчид бусад оролцогчдоос харьцангуй бага үнэлгээг өгсөн байна.

**Зураг 61. Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, боловсролын байдлаар**




**Зураг 62. Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр**



Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээг үзэхэд судалгаанд оролцогчдын хүйсийн ялгаатай байдал нөлөөлөхгүй байгаа нь харагдаж байна. Харин эдгээр 3 эрхийг сэтгэц, оюуны бэрхшээлтэй оролцогчид бусад оролцогчидтой харьцуулахад харьцангуй бага үнэлгээ өгсөн байгаа нь харагдаж байна.

**Зураг 63 . Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, сонгох эрх, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, боловсролын байдлаар**




Бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 23.4 хувь, дээд боловсролтой оролцогчдын 20 хувь нь үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, бүрэн дунд боловсролтой болон, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын тус бүр 17 хувь, огт сургуульд сураагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 20 хувь,

сонгох эрх, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 29.8 хувь, дээд боловсролтой оролцогчдын 20 хувь, огт сургуульд сураагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 20 хувь, сонгогдох эрх, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 21.3 хувь, огт сургуульд сураагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 20 хувь нь эвлэлдэн нэгдэх эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгчээ.


Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох, эвлэлдэн нэгдэх эрхийг эдлэхэд хүйсийн ялгаатай байдал байхгүй байгааг судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

**Зураг 64. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, сонгох эрх, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр**




Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл оюуны хомсдолын бэрхшээлтэй оролцогчдын 16.1 хувь, сэтгэцийн хувьд бэрхшээлтэй иргэдийн 15.1 хувь, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 10.8 хувь нь үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ огт эдэлж чадахгүй байна гэсэн хариултыг өгсөн байна. Харин сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 11 хувь, оюуны хомсдолын бэрхшээлтэй оролцогчдын 9.7 хувь нь сонгох эрхээ эдэлж чадахгүй байна. Сонгогдох эрхийн хувьд сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 23.3 хувь, харааны бэрхшээлтэй оролцогчдын 20 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн 17.6 хувь, оюуны хомсдолын бэрхшээлтэй иргэдийн 16.1 хувь нь огт эдэлж чадахгүй байна гэжээ. Харин Эвлэлдэн нэгдэх эрхээ хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн 16.2 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн 16.4 хувь нь “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгсөн байна.

**Зураг 65. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, сонгох эрх, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, газар зүйн байршлаар**



Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хувьд аймаг, нийслэлийн төвд болон хөдөө амьдардаг оролцогчдын 10 хувь, сонгох эрхийн хувьд төвөөс алслагдсан байрлалд амьдардаг оролцогчдын 33.3 хувь, сонгогдох эрхийн хувьд төвөөс алслагдсан байрлалд амьдардаг оролцогчдын 33.3 хувь нь эвлэлдэн нэгдэх эрхийн хувьд аймаг, нийслэлийн төвд амьдардаг оролцогчдын 26.3 хувь, сумын төв аслагдсан байрлалд амьдардаг оролцогчдын 22.9 хувь нь “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгсөн байна.


**Зураг 66. Шударга шүүхээр шүүлгэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, насаар**





Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хувьд 26-35 насны судалгаанд оролцогчдын 16.9 хувь, 46-65 насны оролцогчдын 16 хувь нь, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хувьд 65 ба түүнээс дээш насны оролцогчдын 19.8 хувь, 46-65 насны оролцогчдын 13.8 хувь нь “огт эдэлж чадахгүй байна” гэж хариулжээ.


**Зураг 67. Шударга шүүхээр шүүлгэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, боловсролын байдлаар**



Огт сургуульд сураагүй, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 25.5 хувь нь шударга шүүхээр шүүлгэх эрхээ огт эдэлж чадахгүй байна гэсэн бол дээд боловсролтой оролцогчдын 20 хувь, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 25.5 хувь нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх гэдэг эрхийг огт эдэлж чадахгүй байна гэж хариулсан байна. Харин огт сургууль сураагүй бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 16-17 хувь нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж үзсэн байна.


Шударга шүүхээр шүүлгэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ эдлэхэд хүйсийн ялгаатай байдал нөлөөлөхгүй байгааг дээрх судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

Зураг 68. Шударга шүүхээр шүүлгэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр




Харааны бэрхшээлтэй иргэдийн 17 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 16.4 хувь, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 16 хувь нь шударга шүүхээр шүүлгэх эрхээ огт эдэлж чадахгүй байна. Хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 18.9 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 17.8 хувь нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээ огт эдэлж чадахгүй байна. Харин сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 16.4 хувь нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгсөн байна.

**Зураг 69. Шударга шүүхээр шүүлгэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, зорчих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, газар зүйн байршлаар**




Аймаг, нийслэлийн төвд амьдарч байгаа оролцогчдын 16.9 хувь, хөдөө амьдарч байгаа оролцогчдын 14.5 хувь нь шударга шүүхээр шүүлгэх эрх, аймаг, нийслэлд амьдарч байгаа оролцогчдын 12.9 хувь нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, аймаг, нийслэл сумын төвд амьдарч байгаа оролцогчдын 17.6 хувь нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй оршин суух, амьдрах эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

**Зураг 70. Боловсрол эзэмших эрх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, насаар**



65-аас дээш насны оролцогчдын 26.1 хувь нь боловсрол эзэмших эрх, 18-25 насны оролцогчдын 15.2 хувь нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ тус тус “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгсөн байна.

**Зураг 71. Боловсрол эзэмших эрх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, боловсролын байдлаар**




Огт сургуульд суралцаагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 44 хувь, дээд боловсролтой оролцогчдын 20 хувь, бичиг үсэг тайлагдсан бага боловсролтой оролцогчдын 22.2 хувь, бичиг үсэг тайлагдаагүй сургуульд сураагүй оролцогчдын 38.3 хувь нь сурч боловсрох эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж үзсэн байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийн хувьд огт сургуульд сураагүй боловч бичиг үсэг тайлагдсан оролцогчдын 24 “огт эдэлж чадахгүй байна” гэсэн бол дээд боловсролтой оролцогчдын 30 хувь нь эрүүл аюулгүй орчин амьдрах эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж үзсэн байна.


Боловсрол эзэмших, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл аюулгүй орчин амьдрах эрхийн хувьд эрхээ эдлэхэд хүйсийн ялгаатай байдал ажиглагдахгүй байна.

**Зураг 72. Боловсрол эзэмших эрх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр**




Сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 30 хувь, оюуны хомсдолтой оролцогчдын 41.9 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 28.8 хувь, хэл ярианы бэрхшээлтэй оролцогчдын 21.6 хувь нь сурч, боловсрох, оюуны хомсдолтой оролцогчдын 22.6 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 11.7 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 17.8 хувь нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ огт эдэлж чадахгүй байна гэж хариулсан байна.

**Зураг 73. Боловсрол эзэмших эрх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, газар зүйн байршлаар**



Боловсрол эзэмших, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэх боломжид судалгаанд оролцогчдын амьдарч байгаа байршил нөлөөлөхгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.


**Зураг 74. Хөдөлмөрлөх, шударгаар үнэлүүлэх эрх, нийгэм, соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, насаар**



26-35 насны судалгаанд оролцогчдын 20.6 хувь, 18-25 насны оролцогчдын 19.6 хувь, 46-65 насны оролцогчдын 18.6 хувь, 65-аас дээш насны оролцогчдын 17.4 хувь, 36-45 насны оролцогчдын 15.6 хувь нь хөдөлмөрлөх, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж үзсэн байна.


26-35 насны оролцогчдын 17.5 хувь, 65-аас дээш насны оролцогчдын 17.4 хувь, 46-65 насны оролцогчдын 14.9 хувь, 36-45 насны оролцогчдын 11.8 хувь нь нийгэм соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж хариулсан байна.

**Зураг 75. Хөдөлмөрлөх, шударгаар үнэлүүлэх эрх, Нийгэм, соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, боловсролын байдлаар**




Огт сургуульд суралцаагүй оролцогчдын 44 хувь, дээд боловсролтой (магистр) оролцогчдын 35 хувь, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 34 хувь нь хөдөлмөрлөх, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэж үзсэн бол огт сургуульд сураагүй оролцогчдын 40 хувь, бичиг үсэг тайлагдсан бага боловсролтой оролцогчдын 20.8 хувь, бичиг үсэг тайлагдаагүй оролцогчдын 36.2 хувь нь нийгэм, соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ огт эдэлж чадахгүй байна гэж хариулсан байна.

**Зураг 76. Хөдөлмөрлөх, шударгаар үнэлүүлэх эрх, Нийгэм, соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр**



Оюуны хомсдолын бэрхшээлтэй оролцогчдын 48.4 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 30.1 хувь нь хөдөлмөрлөх, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, оюуны хомсдолтой оролцогчдын 38.7 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын 26 хувь нь нийгэм соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ “огт эдэлж чадахгүй байна” гэсэн хариултыг өгсөн байна.

**Зураг 77. Хөдөлмөрлөх, шударгаар үнэлүүлэх эрх, Нийгэм, соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих эрхээ эдэлж байгаа хамаарлын шинжилгээ, газар зүйн байршлаар**



Судалгааны үр дүнгээс харахад нийгэм соёлын амьдралд оролцох бүтээл туурвих, хөдөлмөрлөх, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэхэд судалгаанд оролцогчдын амьдарч буй орон зайн байршил нөлөөлөхгүй байгаа нь харагдаж байна.



### **БҮЛЭГ 3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

Хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх олон нийтийн санаа бодлыг тандах зорилгоор 1291 иргэдээс санал асуулга авсан. Судалгаанд оролцогчдын 55.4 хувь нь эмэгтэй, 44.2 хувь нь эрэгтэй, насны хувьд 40.5 хувь нь 18-25, 21 хувь нь 26-35, 18.8 хувь нь 36-45, 18.7 хувь нь 46-65, 11.7 хувь нь 65-аас дээш насны оролцогчид байв.

*Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын мэдээлэл*

Таны хүйс	
Эмэгтэй	55.4
Эрэгтэй	44.2
Таны нас	
18- 25 нас	40.5
26-35 нас	21
36-45 нас	18.8
46-65	18.7
65-аас дээш	11.7
Таны гэр бүлийн байдал	
Ганц бие	38.2
Гэрлэсэн	39.0
Хариулахаас татгалзсан	6.6
Таны боловсролын байдал	
Бага боловсрол	1.5
Бичиг үсэг тайлагдаагүй	0.7
Бүрэн бус дунд боловсрол	3.9
Бүрэн дунд боловсрол	32.6
Доктор	1.9
Дээд боловсрол(Бакалавр)	41.7
Магистр	9.9
Техник мэргэжлийн тусгай боловсрол	7.9

Судалгаанд оролцогчдыг боловсролын байдлыг авч үзвэл 0.7 хувь нь бичиг үсэг тайлагдаагүй, 1.5 хувь нь бичиг үсэг тайлагдсан, бага боловсролтой, 3.9 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 32.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 41.7 хувь нь дээд боловсролтой (Бакалавр), 9.9 хувь нь дээд боловсролтой (Магистр), 7.9 хувь нь техник мэргэжлийн, тусгай боловсрол эзэмшсэн байна.

Судалгаанд оролцогчдыг гэрлэлтийн байдлын хувьд авч үзвэл 38.2 хувь нь ганц бие, 39 хувь нь гэрлэсэн, 6.6 хариулахаас татгалзсан байна.

Судалгаанд оролцогчдын 40.6 хувь нь хөгжлийн бэрхшээлийн талаар ямар нэгэн байдлаар ойлголттой байхад 59.4 хувь нь ямар нэгэн ойлголт огт байхгүй гэжээ.


**Зураг 78. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт**



Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх бодлыг нээлттэй асуулгаар тодруулахад судалгаанд оролцогчдын 28.9 хувь нь төрөлхийн эсвэл олдмол байдлаар хэвийн хөгжлөөр хөгжихгүй боломжгүй болсон, 13.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдаар өөр гэж бодоогүй, 12.5 хувь нь хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, 10.7 хувь нь нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан хүмүүс, 10 хувь нь хэвийн байх л зүйл, 9.1 хувь нь хэцүү өрөвдмөөр хүмүүс, 8.4 хувь нь тусламж шаардлагатай хүмүүс, 6.6 хувь нь огт энэ хүмүүсийн талаар юу ч мэддэггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй тааралдаж ярилцаж байсан эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын 41.4 хувь нь амьдарч буй газар, байр, гудамжинд, 20.5 хувь нь ажлын байранд, 33.9 хувь нь ах дүү хамаатсан садныхаа хүрээлэлд тааралдаж байсан гэж хариулжээ.

**Зураг 79. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад хэр ээлтэй улс вэ?**




Судалгаанд оролцогчдоос “Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад хэр ээлтэй улс гэж та бодож байна вэ?” гэх судал асуултад судалгаанд оролцогчдын 83.1 хувь нь огт ээлгүй, 14.3 хувь нь хэлж мэдэхгүй байна, 2.6 хувь нь маш ээлтэй улс хэмээн хариулсан байна.

**Зураг 80. ХБИ амьдрахад ээлгүй байгаагийн гол шалтгаан**



Оролцогчдын 83.1 хувь нь огт ээлгүй гэж хариулсны шалтгааныг тодруулахад 41.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад шаардлагатай дэд бүтэц байхгүй, 18 хувь нь яагаад ийм байгаа талаар огт бодож үзээгүй, 11.5 хувь нь нийтийн тээврийн хүртээмж муу учраас нийгмийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж чаддаггүй, 7.9 хувь нь нийгмийн янз бүрийн ялгаварлан гадуурхалтаас болж эрх, эрх чөлөө нь байнга зөрчигддөг, 4.8 хувь нь төрийн бодлого энэ хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлд хэрэгждэггүй, 2.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сурч, боловсрох эрхээ эдэлж чадахгүй байна, 2.4 хувь нь чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх орчин, нөхцөл эдгээр хүмүүст байдаггүй, 2.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнх нь амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх боломж байдаггүй, 2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн тэтгэвэр халамжийн тогтолцоо маш муу байдаг учраас ээлгүй гэж хариулсан байна.


**Зураг 81. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамтран ажиллахад үүсэж болох бэрхшээл**



Судалгаанд оролцогчдын 14.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамтран ажиллахад ямар нэгэн саад үүснэ гэж үзсэн байхад 48.8 хувь нь ямар нэгэн саад бэрхшээл үүсэхгүй гэж хариулсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажлын байранд хамтран ажиллахад ямар бэрхшээл үүсэх талаар тодруулахад оролцогчдын 43.2 хувь нь одоогоор хамтран ажиллаж үзсэн туршлага байхгүй, 24.9 хувь нь ер нь л маш их хэцүү байна, 19.1 хувь нь ямар ч бэрхшээл үүсэхгүй, 6.8 хувь нь харилцан ойлголцоход бэрхшээлтэй байна, 3.7 хувь нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн сахиж чадаагүйн улмаас бэрхшээл үүснэ, 1.7 хувь нь хөдөлмөрийн нөөц, ачаалал даах чадвар нь энгийн хүнээс харьцангуй сул, 0.6 хувь нь хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан заавал нэг асуудал үүснэ хэмээн хариулсан байна.


**Зураг 82. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамтран ажиллах, суралцах гэр бүл зохиох талаарх ойлголт**




Судалгаанд оролцогчдын 44.6 хувь нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй гэр бүл болж хамтран амьдрахад ямар ч бэрхшээл үүсэхгүй” гэдэгтэй огт санал нийлэхгүй гэсэн бол 37 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамтран суралцахад ямар ч бэрхшээл үүсэхгүй гэдэгтэй бүрэн санал нийлж байна гэжээ. Харин судалгаанд оролцогчдын 37.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамтран ажиллахад ямар нэгэн бэрхшээл үүсэхгүй гэдэгтэй огт санал нийлэхгүй байна гэж хариултыг өгсөн байна.

Мөн судалгаанд оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүн Үндсэн хуулиар олгогдсон эрхээ нийгмийн гишүүнийхээ хувьд элдэх эрхтэй гэдэгтэй бүгд санал нийлж байгаагаа илэрхийлсэн байна.

**Зураг 83. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт**



**Зураг 84. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай дэмжлэг**



Судалгаанд оролцогчдын 69.1 хувь нь соёл урлаг үзвэрийн газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх, 67.7 хувь нь ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах тал дээр илүү бүтээлчээр хандах, 68.9 хувь нь боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжин сургах шаардлагатай гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдын 44.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмээс тусгайлсан халамж хүртэх ёстой гэдэгтэй огт санал нийлэхгүй байна гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 63.3 хувь нь нийгэм, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ойлгож туслахад бэлэн биш байна гэдэгтэй огт санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 60.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд бие даан оролцож, нийгмийн гишүүдтэй зэрэгцэн ажиллаж амьдарч чадна гэдэгтэй санал нийлэхгүй байна гэжээ. Судалгаанд оролцогчдын 56 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн удирдах албан тушаалтан болж бодлого боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжтой гэдэгтэй санал нийлэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.


**Зураг 85. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даасан байдлыг хангахад зайлшгүй хийх шаардлагатай ажлууд**



Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд бие даан оролцох боломжийг хангахын тулд хамгийн түрүүнд юу хийх шаардлагатай талаар нээлттэй асуулгаар асуухад судалгаанд оролцогчдын 18.7 хувь нь нийгмийн зүгээс ойлгож хүлээн зөвшөөрөх, 16.3 хувь гарааны тэгш боломж олгох, 13.4

хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцох чадварыг нь сургалтуудаар дамжуулан олгох, 11.9 хувь нь хүртээмжтэй ажлын байрыг олноор бий болгох, 8.3 хувь нь төр хуулиар хүлээн зөвшөөрсөн үүргээ биелүүлэх, 6.8 хувь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, 6.4 хувь нь суралцах амьдрах хүртээмжтэй орчныг бүрдүүлэх гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдын 10 хувь нь энэ талаар мэдэх шаардлага хүмүүст байхгүй гэжээ.

**Зураг 86. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгуульд дэмжих эсэх**



Судалгаанд оролцогчдын 29.8 хувь нь 2024 оны УИХ-ын сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг дэмжиж саналаа өгнө гэж хариулсан байхад 19.4 хувь нь дэмжихгүй, 50.8 хувь нь одоогоор сайн хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.

## **БҮЛЭГ 4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн бүхий л хүрээнд оролцох явдлыг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүний угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш салшгүй эрхийг хүлээн зөвшөөрч Монгол Улсын Үндсэн Хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, тэдгээрийн нэмэлт протокол зэргийг соёрхон баталсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн дээрх олон улсын гэрээ конвенцод заасан эрх чөлөөг эдэлж, сонголт хийх, бие даасан байдал, хараат бус байдлыг хүндэтгэж, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, хамрагдах, тэдний ялгаатай байдал онцлог хэрэгцээг хүндэтгэх, тэгш боломж олгох, хүртээмжтэй байх, эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байхыг баталгаажуулсан.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй” мөн 21 дүгээр зүйлд “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”, “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй”, “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно гэжээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2.1-д “Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”, 25 дугаар зүйлд “Иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах



эрх, боломжийг эдэлнэ: а) төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон, төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох; б) сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох; с) тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаших”, 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчлахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой” гэж тус тус заажээ.

Энэ заалтын “бусад байдлаар” гэдгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлээр алагчлахыг хориглосон утга бий<sup>147</sup>.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэж тунхаглаж Монгол Улсын иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргана хэмээн заасан нь олон улсын хэм хэмжээнд нийцэж байна.<sup>148</sup>

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг 2009 оны 05 дугаар сарын 13-ны өдөр соёрхон баталж конвенцын нэмэлт протоколд нэгдсэн орсон.

Уг конвенцын 29 дүгээр зүйлд Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг дараах байдлаар баталгаажуулсан. Үүнд

а. Бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагуудаараа дамжуулан улс, төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараах хэлбэрээр хангана:

1. сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;

<sup>147</sup> О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа), Хүний эрх – Дэвшилтэт бодлогын хүрээлэн, Улаанбаатар хот, 2021 он: сонгох, сонгогдох эрх (хуудас 160), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх (хуудас 379)

<sup>148</sup> Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа), Улаанбаатар, 2021, Сонгох, сонгогдох эрх

2. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх, болон шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологи ашиглах замаар албан тушаал хаших, төр засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах эрхийг дэмжиж хамгаалах.

б. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх, үндсэн дээр ямар нэг ялгаварлан гадуурхалгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжих, түүний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог дараах хэлбэрээр дэмжих:

1. Улс орны улс төрийн болон төрийн хэрэг, ялангуяа улс төрийн намуудын үйл ажиллагаа болон удирдлагатай нь холбоотой үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсээр зааж хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгох, сонгогдох эрхээ чөлөөтэй, үр дүнтэй, бүрэн дүүрэн эдлэх эрхтэй болохыг тусгасан.

Монгол Улс нь 2011 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх анхдугаар илтгэлээ хүргүүлснийг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны хуралдаанаар 2015 онд хэлэлцэж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэгдсэн эерэг зүйлс, болон тулгамдсан асуудал, түүний шийдлийн талаар зөвлөмжийг өгчээ. Монгол Улс хоёр болон гуравдугаар тайлан, илтгэлээ 2023 онд хүргүүлсэн бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 05-нд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэгдсэн эерэг зүйлс болон тулгамдсан асуудал, шийдлийн талаар зөвлөмжийг өгчээ.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос конвенцын 29 дүгээр зүйлд заасан эрхийн талаар өгсөн зөвлөмжийг авч үзэхэд: Монгол Улсын Иргэний хууль болон Сонгуулийн тухай хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийн талаарх конвенцын заалттай нийцээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа сонсголын бэрхшээлтэй, оюуны болон/эсвэл сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй, хараагүй-сонсголгүй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд улс төр, нийгмийн амьдралд хангалттай төлөөлөлгүй байгаад санаа зовниж, санал авах байр, санал өгөх журам, байгууламж, материал, түүнчлэн сонгуулийн талаарх мэдээлэл, тэр дундаа сонгуулийн олон нийтийн мэтгэлцээн, сонгуулийн

хөтөлбөр, сонгуулийн онлайн болон хэвлэмэл материал зэрэг нь хүртээмжгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн үр дүнтэй оролцоог хязгаарлаж байгааг дүгнэж, Монгол Улсын Засгийн газарт хандан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийн талаар дараах зөвлөмж<sup>149</sup>:

- (а) “Иргэний хууль болон Сонгуулийн тухай хуулийг конвенцын заалттай уялдуулах үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулж, тэгш байдлыг хангах тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мөн төлөөлөл багатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа сонсголын бэрхшээлтэй, оюуны болон/хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульт болон бусад албан тушаалд оролцоог дэмжихээс гадна хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид, ялангуяа цөөнхийн улс төрийн намаас нэр дэвшихэд нь дэмжлэг үзүүлэх”;
- (б) Сонгууль болон санал хураах журам, тоног төхөөрөмж, сонгуулийн онлайн болон хэвлэмэл материалыг энгийн яриа хэлээр, хялбар уншигдах, ашиглах боломжтой болгож, улмаар хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүргэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах”-ийг өгчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлснээр олон улсын бусад гэрээ, конвенц, санаачилгуудыг хэрэгжүүлнэ. Тухайлбал:

Тогтвортой хөгжлийн зорилт 2030, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бодит болгоё-Инчеоны стратеги, түүний хэрэгжилтийг эрчимжүүлэх Бээжин тунхаглал<sup>150</sup>, мөн дараагийн Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил болон Жакартагийн тунхаглал (2023-2032) зэрэг баримт бичгүүд байна<sup>151</sup>.

Жакартагийн тунхаглал нь Инчеоны стратегийг үргэлжлүүлэх баримт бичиг бөгөөд 10 зорилгыг тодорхойлсноос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрхийг хангах талаар хэд хэдэн зорилгыг дэвшүүлсэн. Энэ нь улс төрийн явц болон шийдвэр гаргах түвшинд оролцуулахыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрт үеийн дэмжлэгийг өргөсгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцыг соёрхон батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг зорилгыг тодорхойлжээ.

<sup>149</sup> Монгол Улсын хоёр болон гуравдугаар нэгтгэсэн тайланд хийсэн ажиглалт, дүгнэлт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хороо, 2023 оны 09 дүгээр сарын 05 (CRPD/C/MNG/CO/2-3): 29 дүгээр зүйл: Улс төр, нийгмийн амьдралд оролцох

<sup>150</sup> Инчеон стратеги болон Инчеон стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Бээжин тунхаглал, United Nations 2018, ST/ESCAP/2848

<sup>151</sup> Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил, Жакартагийн тунхаглал, 2023-2032, НҮБ, 2023, ST/ESCAP/3055

**Хүснэгт 8. Жакартагийн тунхаглал ба бусад олон улсын бичиг баримтуудын хэрэгжилт**

Ази-Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил (2023-2032): Жакартагийн тунхаглал	ХБХЭТК	Тогтвортой хөгжлийн зорилт 2030 (169 зорилт)	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндай хүрээ 2015-2030
1. Ядуурлыг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах	27, 28	1. Ядуурлыг устгах (1.1, 1.2) 4. Чанартай боловсролыг дэмжих (4.4, 4.5) 8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (8.5, 8.6) 10. Тэгш бус байдлыг бууруулах (10.2)	
2. Улс төрийн явц болон шийдвэр гаргах түвшинд оролцуулахыг дэмжих	29	5. Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах (5.5) 10. Тэгш бус байдлыг бууруулах (10.2) 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох (16.7)	
3. Биет орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг сайжруулах	9, 21	9. Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх (9.1) 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (11.1, 11.2, 11.7) 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох (16.10) 4. Чанартай боловсролыг дэмжих (4.A) 9. Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх (9.C)	7, 19, 30, 32, 36
4. Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх	19,25,26,28	1. Ядуурлыг устгах (1.3) 3. Эрүүл мэндийг дэмжих (3.7, 3.8) 10. Тэгш бус байдлыг бууруулах (10.4)	
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрт үеийн дэмжлэгийг өргөсгөх	7, 24, 30	4. Чанартай боловсролыг дэмжих (4.1, 4.2, 4.5, 4.A)	
6. Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдэлжүүлэлтийг баталгаажуулах	6	3. Эрүүл мэндийг дэмжих (3.7, 3.8) 4. Чанартай боловсролыг дэмжих (4.1, 4.2, 4.3, 4.5, 4.6) 5. Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах (5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.A, 5.B, 5.C) 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох (16.1, 16.2)	

7. Гамшгийн эрсдэлийг бууруулах хөгжлийн бэрхшээлийг хамруулсан менежмент	11	1. Ядуурлыг устгах (1.5); 9. Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх (9.1) 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (11.2, 11.5, 11.7, 11.В) 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (13.1, 13.3, 13.В)	7, 19, 24, 30, 32, 33, 36
8. Харьцуулж болох, найдвартай хөгжлийн бэрхшээлийн статистик тоо мэдээг сайжруулах	31	17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (17.18, 17.19)	19
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенцыг соёрхон батлах, хэрэгжилтийг эрчимжүүлж, үндэсний хууль тогтоомжийг Конвенцын үзэл санаатай нийцүүлэх	4	10. Тэгш бус байдлыг бууруулах (10.3) 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох (16.3, 16.В)	
10. Бүс нутаг, бүсийн болон бүс хоорондын хамтын ажиллагааг сайжруулах	32	17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (17.9, 17.16, 17.19)	

2013-2022 онд Ази-Номхон далайн гишүүн орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн нөхцөл, байдлыг сайжруулахад хангалттай сайн үр дүнд хүрээгүй учраас дээрх 10 зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсныг Жакартагийн тунхаглалд дурдсан. Монгол Улсын Засгийн газар Инчеоны тунхаглалыг ихэнх орнуудын нэгэн адил хангалттай хэрэгжүүлээгүй бөгөөд нас, хүйсээр нь ангилсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн статистик, тоо мэдээлэл холбогдох салбаруудад гардаггүй нь НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хэлтсээс авсан статистик тайлангаар батлагдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хорооноос Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжийг, мөн Жакартагийн тунхаглалыг хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтад тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж, мөн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь заалтад “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,

эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэлбодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан.

Монгол Улсын хууль, тогтоомжуудад хэд хэдэн зарчмын зөрчил байгааг хуулийн шинжээчид дүгнэсэн байна<sup>152</sup>:

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5-д “...хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны “... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн хэсэг нь “хөгжлийн бэрхшээлтэй хүний жагсаал, цуглаанд сайн дураараа нэгдэх, оролцох эрхийг хязгаарлах боломжийг бүрдүүлэхээр байх” тул Үндсэн хуулийн 1.2-ын “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 10.2-ын “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 14.1-ийн “...хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна”, 14.2-ын “Хүнийг ..... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16.16-ын “...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, 19.1-ийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц....нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж Цэц шийдсэн<sup>153</sup>. Энэ дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалаад зогсохгүй Үндсэн хуулийн 14.2-т нэрлэн заагаагүй шинжээр ч хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн түүхэн шийдвэр юм<sup>154</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд баталж, мөн Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталсан боловч уг хөтөлбөрийг Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгож, шинээр үндэсний хөтөлбөр батлаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

<sup>152</sup> Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа), Хүний эрх – Дэвшилтэт бодлогын хүрээлэн, Улаанбаатар, 2021: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хуудас-380

<sup>153</sup> УИХ э. С.Номынбаясгалан, Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 07, 2017.11.29

<sup>154</sup> О.Мөнхсайхан, “Хууль дээдлэх ёс: ерөнхий хандлага ба Монгол”, Эрх зүй №4 (52) (МУИС-Хууль зүйн сургууль 2020), 1-63

**Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтууд**

Хууль	Зүйл, заалт
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль /2020 он/	<p>5 дугаар зүйл. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх</p> <p>5.7. Сонгогч саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа гаргах боломжоор хангагдсан байна.</p> <p>41 дүгээр зүйл. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах</p> <p>41.27. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна.</p> <p>56 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа</p> <p>56.3. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.</p> <p>56.4. Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.</p> <p>56.5. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.</p> <p>58 дугаар зүйл. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа.</p> <p>58.1.1. Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;</p> <p>62 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх</p> <p>62.9. Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.</p> <p>62.16. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 62.5-д заасан зааврыг батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг тусгасан байна</p>

<p>Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /2019 он/</p>	<p><b>5 дугаар зүйл. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх</b>  5.1. Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.  5.4. Сонгогч саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна.</p> <p><b>46 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах</b>  46.27. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.</p> <p><b>62 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа</b>  62.3. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.  62.4. Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.  62.5. Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.</p> <p><b>63 дугаар зүйл. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа</b>  63.1. Дараах сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авна:  63.1.1. Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;</p>
<p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай /2020 он/</p>	<p><b>5 дугаар зүйл. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх</b>  5.1. Тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн /цаашид "иргэн" гэх/ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр орон нутгийн Хурлын сонгуульд оролцож, тухайн шатны Хурлын Төлөөлөгчийг сонгох эрхтэй.</p> <p><b>61 дүгээр зүйл. Санал авах байр, хугацаа</b>  61.3. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.  61.4. Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.  61.5. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.</p> <p><b>62 дугаар зүйл. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа</b>  62.1. Өөрийн байнга оршин суугаа сум болон нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа дараах сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авна:  62.1.1. Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;</p>



<p>Улс төрийн намын тухай хууль /2023 он/</p>	<p>8 дугаар зүйл. Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх</p> <p>8.5. Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана</p> <p><b>26 дугаар зүйл. Улс төрийн намын орлогын эх үүсвэр</b></p> <p>26.3.1 төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх</p> <p><b>27 дугаар зүйл. Төрийн санхүүжилт</b></p> <p>27.7. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.</p>
<p>Сонгуулийн ерөнхий хорооны тухай хууль /2019 он/</p>	<p><b>46 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах</b></p> <p>46.27. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.</p> <p><b>62 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа</b></p> <p>62.3. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.</p> <p>62.4. Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.</p> <p>62.5. Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/</p>	<p><b>6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах</b></p> <p>6.1. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p> <p>6.2. Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.</p> <p>6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:</p> <p>6.3.6. төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.</p> <p><b>30 дугаар зүйл. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох</b></p> <p>30.1. Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p> <p>30.2. Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.</p> <p>30.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.</p> <p>30.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.</p>

Зөрчлийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийн талаар заалт тусгаагүй, харин хөгжлийн бэрхшээл, түүн дотроо онцгойлон сэтгэцийн бэрхшээлтэй хүний талаар дараах заалтыг тусгажээ.

### Хүснэгт 10. Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт

Зөрчлийн тухай хууль	Холбогдох заалт
2.3 дугаар зүйл. Шийтгэлээс чөлөөлөх үндэслэл	2.Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно.
4.4 дүгээр зүйл. Албадан эмчлэх	1.Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно.
5.8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих	5.Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6.7 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хууль зөрчих	5.Иргэнээс, эсхүл арван найман насанд хүрээгүй хүн, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон өвчтөний хувьд хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-өөс нь бичгээр зөвшөөрөл авахгүйгээр нарийн төвөгтэй оношилгоо, мэс засал, анагаах ухааны судалгаа, туршилт хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6.11 дүгээр зүйл. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль зөрчих	1.Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл тусгаарлах, номхотгох аргыг хэрэглэх журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих	1. Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.5 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль зөрчих	2. Хот байгуулалтын тухай хуульд заасан:  2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох журам;  зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
--	--

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох эрхийг бусад хуулиар баталгаажуулснаас гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5.2-т, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.5-д болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 5.4-д “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй” байхаар зохицуулсан нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүний сонгуульд оролцох эрхийг хязгаарласан зохицуулалт юм.

Хэдийгээр НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцож саналаа өгөх эрхийг хязгаарлаж байгаа хууль, эрх зүйн зүйл, зохицуулалтыг өөрчлөх, хасах зөвлөмж өгсөн боловч үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.

Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, ялангуяа оюуны болон сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийг “эрх зүйн чадамжгүй” гэж үздэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд саад учруулж байна. Тухайлбал; Иргэний хуулийн 18 дугаар зүйлд Иргэний эрх зүйн чадамжгүй иргэнийг тодорхойлсон бөгөөд 18.2. дох хэсэгт “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно”, 18.3. дах хэсэгт “Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ” гэж заажээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос 2015 онд өгсөн зөвлөмж “...Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа оюуны болон сэтгэц нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн амьдралын талаар сонголт хийх, бусдын нэгэн адил хуулийн чадамжаа эдлэх эрхийг баталгаажуулах хууль ёсны арга хэмжээнүүд хангалтгүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлээсээ болоод сэтгэл зүйн хязгаарлалтад орсон хүнийг хуулийн байнгын чадамжгүй гэж үзэж, хувь хүний асуудлууд болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асран хамгаалагч нарт оролцогч улс зөвшөөрөл олгож байна” гэсэн

хэсэгтэй<sup>155</sup> одоо ч зөрчилдсөөр байгаа бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрийн өмч хөрөнгөтэй холбоотой болон бусад асуудлаар шийдвэр гаргах эрх хангагдаж чадаагүй хэвээр байгаа гэж үзэх үндэслэл болно.

Тодруулбал, Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3, 18.4 дэх хэсэг болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133, 142, 143 дугаар зүйлүүдэд тус тус зааснаар оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шүүхээр эрх зүйн чадамжгүй гэж тогтоох, улмаар түүнтэй холбоотой шийдвэр гаргах бүх эрхийг түүний нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийхээр заасныг хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл, зориг, саналыг заавал харгалзан үзэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийн оролцоог хангах зохицуулалтыг зайлшгүй бий болгох, конвенцын зөвлөмжийг биелэлтийг хангах шаардлага бий болоод удаж байгаа бөгөөд аливаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцооход түүний оролцоо, эрхээ хамгаалах боломж огт байхгүй байна<sup>156</sup>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.27-д “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна”, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 46.27-д хуулиудад “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно” гэж (хүч сулруулсан) тусгасан, харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэх талаар зохицуулалт тусгаагүй байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь иргэдийн сонгох эрх, тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хангах талаар сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтсыг 2087 санал авах байранд байрлуулсан. Харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хорооны цахим

<sup>155</sup> Монгол Улсын анхдугаар тайланд хийсэн ажиглалт, дүгнэлт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хороо, 2015 оны 5 дугаар сарын 13, CRPD/C/MNG/CO/1): 12 дугаар зүйл: Хуулийн өмнө тэгш байх.

<sup>156</sup> НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Хуулийн өмнө тэгш байх (12 дугаар зүйл), ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, “Богд судалгааны хүрээлэн” НҮТББ, 2023 он

хуудсан дэх мэдээллийн үсгийн хэмжээг 3 шатлалаар томруулах, дэвсгэрийг 2 өнгөөр сонгон харах тохиргоотой болгосон.<sup>157</sup>

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2020 онд “Хөгжлийн бэрхшээлтэй, зөрчлийн улмаас баривчлагдсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогчдын сонгох эрхийн хэрэгжилтэд хийх мониторингийн удирдамж”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхийн хэрэгжилтэд мониторинг, 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үеэр олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хөгжлийн бэрхшээлтэй, зөрчлийн улмаас баривчлагдсан болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон, хугацаат цэргийн алба хаагчид, коронавируст халдварын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа гэрээр тусгаарлагдсан, ажиглалтад байгаа сонгогчдоос тусгаарлалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн сонгох эрхээ эдэлж байгаа эсэхэд хяналт үнэлгээ, мониторингийн ажлыг тус тус зохион байгуулсан.

Тус мониторингийн хүрээнд 2020 онд нийслэлийн 6 дүүргийн 59, аймаг орон нутагт 93 нийт 152 санал авах байр, 2021 онд Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдээс 40 хэсгийн хороо, 18 аймгийн нийт 80 хэсгийн байрны бэлтгэл, зохион байгуулалт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Санал авах байрыг бэлтгэх заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин: Үндсэн шаардлага MNS 6055:2009” стандартад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийжээ.

Мониторингийн нэгдсэн дүнгээс үзэхэд санал авах байрны дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэйгээр тоноглон засах, тэдний сонгуульд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байгааг илэрхийлжээ. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсэгт “Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.” гэж заасан. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнд

<sup>157</sup> Сонгуулийн ерөнхий хорооноос Сонгогчдод мэдээ, мэдээллийг хүртээмжтэй түгээх, хөгжлийн бэрхшээлтэй болон иргэдийн сонгох эрхийг хангах талаар тайлан, Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, 2021 он

зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэх талаар сонгуулийн хороод харилцан адилгүй ойлголттой байна. Тухайлбал: УИХ-ын сонгуулийн үед /2020/ тэргэнцэртэй иргэний дүрс бүхий наалтыг 49 санал авах байранд байршуулсан байсан бол 103-т нь байршуулаагүй, зарим санал авах байранд ийм бүхээг бэлтгэх талаар огт ойлголтгүй байв. Ерөнхийлөгчийн сонгуулийн үед /2021/ тэргэнцэртэй иргэний дүрс бүхий наалтыг 80 санал авах байранд байршуулсан байсан бол 40 нь байршуулаагүй, зарим санал авах байранд ийм бүхээг бэлтгэх талаар огт ойлголтгүй байв.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж заасан. УИХ-ын сонгуулийн үед /2020/ санал авах байрны 16 нь цэцэрлэгт, 54 нь сургуульд, 32 нь сум баг, дүүргийн хорооны байранд, 50 нь бусад барилга байгууламжид байснаас сум баг, дүүргүүдийн хороодын байрны подваль болон цэцэрлэг, эсхүл сургуулийн 2, 3 давхарт байрлаж байгаа санал авах байрны орц гарц, налуу зам стандартад нийцээгүй огцом шаттай, налуу зам болон бусад зай талбайн хүртээмжгүй байдлаас тэргэнцэртэй сонгогч орох боломжгүй байна. Мөн тэргэнцэртэй сонгогч ирсэн тохиолдол 2 ажилтны туслалцаатайгаар шатаар өргөж, буулгах, зөөх, эсхүл зөөврийн битүүмжилсан хайрцгаар саналыг нь авахаар зохион байгуулан ажиллаж байна гэсэн тайлбарыг хийж байв. Ерөнхийлөгчийн сонгуулийн үед /2021/ Санал авах байрны 88 нь сургууль, цэцэрлэг, 20 нь сум баг, дүүргийн хорооны байранд, 12 нь бусад барилга байгууламжид байснаас сум баг, дүүргүүдийн хороодын байрны газар доорх давхар (подваль)-т болон цэцэрлэг, эсхүл сургуулийн 2 дээш давхарт байрлан, санал авах байрны орц гарц, налуу зам стандартад нийцээгүй огцом шаттай, налуу зам болон бусад зай талбайн хүртээмжгүй байдлаас тэргэнцэртэй сонгогч орох боломжгүй байв. Тухайлбал 9 нь газар доорх давхар (подваль)-т, 10 нь 2-оос дээш давхарт байршиж байна.
3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна” гэж заасны дагуу саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байсан бөгөөд мөн

томруулдаг шилтэй байсан хэдий ч ширээний гэрэлгүй, гэрэлтүүлэг хангалтгүй байв.

4. Хэсгийн хороод хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг дугаар харгалзахгүй саналаа өгөх боломжоор хангаж ажиллахаар төлөвлөж байгаа нь сайшаалтай хэдий ч цар тахлын үед сонгогчид хоорондын зайг баримтлан санал авах ажиллагааг зохион байгуулахад хүлээх нөхцөл байдал үүсч болзошгүй юм. УИХ-ын сонгуулийн үед /2020/ мониторинг хийсэн санал авах байрны 51 нь хүлээлгийн сандалтай, 101 нь гадна, дотно орчинд хүлээлгийн сандал байхгүй байв. Ерөнхийлөгчийн сонгуулийн үед /2021/ Мониторинг хийсэн санал авах байрны 93 нь хүлээлгийн сандалтай, 27 нь гадна, дотно орчинд хүлээлгийн сандалгүй байв.

Дээрх үнэлгээ, мониторингтой холбоотойгоор зорилтот бүлгийн сонгогчдын эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасныг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн эрхийг хангуулах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комисс дараах зөвлөмжийг хүргүүлжээ. Үүнд:

1. Санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар тоноглон засах, Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, санал авах байр бэлтгэх заавар батлах тухай” 23 дугаар тогтоолд заасан “Орчны хүртээмж ба MNS 6055:2009 стандарт”-д нийцүүлэх, нэгдсэн зааварчилгаа өгөх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмолжуулах;
2. Санал авах байрыг газар доорх давхар (подваль) болон 2-оос дээш давхарт байршуулахыг хориглох;
3. Сонсголын бэрхшээлтэй, сул сонсголтой иргэнтэй харьцахад хамгийн тохиромжтой шийдэл нь дохионы хэлмэрч тул сонгуулийн санал авах байр болгонд дохионы орчуулагч ажиллуулах;
4. Санал бэлтгэх бүхээгний өндөр, нам зэргийг тохируулан тэргэнцэртэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар тоноглох, ингэхдээ стандартын бус жижиг ширээг ашиглахгүй байх, санал авах байрны хэмжээнээс хамаарч 2-6 хаалт бүхий ширээ байршуулсан тохиолдолд бүхээгт тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээ өнгө, загвар, харагдах хэлбэрийг жигдлэх, нэгдсэн байдлаар тараах буюу бүхээгний аль хэсэгт, хэрхэн тогтоох талаар нэгдмэл мэдээллээр хангаж, зааварчлах;
5. Санал авах байрны зохион байгуулалтыг сонсголын бэрхшээлтэй сонгогчдод ойлгомжтой байлгах үүднээс нэгдсэн тэмдэг, тэмдэглэгээг

байршуулах, шаардлагатай тохиолдолд тэдэнтэй харилцах самбар байршуулж, түүнд түгээмэл хэрэглэх үг, яриаг ойлгомжтой байдлаар зургаар дүрслэн үзүүлэх;

6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд удаан хугацаагаар зогсоход хүндрэлтэй байдгийг харгалзан тэдэнд зориулан түр хэрэглүүлэх туслах хэрэгсэл болох таяг тавих, тавиур, хүлээлгийн сандал зэргийг байршуулж хэвших;

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, үндсэн эрх, эрх чөлөөгөө саадгүй эдлэх, улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд оролцох, сонгох сонгогдох эрхээ эдлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх тал дээр ажиллаж, тодорхой хуулийн заалтуудыг холбогдох хуулиудад нэмж, шинэчлэн найруулж, нөхцөл байдлыг бага зэрэг сайжруулсан хэдий ч зөвхөн биет орчныг сайжруулах, саадыг арилгах төдий зохицуулалтыг хийсэн байна.

Энэхүү хуулийн зүйл, заалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжгүй бөгөөд “Хэнийг ч ардаа орхигдуулахгүй” гэсэн Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх боломжгүй билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор “хөдөлмөрийн чадвар алдалт”-ыг дүгнэж, эмнэлгийн загвараар тодорхойлж, нийгмийн нэгэн идэвхтэй гишүүн гэж харахгүй хэвээр байгаа нь сонгох, сонгогдох эрхийн хүрээнд ч тодорхой харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалтад “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан бөгөөд хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах талаар тодорхой тусгаагүй байна. Үндсэн хуулийн 1.2-ын “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 10.2-ын “Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 14.1-ийн “...хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна”, 14.2-ын “Хүнийг ..... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16.16-ын “...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, 19.1-ийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц....нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж Үндсэн хуулийн Цэц 2017 онд шийдвэрээ гаргасан атал Монгол Улсын Засгийн газар одоог хүртэл тохирох арга хэмжээ аваагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг “эрх зүйн чадамжгүй” гэж хуулиар үзэж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнөөс асран хамгаалагч нь шийдвэр гаргах боломж их байна. Өөрөөр хэлбэл, одоогийн хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн сонгох, сонгогдох эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байна.



Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан судалгаанаас “Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн нь 39,474 иргэнийг төлөөлдөг” гэснээс үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл болсон 2–3 гишүүн байх зайлшгүй хэрэгцээ байна. Үндэсний статистикийн хорооны 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогоор Монгол Улсад нийт 108071 хөгжлийн бэрхшээлтэй хүн (нийт хүн амын 3.2 хувь) байгаагаас 20 ба түүнээс дээш насны 92,220 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 85,3 хувийг эзэлж байна. Гэтэл, Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог баталгаажуулж, шийдвэр гаргах түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа эсэхийг нотлох статистик, тоо баримт байхгүй байгаа нь Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ өмнө үүрэг хүлээж, хариуцлагатай байгаа эсэх нь учир дутагдалтай байна.

Иргэний нийгмийн байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд сүүдэр илтгэлээ илгээж байгаач энэ нь зөвхөн тэрхүү цаг хугацаанд хамааралтай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 33 дугаар зүйлийн 33.2, 33.3 дахь заалтуудыг Монгол Улс хэрэгжүүлэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс бие даасан хяналтын механизм байхгүй, тэд дуу хоолойгоо хүргэж чаддаггүй, нийгэмд нуугдсан бүлэг хүмүүс хэвээр байна.

## СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

**Үр дүн 1.** Судалгаанд нийт 698 хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсоноос 56,3 хувь буюу 393 хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй байсан. 18-65 насны нийт 652 хүн судалгаанд оролцсон нь сонгуулийн идэвхтэй насныхан байсан тул асуултад хариулж, өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл нийт судалгаанд оролцогчдын 26.9 хувь нь хөдөлгөөний, 14.3 хувь нь харааны, 11.6 хувь нь сонсголын, 10.5 хувь нь сэтгэц-нийгмийн, 6 хувь нь уналт, таталттай, 5.3 хувь нь хэл ярианы, 4.4 хувь нь оюуны хомсдолтой, үлдсэн 20.9 хувь нь бусад бэрхшээлтэй хүмүүс байсан.

Газарзүйн байршлын хувьд 21.6 хувь нь Улаанбаатар хот, 2,8 хувь нь кластер 4 (Сэлэнгэ аймаг), 19.9 хувь нь кластер 2 (Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий, Дархан-Уул), 16.6 хувь нь (кластер 3: Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Увс, Орхон, Говьсүмбэр), 12 хувь нь (кластер 1: Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Хөвсгөл) байна. Үүнээс харахад судалгааны үр дүн бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, газар зүйн байршлаар төлөөлөх чадвартай гэсэн үр дүн гарсан.

Судалгаанд оролцогчдын 42.6 хувь нь өрхийн орлого хэрэгцээнд арай ядан хүрдэг; 84.7 хувь нь нийгмийн халамжийн сангаас тодорхой төрлийн халамж авдаг, оролцогчдын 23.78 хувьд авч буй халамж нь өрхийн орлогын тал хувийг, 16.05 хувь нь бүхэлдээ өрхийн орлогыг бүрдүүлдэг гэсэн хариулыг өгсөн байна.

### Хүснэгт 11. ХБИ-ний дундаж зардал

Үзүүлэлт	Хоол хүнсний бүтээгдэхүүний зардал	Боловсрол сургуультай холбоотой зардал	Эрүүл мэнд, эмчилгээний зардал
ХБИ хувьд дундаж зардал	387,000	188,000	230,600
Улсын дундаж	472,022	707,400	156,200
Зөрүү (Хувиар)	18 хувиар бага	73 хувиар бага	47 хувиар илүү

ХБИ-ийн хувьд эрүүл мэнд эмчилгээний зардал өрхийн зарлагын дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд улсын дундажтай харьцуулахад 47 хувиар их байхад боловсрол сургуультай холбоотой зардал улсын дундажтай харьцуулахад 73 хувиар бага, хоол хүнсний бүтээгдэхүүний зардал улсын дундажтай

харьцуулахад 18 хувиар бага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эндээс анхаарал татаж байгаа хамгийн гол асуудал бол сургууль боловсролтой холбоотой зардал маш бага байгаа нь ХБИ бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгмийн гишүүдтэй харилцах чадварт суралцах, бие даан шийдвэр гаргах ур чадварт суралцахад маш том хязгаарлалт болж байна гэж дүгнэж байна.

**Үр дүн 2.** Судалгаанд оролцогчдын 7.16 хувь нь мэдээллийн эх сурвалждаа “маш их сэтгэл ханамжтай”, 44.99 хувь нь “сэтгэл ханамж дунд” гэсэн үнэлгээг өгсөн байна. Өөрөөр хэлбэл одоогийн мэдээлэл авч байгаа байдалдаа төдийлөн сэтгэл ханамжтай байхгүй байна гэсэн үг юм. Мэдээллийн эх сурвалждаа сэтгэл ханамжгүй байгаа шалтгааныг тодруулахад:

- Мэдээлэл хүлээж авах ялгаатай байдлыг харгалзан үзсэн мэдээллийн хэрэгсэл цөөхөн байдаг.
- Телевизээр явж байгаа хөтөлбөрийн мэдээний хэсэг, төр засгийн зүгээс хийж байгаа мэдээлэл нь мэдээлэл хүлээ авах ялгаатай байдлыг харгалзан үзсэн байдаг.
- Хувь хүний хөгжил, чөлөөт цагийн мэдээ мэдээлэл нь мэдээлэл хүлээж авах ялгаатай байдлыг харгалзан үзээгүй байдаг.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлдэггүй зэрэг хариултуудыг өгсөн байдаг.

**Үр дүн 3.** Харааны бэрхшээлтэй иргэдийн 8.4, хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 11,8, уналт таталтын бэрхшээлтэй оролцогчдын 2.3, сэтгэцийн хувьд бэрхшээлтэй оролцогчдын 5.5, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 7.9, оюуны хомсдолтой оролцогчдын 1.3, бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн 13.8 хувь нь л бие даан нийгмийн харилцаанд оролцож байгааг судалгааны үр дүн харуулж байна. Бие даан нийгмийн харилцаанд ороход нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлүүдэд:

- Улирлын шинж байдал;
- Дэд бүтэц;
- Үйлчилгээний байгууллагуудын мэдээллийн хүтээмжгүй байдал;
- Гэр бүлийн болоод нийгмийн гишүүдийн хандлага зэрэг эзэлж байна.

**Үр дүн 4.** Сонгуульд оролцож саналаа өгөх, улс төрийн байр сууриа илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг улс төрийн биет оролцооны идэвхийн хувьд судалгаанд оролцогчдын 12 хувь нь маш идэвхтэй, 40.5 хувь нь идэвхийн хувьд дундаж, 17.6 хувь нь огт идэвхтэй биш, 14.9 хувь нь сул идэвхтэй хэмээн хариулсан байгаагаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвхтэй биет оролцоо тодорхой нөхцөлүүдээр хязгаарлагдаж байна.

Судалгаанд оролцогчдын 33.5 хувь нь сонгох, сонгогдох эрхийн төлөв байдлыг дундаж гэж үнэлсэн байхад 8 хувь нь энэ эрхээ хангалттай сайн эдэлж байна гэж хариулсан байна. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгох, сонгогдох эрхээ хангалттай эдэлж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцогчдын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжилтэд ХБИ өөрөө нөгөө талаас улс төрийн намын оролцоо чухал нөлөөтэй болохыг харж болохоор байна.

**Үр дүн 5.** Судалгаанд оролцогчдын 39.8 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцож, шийдвэр гаргах бодлого төлөвлөх үйл явцад оролцохыг маш их хүсдэгээ илэрхийлсэн байдаг. Харин 14 хувь нь нийгмийн харилцаанд бие даан оролцох ямар ч сонирхолгүй болохоо илэрхийлсэн байдаг.

Үр дүн 6. ХБИ-ийн талаарх олон нийтийн санаа бодлын судалгаанд оролцогчдын 29.8 хувь нь 2024 оны УИХ-ын сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг дэмжиж саналаа өгнө гэж хариулсан байхад 19.4 хувь нь дэмжихгүй, 50.8 хувь нь одоогоор сайн хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна. Эндээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх нийгмийн хандлага ХБИ нийгмийн харилцаанд оролцоход тийм ч их сөрөг хязгаарлалт болоод байна гэж үзэх боломжгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл ХБИ-ийн хувьд сонгуульд нэр дэвших сонгогдох боломж тодорхой хэмжээгээр байна гэж үзэж болохоор байна.

**Үр дүн 7.** 2020 оны УИХ-ын болон Орон нутгийн сонгууль, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн оролцоог судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 85.7 хувь нь УИХ-ын сонгуульд, 84.1 хувь Орон нутгийн сонгуульд 84.7 хувь нь Ерөнхийлөгчийн сонгуульд тус тус оролцож саналаа өгсөн байна. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн оролцоо буюу сонгох эрхийн хэрэгжилт сайн байгаа нь харагдаж байна. Гэхдээ судалгаанд оролцогчдын 14-16 хувь нь аль ч сонгуульд оролцож саналаа өгөөгүй гэсэн хариулт өгсөн байна. Сонгуульд оролцоогүй шалтгаан нь сонгуулийн байранд ганцаараа очих боломжгүй, хэн нэгний тусламж дэмжлэгийг авах шаардлагатай болдог, сонгуулийн хэсгийн санал авах байр хол байдаг, улс төрийн сонгуулийн талаар ойлголт муу, мэдээллийн хүртээмжийн хязгаарлагдмал байдал, нийгмийн оролцооны идэвх сул зэргээс шалтгаалан сонгуульд оролцоогүй болохоо судалгааны явцад илэрхийлсэн байна. Иймд сонгуулийн хэсгийн санал авах байрны хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хүлээж авах ялгаатай байдалд нийцсэн сонгогчдын боловсрол олгох тогтолцоог эргэн харж, мэдэх эрхийг ханган ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцооны идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь зохион байгуулах шаардлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байсан.

**Үр дүн 8.** Оролцогчдын 9.9 хувь нь улс төрийн намын гишүүн, 18.1 хувь нь төрийн бус байгууллага, 11.2 хувь нь сайн дурын бүлэг, эвсэл холбоод, 7.6 хувь нь шашны байгууллагад албан ёсны гишүүнчлэлтэй байна. Эндээс үзэхэд ХБИ хувьд улс төрийн болоод нийгмийн бусад оролцооны институтжилт сул байна гэж дүгнэж болохоор байна.

**Үр дүн 9.** Ахуйн хүрээнд бие даан хийж чаддаг үйлдэл нь нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээс харьцангуй олон байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид ахуйн хүрээнд бие даан хийдэг үйлдлүүдээ дунджаар 4.3, нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээ харьцангуй багаар буюу 3.7 гэж үнэлсэн байна. Энэ нь судалгаанд оролцогчдын хувьд ахуйн хүрээнд зарим үйлдлийг бие даан хийж чаддаг байхад нийгмийн харилцаанд бие даан хийж чаддаг үйлдэл хязгаарлагдмал байгааг харуулж байна.

